УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 10 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	*1-1*
Хуралдааны товч тэмдэглэл:	*2-11*
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	*12-96*

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх	*12-13*
1. Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд */Засгийн газар 2026.08.31-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хоёр дахь хэлэлцүүлэг/***	*13-18*
2. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 7 гишүүн 2026.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх/***	*18-49, 92-94*
3. Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 31 гишүүн 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх/***	*49-89, 94-95*
4. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл */Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***эцсийн хэлэлцүүлэг/***	*89-92, 95-96*

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны "Их хуралдай" танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Х.Баттулга, Э.Болормаа, Г.Ганбаатар, Г.Дамдинням, Т.Доржханд, Ц.Мөнхтуяа, Б.Найдалаа, П.Наранбаяр, Н.Номтойбаяр, Р.Сэддорж, Б.Түвшин, Б.Уянга, О.Цогтгэрэл, Л.Энхнасан;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Гантөмөр;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр, П.Батчимэг, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, С.Лүндэг, М.Сарнай, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Н.Алтанхуяг, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Н.Алтаншагай-06 минут, С.Амарсайхан-2 цаг 58 минут, Ц.Баатархүү-18 минут, М.Бадамсүрэн-52 минут, Э.Бат-Амгалан-01 минут, Б.Батцэцэг-03 минут, Ж.Баярмаа-1 цаг 00 минут, Б.Бейсен-22 минут, Х.Булгантуяа-17 минут, Ш.Бямбасүрэн-02 минут, Ж.Галбадрах-01 минут, С.Ганбаатар-35 минут, Д.Ганбат-02 минут, П.Ганзориг-10 минут, Ц.Даваасүрэн-41 минут, Б.Дэлгэрсайхан-11 минут, Б.Жавхлан-11 минут, Б.Жаргалан-17 минут, Д.Жаргалсайхан-36 минут, Ж.Золжаргал-19 минут, Т.Мөнхсайхан-03 минут, П.Мөнхтулга-13 минут, М.Нарантуяа-Нара-47 минут, Г.Очирбат-04 минут, Л.Оюун-Эрдэнэ-2 цаг 58 минут, Д.Пүрэвдаваа-53 минут, Ц.Сандаг-Очир-02 минут, О.Саранчулуун-10 минут, Х.Тэмүүжин-03 минут, Г.Тэмүүлэн-02 минут, А.Ундраа-06 минут, Ч.Ундрам-08 минут, Н.Учрал-04 минут, Г.Уянгахишиг-03 минут, Д.Цогтбаатар-06 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 10 дугаар сарын 13-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн, Да.Цогтбаатар нарт Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 39 гишүүн 2026.10.07-ны өдөр өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв.

Нэг.Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд */Засгийн газар 2026.08.31-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, А.Энхбат, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал Д.Баярсайхан, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал Ч.Цэвэгдорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

С.Бямбацогт: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 19
Бүгд: 90
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 7 гишүүн 2026.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал, Нийгмийн статистикийн газрын дарга

Ш.Ариунболд, Мэдээллийн технологи, өгөгдлийн инженерчлэлийн газрын дарга Ж.Тэрбиш, Тамгын газрын дарга Б.Лхагва, мөн газрын Захиргаа, хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ш.Оюунгэрэл, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Төмөрхуяг, зөвлөх Ж.Наранпүрэв нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Эрдэнэсамбуу, зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 10 цаг 42 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Бум-Очир, Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ, Б.Хэрлэн, Л.Соронзонболд, Ч.Анар, Д.Энхтүвшин, Ч.Ундрам, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, О.Саранчулуун нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /12:09/

Гурав.Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 31 гишүүн 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Улаанбаатар Дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга М.Доржпалам, мөн компанийн Техник, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Эрдэнэбаяр, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын зөвлөх инженер Р.Батмөнх, Зөвлөх инженер Х.Эрдэнэчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Эрдэнэсамбуу, зөвлөх Б.Нарангэрэл, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, О.Номинчимэг, Б.Бат-Эрдэнэ, Г.Лувсанжамц нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Зөвлөх инженер Х.Эрдэнэчулуун, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын зөвлөх инженер Р.Батмөнх нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 58 минут үргэлжилж, 13 цаг 00 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 04 минутад эхлэв.

Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Г.Хосбаяр, С.Эрдэнэбат, Д.Энхтүвшин, Ч.Ундрам, П.Ганзориг, Л.Соронзонболд, Ц.Баатархүү нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Зөвлөх инженер Х.Эрдэнэчулуун, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын зөвлөх инженер Р.Батмөнх нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, О.Саранчулуун нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /15:24/

Дөрөв.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл */Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, мөн комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т "Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно." гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /15:30/

Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Б.Пүрэвдорж: Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 51
Бүгд: 100
49.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн "дэмжсэн" санал техникийн саатлын улмаас "эсрэг" гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 49
Бүгд: 100
51.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Пүрэвдорж: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 46
Бүгд: 100
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42

Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 43
Бүгд: 100
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 39
Бүгд: 100
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 40
Бүгд: 100
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 39
Бүгд: 100
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 44
Бүгд: 101
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 41
Бүгд: 101
59.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 42
Бүгд: 101
58.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 41
Бүгд: 101
59.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 44
Бүгд: 101
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 42
Бүгд: 101
58.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 42
Бүгд: 101
58.4 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 42
Бүгд: 101
58.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Б.Пүрэвдорж: Дулаан хангамжийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 53
Бүгд: 101
47.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 53
Бүгд: 101
47.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 52
Бүгд: 101
48.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14-т “Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл бариmтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.” гэж заасны дагуу “Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Уг асуудлыг 15 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

<u>Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал</u>

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хууль ёсны” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, “буюу” гэснийг “, эсхүл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 40
Бүгд: 101
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын урилгаар “Барилгын хөөсөнцөр хавтан хөгжүүлэлтийн манлай холбоо” төрийн бус байгууллагын гишүүд болон барилгын дулаалгын материал үйлдвэрлэгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтаншагай нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хорооны ахмадын төлөөлөл, нийслэлийн ерөнхий боловсролын “Оргил” сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 52 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын 2026 оны 10 сарын 15-ны Пүрэв гаргийн чуулганы хуралдаанд ирвэл зохих 126-65 гишүүн буюу 51,6 хувийн ирцтэй байна. Чуулганы нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье.

10 дугаар сарын 13-нд Монгол Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Баттогтохын Чойжилсүрэн нар төржээ. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Баттогтохын Чойжилсүрэн нарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы хуралдаанд ирсэн эртэч гишүүдийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Мөнгөнцогийн Ганхүлэг, Нанзадын Наранбаатар, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Тилеуханы Аубакир нарын гишүүд өглөө 9 цагт ирцэд орсон байна.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцэнэ. Та бүхэндээ танилцуулъя.

1 дүгээрт, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна. Санал хураалттай. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирээрэй. Ирцдээ орсон гишүүд ээ, шууд санал хураалттай шүү.

2 Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа нарын 7 гишүүн өргөн мэдүүлсэн.

3 дугаарт нь, Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг нарын 31 гишүүн өргөн мэдүүлсэн.

4 дүгээрт нь, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлж бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн

холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай нарын 39 гишүүн 2026 оны 10 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Нанзадын Наранбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 09 дүгээр сарын 15, 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд 2026 оны 10 дугаар сарын 6, 7, 8-ны өдрүүдийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, танилцуулгаа боловсруулан Төсвийн байнгын хороонд ирүүлснийг та бүхэнд танилцуулж байна.

1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд төрийн айлчлалын бүрэлдэхүүн болон холбогдох зардлын талаар, мөн Гадаад харилцааны яамны хөрөнгө оруулалтын зардалд Япон Улс дахь Монгол Улсын элчин сайдын яамны байрны асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн, оюутан цэрэг хөтөлбөрийг өргөжүүлэх боломжтой эсэх, Монгол Улсын иргэд хэдэн улсад хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчиж байгаа болон 2027 онд нэмэгдүүлэх боломжтой эсэх, Коп 17 олон улсын бага хурлын үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилт болон Батлан хамгаалах яамны төсөв мөн цахим гадаад паспортын чанарын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Монгол Улсын гадаад харилцааны бодлогын үр дүнг дипломат арга хэмжээ, уулзалт, санамж бичгийн тоогоор бус манай улсад хөрөнгө оруулалт нэмэгдүүлсэн, экспортын хэмжээ, ажлын байрны тоо болон иргэдэд үзүүлсэн бодит

өгөөжөөр хэмждэг үр дүнд суурилсан тогтолцоонд шилжих шаардлагатай, мөн байгалийн хий дамжуулах хоолойн төслийг эрчимжүүлж эрдэс баялгийн болон эрчим хүчний салбарын асуудалд онцгой анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд 2027 оны бэлчээрийн ачааллыг багасгахтай холбоотойгоор тухайн салбарын зорилтот түвшнийг өөрчлөхөөр тусгаснаар бэлчээрийн ачаалал хэдий хэмжээгээр буурахыг тодруулж, малын гоц халдварт болон зоонозын халдварт өвчнийг бууруулахад чиглэсэн эм, бэлдмэлийн санхүүжилт буурч байгаатай холбоотойгоор вакцины хэрэгцээ, хамрагдалт, оношилгоо, хорио цээр, шуурхай арга хэмжээний зардлыг төсөвт бүрэн тусгасан эсэх, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд олгосон зээлийн эргэн төлөлт, хүүгийн дэмжлэгийг төрөөс хариуцах үндэслэлийн талаар, мөн Хөдөө аж ахуйг дэмжих сан, ЖДҮХС болон хүлэмжийн хий, агаарын бохирдлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төслүүдийн хэрэгжилт жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төсвийн бодлогоор дэмжих арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчид жижиг дунд бизнес эрхлэгчид, тариаланчид, ногоочдын бүтээгдэхүүний үнэ өсөлттэй байхад салбарын яам анхаарах, мөн тус салбарыг хөгжүүлэхэд төрөөс олгодог дэмжлэг, урамшуулал, зээлийн хүүгийн татаасны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үр дүнд суурилсан зарцуулалтын тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай гэсэн саналуудыг хэлсэн байна.

3.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, эрт илрүүлгийн үр дүнгийн талаар тодруулж, орон нутгийн эмнэлгүүдийн чадавхыг цаашид хэрхэн бэхжүүлэх мөн ажил олгогч эздийн болон үйлдвэрчний эвлэлийн холбоотой хэлэлцэн тохиролцсон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэх, 2026 оны төсвийн тодотголоор нэмэгдсэн халамжийн тэтгэврийн нэмэгдэл нь 2027 оны төсөвт хэрхэн нөлөөлөх, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн талаар болон хэрэгжих хугацаа, олон жил дамжиж буй төслүүдийн хэрэгжилт удаашрах шалтгаан болон оношилгоо эмчилгээний төвийг бүсийн хэмжээнд биш аймаг бүрд ажиллуулах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн 2027 оны төсвийн төслийг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад өөрчлөх нь зүйтэй бөгөөд ХАБ-ын болон болзошгүй эрсдэлийн зардлыг зохих хэмжээнд төлөвлөх, яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийг сайжруулах, эрт илрүүлгийн үзлэгийг үр дүнд чиглүүлэх, асаргааны тэтгэмжийг нөхцөл байдлаар нь эрэмбэлэх нь зүйтэй талаар, мөн төрөлжсөн ахлах сургууль, ногоон сургууль, боловсролын зээлийн сангийн бодлогыг боловсронгуй болгож ЕБС-ийн анги дүүргэлт, ачаалал өндөр байгаа энэ үед мэдээллийн технологийн танхимыг хүчин чадал сайтай, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглох бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн байна.

4.Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд сургуулиудыг 1 ээлжийн сургалтад шилжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын талаар тодруулж төсвийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг хэрхэн тусгасан, анхан шатын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, хэрэгжилт, төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлого, мөн хөгжлийн бодлогын зорилт шалгуур үзүүлэлт болон төсвийн төлөвлөлтийн уялдаа хангалттай эсэх хөрш орнуудтай хамтран цахилгаан станц байгуулах боломж болон цалин хөлсний өсөлт инфляцад нөлөөлөх нөлөөллийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Мөн түүнчлэн төсөв, хөгжлийн бодлого, шалгуур үзүүлэлт болон тайлагналын тогтолцоог уялдуулан нэгтгэх, төсвийн зохицуулалт, зарцуулалт бүрийг хүрэх үр дүнтэй холбон төлөвлөж хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн эрт илрүүлэг, сэргээн засах тусламж, үйлчилгээний төлөвлөлт, чанар, хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар, мөн төсвийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, тогтмол мэдээлж байх нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн байна.

5.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн алдагдал болон эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд нь төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх, мөн 2027 онд төрийн албан хаагчдын цалин, ахмад настны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж хэрхэн нэмэгдэх, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хэмнэлтийн бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар, төрийн тусгай байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн хангалт болон гоц халдварт өвчний улмаас мал нь устгалд өртсөн малчдад нөхөн олговор олгох эсэх, 2026 оны төсвийн жилд Улсын Их Хурлаар батлагдаагүй төсвийг зарцуулсан эсэх, мөн Малчны тухай хуулийн хэрэгжилтийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн төрийн албан хаагчдын цалинг нэгдсэн бодлогоор шинэчлэх нь зүйтэй бөгөөд төсвийн зарлагын өсөлт нь иргэдийн бодит орлогыг дэмжихгүйгээр инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэйг анхаарах мөн төсвийн тогтвортой байдлын зөвлөл эрсдэлийн үнэлгээ хийхээс гадна бодлогын хувилбар шийдлийн талаар санал боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн байна.

6.Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлэг явуулах үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд 2027 оны төсөвт тусгагдсан төрийн тусгай албан хаагчдын орон тоо, хувцас, хангалтын зардлын тооцоог тодруулж, мөн Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх ажиллагаатай холбоотой гэр бүлийн сэтгэл зүйчийн орон тоог нэмсэн эсэх, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээг таслан зогсооход шаардагдах зардал болон шүүх, прокурорын барилгын хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Мөн шүүх эрх мэдлийн байгууллагын төсвийг гүйцэтгэх засаглалын төсөвтэй зэрэгцүүлэн хэлэлцэх нь зохимжгүй бөгөөд цаашид улсын төсвөөр санхүүжих хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх, хүүхэд, гэр бүлийн шүүх байгуулахыг Улсын Их

Хурал бодлогоор дэмжиж, хуулиа баталсан байтал 2027 онд төсвийн төсөлд уг санхүүжилтийг тусгаагүй байгааг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

7.Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд Эрчим хүч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал өссөн шалтгааныг тодруулж, Оюутолгой компанийн 2027 оны ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлж зарцуулахаар төлөвлөсөн нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, мөн 2027 оны төсвийн төсөлд тусгагдсан зарим урсгал зардал, өсөлтийн тооцоо болон төрийн албан хаагчдын цалин хөлс харилцан адилгүй нэмэгдсэн шалтгааны талаар, мөн эрчим хүчний үнийн өсөлтийг бууруулах татаасыг айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад ялгаатайд тооцсон эсэх, улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний нэр, байршил, зорилго, бэлтгэл хангагдсан байдал, хэрэгжих хугацаа, нийт өртөг, үр дүнгийн шалгуурыг тодорхой болгосноор төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой эсэх, Ази-Номхон далайн хүний эрхийн үндэсний байгууллагуудын сургалтын төвийг Монгол Улсад байгуулах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Мөн аливаа шийдвэрт Үндсэн хуулийн зарчмаа баримтлах, мөн ард түмний амьдрал доройтсон энэ үед Оюутолгойн ногдол ашгийг төсөвт зарцуулахгүй байх, хүүхдийн хоолны агууламж, чанарыг бууруулахгүйгээр төлөвлөж хүний эрхийн мэдрэмжтэй төлөвлөлтийг төлөвшүүлэх, төрийн бүх байгууллага хүний эрхэд суурилсан үйлчилгээгээ хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн.

Төсвийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасныг баримтлан явуулж, дараах танилцуулгыг та бүхэнд танилцуулж байна.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баясгалан, Шижир нар Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг анхаарах нь зүйтэйг сануулж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртөг нэмэгдсэн шалтгааныг болон ТЭЗҮ нь магадлангаар баталгаажаагүй төслүүдийг жагсаалтаас хасах боломжтой эсэх, мөн төрийн тусгай байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн хангалт бэлэн байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар 2027 оны төсвийн орлогын ангилал, тооцоолол, орлого бүрдүүлэлтийн талаар, мөн уул уурхайн бүтээгдэхүүний экспорттой холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг улирал бүр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод тайлагнах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Оюутолгойн ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэх үндэслэл, шийдвэрийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтулга 2027 оны төсөвт хөдөө аж ахуйн салбарын нөлөөлөл, мөн орон нутагт баригдах арьс шир боловсруулах үйлдвэрүүд болон 10 аймагт баригдах дулааны станцын бүтээн байгуулалтын явц, ажилд улсын төсвөөс санхүүжилт олгох эсэх, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2027 оны төсвийн зарлагын өсөлт нь инфляцад хэрхэн нөлөөлөхийг тодруулж, төсвийн алдагдлыг хуримтлалын санд төвлөрүүлэх орлогоор санхүүжүүлж байгаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг төсвийн төсөлд

тусгагдсан төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл нь инфляцад хэрхэн нөлөөлөх, мөн төсөлд тусгагдсан зарим урсгал зардлыг бууруулж, 2027 оны төсвийг алдагдалгүй батлах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан 2027 оны төсвийн зардлын нэмэгдэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг тодруулж, Засгийн газрын өрийн хэмжээ нь төсвийн тусгай шаардлага хангаж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2027 оны төсвийн төсөлд санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргасан эсэх, мөн төсвийн зардал нэмэгдэж байгаатай холбоотойгоор ядуурлыг бууруулах үзүүлэлтүүд өөрчлөгддөг эсэх, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан 2027 онд сургалтын төлбөрийн зээлийн сангийн санхүүжилттэй холбоотой өөрчлөлтүүдийг тодруулж, мөн үйл ажиллагааг нь зогсоосон төсөл хөтөлбөрүүдийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг 2027 оны төсвийн бодлогоор шинээр нэмэгдэх ажлын байрны тоо болон хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүд барих, иргэдэд ипотекийн зээл олгох, Тавантолгойн ДЦС-ын бүтээн байгуулалтын ажлуудад тусгагдсан хөрөнгийн дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан Боловсролын зээлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал нь шийдэгдээгүйгээс оюутнууд, эцэг эхчүүдэд хүндрэлтэй байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг түүхий эдийн үнэ өндөр байгаа боломжийг ашиглан Оюутолгойгоос төвлөрүүлэх орлогоор зээлээ төлөхөд анхаарч, иргэдэд ногдол ашиг хуваарилах хугацааг наашлуулах нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа Улсын Их Хурлаар төсөв хэлэлцүүлэх үе шатыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор иргэд, олон нийтийн саналыг авч төсөлд тусгах, боловсрол, эрүүл мэнд зэрэг томоохон салбаруудын төсвийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Наранбаатар даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын ерөнхий аудитор, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтоолын зөвлөлийн гишүүн, Найдангийн Цэвэлмаа Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Даваасамбуугийн Баярсайхан Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэр хэрэгжилтийн газрын захирал, Машдэлгэрийн Наранжаргал Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

оруулалтын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур хугацаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя. Лувсанжамц гишүүн суучхаарай.

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 78,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 онын төсвийн тухай хуулийн төслүүдийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүллээ.

10.23 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Статистикийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урьж байна.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Ганхүлэг, Мөнхсоёл, Ундраа, Саранчулуун, Сэддорж нарын хамт санаачлан боловсруулаа.

Статистикийн тухай хууль 1997 онд шинэчилсэн найруулгаар батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл мөрдөгдөж байна. Энэ хугацаанд Статистикийн тухай хуулийн 23 зүйлийн 20-д нь 178 нэмэлт, өөрчлөлт орж, хуулийн анхны үзэл баримтлал, зохицуулалтын суурь зарчим ихээхэн өөрчлөгдсөн байна.

Мөн статистикийн үйл ажиллагаатай холбоотой харилцаа 15 хууль, 58 тогтоол шийдвэрээр зохицуулагдаж байгаа нь эрх зүйн орчны системчлэл алдагдаж, өнөөгийн шаардлагыг бүрэн хангах боломж хязгаарлагдсан байна. Өнөөдөр статистикийн мэдээллийн эх үүсвэр нь зөвхөн уламжлалт судалгаа тооллогоор хязгаарлагдахгүй болж, төрийн байгууллагуудын мэдээллийн сан, захиргааны мэдээлэл, их өгөгдөл зэрэг мэдээллийн шинэ эх үүсвэрүүдийг ашиглах, мэдээллийн интеграцийг хийх хэрэгцээ нэмэгдэж байна. Статистикийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэ түвшинд гаргах шаардлагатай байна.

Шинэчилсэн найруулгаар хуулийн бүтэц 6 бүлгээс 7 бүлэг, 23 зүйлээс 31 зүйл болж өргөжнө. Үндэсний статистикийн тогтолцоо, мэдээллийн хэлбэр, эх үүсвэр, өгөгдлийн сан, нууцлал, мэдээллийн аюулгүй байдал, статистикийн мэргэжлийн хараат бус байдал, мэдээллийн чанар, мэдээлэгч болон хэрэглэгчийн эрх үүрэг зэрэг асуудлыг системтэйгээр зохицуулахаар орууллаа.

НҮБ-аас 2016 онд баталсан албан ёсны статистикийн загвар хуульд тусгагдсан байгаа статистикийн мэдээлэл хэрэгцээтэй, хүртээмжтэй байх, мэргэжлийн хараат бус байдлыг хангах, шинжлэх ухааны үндэслэлтэй байх, алдааг илрүүлж залруулдаг байх, эх сурвалжийг оновчтой сонгодог байх нууцлалыг чанд хамгаалах, арга зүй, журмыг ил тод болгох, мэргэжлийн стандарт ёс зүйд үндэслэх, үндэсний зохицуулалт арга зүйн нэгдмэл байдлыг хангах олон талт хамтын ажиллагааг илүү бэхжүүлэх зэрэг нийтлэг зарчимтай нийцүүлж энэхүү хуулийг боловсруулаа.

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нийт 12 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай өмнөх хуулийг хүчингүй болсонд тооцох тухай мөн Статистикийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулсан. Үүнд: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төв банк буюу Монголбанкны тухай, Эрүүл мэндийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Боловсролын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай зэрэг хуулиудад бага зэрэг нэр томьёоллын нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулахаар бэлтгэсэн болно.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, Эрхэм Улсын Их Хурлын дарга аа,

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн гол зорилго нь статистикийн мэдээллийн үйлдвэрлэл, тархаалтын эрх зүйн орчныг шинэчлэхээс гадна Монгол Улсын үндэсний статистикийн тогтолцоог өнөөгийн нийгэм, эдийн засаг, технологийн өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэхэд оршино.

Монгол Улс төрийн бодлого, төлөвлөлт, төсөв, шийдвэр гаргалтаа ямар өгөгдөлд ямар чанартай мэдээлэлд үндэслэн гаргах вэ гэдгийг тодорхойлох суурь эрх зүйн орчин юм.

Монгол Улсын статистикийн тогтолцоо олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцэж, төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтыг чанартай, нарийвчлалтай, хүртээмжтэй статистикийн мэдээллээр хангах эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна.

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнтэй холбогдох хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат танилцуулна. Таныг Индэрт урьж байна.

Г.Очирбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 7 гишүүнээс 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн статистикийн тогтолцоог бүрдүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжил, төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэрийг гаргахад чанартай, нарийвчлалтай, цаг үеийн шаардлагыг хангасан статистикийн мэдээллээр хангаж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын тогтолцоог бэхжүүлэх, статистикийн бие даасан байдал, албан ёсны статистикийн зарчмууд, статистикийн засаглал, мэдээллийн эх үүсвэр, тархалт, ашиглалт, статистикийн үйл ажиллагааны чанарын хяналт, мэдээллийн нууцлал хамгаалах, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор хуулийн төсөлд тусгажээ.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээдийн нэмэлт зардал үүсэхгүй, харин төрийн байгууллагад зардал үүсэхээр байгаа талаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооллын тайланд тусгасан байна.

Уг хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, хуулийн төсөл батлагдсанаар аж ахуйн нэгжүүдээс гаргадаг давхардсан тайлан, мэдээллийг хэрхэн бууруулах, аж ахуйн нэгжээс иргэдийн хувийн мэдээллийг статистикийн зориулалтаар ашиглахдаа уг мэдээллийг хэрхэн хамгаалах талаар, аж ахуйн нэгжүүдэд санаатайгаар худал мэдээлэл хүргүүлсэн бол ямар хариуцлага тооцох, статистикийн мэдээллийг улс төрийн болон бусад зорилгоор өөрчлөн тайлбарласан бол ямар арга хэмжээ авах талаар, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон энэ хуулийн төсөлд заасан мэдээлэл татах эрхүүд нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөх асуудал байгаа эсэх, нотолгоонд суурилсан статистикийн мэдээллийн салбарын бодлоготой уялдуулан зохицуулалт тусгагдсан эсэх, аж ахуйн нэгж, байгууллагууд статистикийн мэдээллийг бизнесийн үйл ажиллагаандаа ашиглах боломжийг бүрдүүлсэн эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар хуулийн төсөлд хувь хүний мэдээлэлтэй холбоотой зохицуулалт тусгагдсантай холбогдуулан

хуулийн төслийг дагалдуулан Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулсан эсэх, үүнтэй холбоотойгоор ямар дүгнэлт гарсан талаар, мөн төрд байгаа иргэний эмзэг болон хувийн мэдээллийг энэ хуулиар хэрхэн хамгаалж байгаа талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Өгөгдлийн тухай хуулийн төслүүдийн уялдаа хэрхэн хангагдаж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар төрд байгаа статистикийн мэдээлэл өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ашиглаж зөв шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Үндэсний статистикийн зөвлөл төрийн байгууллагын төлөөллөөс гадна мэргэжлийн бүрэлдэхүүнийг нэмж оруулах, ҮСХ-ны даргыг Улсын Их Хурлын дарга санал болгож, томилдог байдлыг өөрчлөх, хүн амын амьжиргааны доод түвшнийг тогтоохдоо ҮСХ холбогдох мэргэжлийн байгууллага, субъектүүдээс ирүүлсэн саналд үндэслэн тухай бүр шинэчлэн тогтоодог байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар, мөн баялгийн тэгш бус хуваарилалт, эдийн засгийн өсөлт, төрийн өмч, худалдан авалт зэрэг бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай статистикийн мэдээллийг зохих аргачлалын дагуу гаргадаг байх асуудлаар байр сууриа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэг Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулахдаа Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 60 хувиар, уг хуулийн төсөлд хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Төв банк болон Монголбанкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 56 хувиар, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувиар, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 56 хувиар, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг 60 хувиар, Статистикийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 64 хувиар буюу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг тус тус дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх

хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

С.Бямбацогт: Очирбат гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Батмөнхийн Батдаваа ҮСХ-ны дарга, Дамдинсүрэнгийн Лхамсүрэн ҮСХ-ны дэд дарга, Бямбасүрэнгийн Лхагва Тамгын газрын дарга, Мангалсүрэнгийн Оюунжаргал Эдийн засгийн статистикийн газрын дарга, Шагдарын Ариунболд Нийгмийн статистикийн газрын дарга, Цэнхэрборын Эрдэнэмөнх Мэдээлэл, технологи, өгөгдлийн инженерчлэлийн газрын дарга, Жамбалдоржийн Тэрбиш Нэгдсэн статистикийн газрын Үндэсний тооцооны хэлтсийн дарга, Шаравсангийн Оюунгэрэл Тамгын газрын Захиргаа, хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Бууpаагийн Төмөрхуяг Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Жамлавын Наранпүрэв зөвлөх. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хууль сануулъя. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүй хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчиж, худал мэдээлэл өгсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэн заасныг та бүхэнд танилцуулъя.

Статистик бол Монгол Улсын нийгмийн амьдралыг бодитоор нь хэмжиж үнэлж дүгнэж байх ёстой. Статистикийн үйл ажиллагааны талаар бас иргэдээс тайлангаар гаргаж байгаа тоонууд чинь иргэдийн өдөр тутмын амьдралын чанар 2 чинь маш зөрүүтэй байна. Та бүгдийн гаргаж байгаа тайлан иргэдийн амьдралын чанар 2 зөрүүтэй байна. Үнэн бодитой тайлагнахгүйгээр шүүмжилдэг бараа бүтээгдэхүүний үнэ өсөөд байдаг. Статистикийн инфляц 10 хэдэн хувьтай гэж, 10 хувьтай гэж гардаг. Эдийн засаг өслөө гэдэг иргэдийн амьдралд наалддаггүй. Тайлан дээрх тоо сайхан гараад, иргэдийн бодит амьдрал муу байгаад байж таарахгүй. Энэ юутай холбоотой байна, яагаад ийм байна. Энэ талаараа бас үнэн бодит мэдээллийг та бүхэн сайн өгөөрэй.

Хуулийн шинэчилсэн найруулга хэлэлцэж байгаа. Энэ хуулийг сайжруулж байж, шинэчилж байж иргэдийн амьдрал дээрх үнэлэмж, та бүгдийн гаргаж байгаа тоо 2 адилхан нийцдэг нийцэлтэй байх ёстой. Тийм болохоор та бүхэн бас үнэн зөв бодитой мэдээллээ өгч, дээрээс нь ямар асуудлууд байгааг ний нуугүй ярьж, энэ хуулиудыг бас эцэслэн батлах тал дээр анхаарах ёстой. Их Хурал ч гэсэн төр, засгийн шийдвэр гаргагч гэсэн бас үнэн зөв, бодитой мэдээлэл дээр шийдвэр гаргавал тэр шийдвэр нь үндэслэлтэй, оновчтой, амьдрал дээр үр өгөөж өгч,

хэрэгждэг болно. Бид нар сайн хэмждэг байх ёстой. Сайн хэмжиж чадах юм бол хянаж, удирдаж чадна. Тийм болохоор хэмжих хэмжүүрийг та бүхэн гаргадаг. Эндээс хангалттай сайн мэдээлэл өгөх ёстой шүү гэдгийг бас хэлье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол зайлшгүй шаардлагатай байгаа. 1997 онд баталсан хууль маань одоо 30 дахь жил рүүгээ орж байгаа. Энэ 29 жилийн хугацаанд 20 гаран удаагийн өөрчлөлтүүд орсон. Зүйрлэх юм бол хуучин дээлээ олон нөхсөн. Тийм учраас одоо бид нар яг энэ дээр нийгмийн шинэ тутам, харилцаа шинээр бий болсон үг хэллэг, нэр томьёо, зохицуулалт, хариуцлага, энэ бүх зүйлийг эрх зүйн зөв хэм хэмжээнд нь оруулахын тулд энэ хуулийг шинэчлэн найруулах зайлшгүй шаардлагатай болсон. Одоо 30 жил байтугай, 3 жилийн өмнө байсан технологийн боломж жилээр биш сараар хурдацтай өсөж хөгжиж байгаа. Сүүлийн үед AI буюу бүтээмэл оюун бол төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшний хурдыг хийгээд, уялдааг 70 хүртэлх хувиар үр өгөөжтэй болгох, ингэснээрээ иргэдийн үйлчилгээ авах, төрөөс авах үйлчилгээг бас хялбарчлах ийм боломжтой болсон байгаа юм.

Гэтэл статистик нь зөвхөн тоон мэдээ цуглуулах, нэгтгэн дүгнэх гэсэн шаардлага хангахгүй энэ хуулийн орчин байгаад байгаа учраас үүнийг хурдтайгаар өөрчлөх нь бол зайлшгүй. Тийм ч учраас төрийн байгууллагад байгаа өгөгдлийг статистикийн зорилгоор холбох, албан ёсны статистикийг мэргэжлийн хараат бус гаргах, мэдээлэгчийн нууцлал ба чанарыг хариуцлагыг нь хуульчлах гэдэг энэ агуулгыг бол дэмжиж байгаа.

1 бодитой асуудал байна. Жишээлбэл одоо утаан дээр ярья. Утааны сонсгол хийхэд Улаанбаатар хот 1 өөр бодлоготой, тоо баримттай. Байгаль орчин, уур амьсгалын яам 1 өөр бодлого, стандарттай. Дотоодын болон гадаадын стандарт нь хүртэл өөр. Эрүүл мэндийн яаманд нь тоон мэдээлэл нь бас өөр байдаг. Журмууд нь өөр байдаг. Ерөнхийлөгчийн Тамгын газар дээр болон Хэрэг эрхлэх дээр байгаа мэдээллүүд нь хоорондоо зөрдөг. Утааны улмаас өвчилсөн хүмүүсийн эмнэлгүүд дээр очсон мэдээлэл хийгээд амь насаа алдсан хүмүүсийн шүүх шинжилгээ дээр очсон тоо нь өөр байдаг. Ингээд 1 сэдэв дээр гэхэд 6-7 янзын өөр тоо баримт дунд нэгдсэн дүгнэлт хийж тухайн зүйлийн шалтгаант холбоог хэрхэн шийдэх боломж нь байдаггүй. Тэгэхээр одоо бол зүгээр 1 байгууллагын хууль ч гэдэг юм уу мэдээлэл дүн бүртгэлийг авах, түүнийг цахимжуулах гэдэг хүрээнд энэ асуудлыг бид нар яримааргүй байгаа юм. Бид нар ямар хүрээнд яримаар байгаа вэ гэхээрээ нөгөө их өгөгдлийг хиймэл оюун гэж яриад байгаа тэр бүтээмэл оюуны тэр платформ дээр зөв ашиглагдахуун болгох зайлшгүй шаардлага байгаад байгаа. 3 асуулт байна.

1 дүгээр асуулт. Миний ойлгож байгаагаар ҮАБЗ-өөс үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчилсэн төслийг Засгийн газарт хүргүүлсэн юм байна гэж ойлгож байгаа. Энэ үндэсний аюулгүй байдлын шинээр төсөл нь боловсруулагдаж буй үзэл баримтлалд та энийг нийцүүлж байгаа юу. Энэ статистикийн хуулийн шинэчилсэн найруулгыг. Яагаад гэхлээр одоо статистикийн асуудал гэдэг бол зөвхөн тоо бүртгэл, мэдээллийн асуудал биш. Шууд ба шууд бус

утгаараа үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой болсон. Мэдээллийн аюулгүй байдлаас өгсүүлээд маш олон зүйлийг ярьж болно. Тэгэхээр энэ 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт. Ер нь статистикийн энэ орчил эрх зүйн зохицуулалт дотор энэ хууль батлагдсанаараа та нарын хүлээлтийн хэдэн хувийг нь хангаж байгаа вэ. Энэ хууль батлагдсаны ар дээр хэчнээн хуулиудад бас нэмж өөрчлөлтүүд орох уу. Хэчнээн жишээлбэл дүрэм, журмууд, зохицуулалтууд гаргах вэ. Энэ 2 асуултад хариулж өгнө үү.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн, хууль санаачлагч хариулъя.

А.Ариунзаяа: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Дэмжиж үг хэллээ. Манай статистикийн байгууллага ер нь 1924 оны 11 сарын 11-нд Тоо бүртгэлийн хэлтэс гэж 7 хүний бүрэлдэхүүнтэй анх байгуулагдаж байсан түүхтэй. Түүнээс хойш 1997 онд манай анхны бие даасан хууль маань гарч, одоог хүртэл мөрдөгдөж явж байна. Статистикийн байгууллагын хувьд албан ёсны статистик, захиргааны мэдээлэл гэдгээрээ бол яг энэ судалгаа, тоон мэдээллийн анхдагч өгөгдөл нь бол хуулиараа тогтоогдоод, 6 бүлгийн 859 статистик үзүүлэлтийг тогтмол давтамжтайгаар боловсруулж мэдээлдэг. Мөн түүнчлэн улсын хэмжээнд 2 тооллого, 9 түүвэр судалгааг зохион байгуулдаг ийм зохицуулалттай.

Одоо мөрдөгдөж байгаа хуулийнхаа дагуу ер нь ямар үзүүлэлтээр, ямар судалгаануудыг ямар давтамжтай хийх вэ гэдгийг бол заагаад өгчихсөн байдаг. Тэгэхээр цаг тутамдаа тухайн үедээ үүсэж байгаа нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудаар судалгаа явуулах гэхээр бас тийм боломж нь хязгаарлагдсан юм шиг харагдаад байдаг. Тийм учраас энэ шинэчилсэн найруулгаараа судалгаануудыг нэрчлэн бол заагаагүй. Тэгэхээр энэ нь бол тухай бүр арга зүйн зөвлөлөөрөө, түүнчлэн тухайн жилийнхээ төлөвлөгөөндөө ороод тэгээд судалгаанууд, тооллогууд хийгдээд явагдана.

Утааны асуудлыг та сая хэллээ. Яг үнэн. Ер нь яг энэ утааны харилцан хамаарал нь ямар байсан юм бэ гэдгийг YCX 2015 онд бас ийм нийгмийн судалгааг хийж байсан. Тэгэхэд захиргааны мэдээллүүдээ ашиглаад, хоорондын хамаарал нь ямар байгаа юм бэ. Улаанбаатар хотын хүн ам нь хэрхэн яаж өсөж байгаа юм, гэр хороолол нь яаж өсөж байгаа юм, автомашины тоо яаж өсөж байгаа юм, эргээд өвчлөл ямар байгаа юм, эхийн эндэгдэл, нярайн эндэгдэл зэрэг бүхий л энэ асуудлуудыг бүгдийг нь 1 платформ дээр авчраад, анализ дүгнэлт хийсэн. Тухайн үедээ яг тэр утааны сонсгол дээр ч гэсэн яг тэр судалгаа хэрэг болж, мөн англи хэл дээр ч гэсэн орчуулагдаж нэлээд бас сайн судалгаа болсон. Түүнээс хойш дахиж тэр судалгааг хийгээгүй байгаа.

Захиргааны мэдээллийн эх үүсвэр нь ямар вэг, аль байгууллагын гаргаж байгаа эх үүсвэр вэ, ямар давтамж буюу аль хугацааг нь авч байгаа вэ гэдгээсээ хамаарч байгууллагуудынуудын гаргаж байгаа мэдээллүүд нь хоорондоо зөрдөг. Захиргааны мэдээлэл гэдэг бол тухайн яам, тамгын газар өөрийнхөө эрхлэх хүрээнийхээ асуудлууд дотроо гаргаж байгаа мэдээллүүд нь шүү дээ. Тэгэхээр тэр дотроо нөгөө мэдээллүүд нь зөрж байгаа тохиолдлууд байдаг. Энэ бол гарцаагүй үнэн.

Хүлээлтийн хувьд гэх юм яах вэ, энэ хуультайгаа хамт өргөн барьсан 12 хууль байгаа. Нэн тэргүүнд бол эдгээр хуулиудад бага зэрэг өөрчлөлтүүд орно. Эргээд энэ хууль маань өөрөө батлагдаад яв явах юм бол арга зүйн зөвлөлөөрөө бас аргачлалуудаа яамдууд дээрээ бас ажиллаж, шинэ тутам үүсэж байгаа мэдээллийн эх үүсвэрийг ашиглах ийм аргачлалуудыг баталж ажиллана гэсэн үг. ҮАБЗ-ийн .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гүйцээж хариулъя.

А.Ариунзаяа: ҮАБЗ-ийн яригдаж байгаа хуулийн төслийн талаар яг надад бол бүр тодорхой мэдээлэл бол байхгүй. Гэхдээ мэдээж манай байгууллага чинь 2024 оноос хойш Статистикийн хороо үйл ажиллагаа явуулж байгаа учраас бүхий л асуудлуудад статистикийн байгууллагын оролцоо, мөн түүнчлэн зөвлөмж, оролцоотой явж байдаг. Мэдээллийн нууцлалыг хангах тал дээр манай статистикийн байгууллагын энэ шинэчилсэн найруулга дээр мөн одоо ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн төслүүд дээр бол тухайлсан заалтууд байгаа. Түрүүний миний хэлсэнчлэн статистик өөрөө мэдээллээ цуглуулж авч байгаа нууцлалыг бол манайх хариуцна. Захиргааны мэдээллийг тухайн яамд өөрсдөө мэдээллийн эх үүсвэрийн анхдагч хэрэглэгч учраас тэр мэдээллийн аюулгүй байдлыг тухай бүр яам, тамгын газар өөрсдөө хариуцдаг байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Ариунзаяа гишүүнд баярлалаа. Гол агуулга бол таны ярьж байгаа зүйлүүдийг бид нар энэ танилцуулга дээрээс уншчихаж байгаа. Одоо хэлэлцэх эсэх асуудлыг бид нар ярьж байгаа. Хэлэлцэгдээд явна. Хэлэлцэгдээд явахаар ямар зүйлийг хүсмээр байна вэ гэхээр энэ аюулгүй байдлын үзэл баримтлал зөвхөн нууцын зэрэгтэй хавтсан дээр генералуудын барьж явж байгаа БХЯ, Гадаад яамтай холбоотой төдийхөн бичиг баримт биш бөгөөд энэ нь эргээд 6 тулгуур зарчмаараа Монгол Улсын үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой асуудал. Тэгээд яагаад энийг хэлээд байна гэхээрээ дэлхий нийтийн нөхцөл байдал сүүлийн үеийн жилүүдэд огцом өөрчлөгдөж байгаа. Энэ дээр статистикийн үр нөлөө, уламжлал гэхээсээ илүүтэйгээр шинэ тутам харилцаанд бас мэдээллийн уг сурвалж болох гээд байгаа учраас яг хэлэлцэх явцдаа, ажлын хэсгийн явцдаа бас энэ чиглэл рүү уялдуулсан байдлаар асуултуудыг асууж, саналаа хэлнэ.

Б.Пүрэвдорж: Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Бум-Очир: Өглөөний мэнд хүргэе. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Хэд хэдэн асуултууд байна. Асуултууд бол хуулийн төсөл болоод ерөнхийдөө ҮСХ-той хамаатай асуудлууд байгаа. Та бүхэн бас анхааралтай чагнаж байгаарай. Нэлээд хэдэн асуудал байгаа.

1 дүгээрт энэ анхдагч мэдээлэл цуглуулахад ялангуяа бизнес болоод аж ахуйн нэгжүүд дээр маш их ачаалал ирдэг. Манай төрийн байгууллагууд, агентлагууд, татвар, нийгмийн даатгал, гааль гэх мэтчилний олон байгууллагуудаас ижил төстэй мэдээллийг удаа дараа тухайн байгууллагуудаас авахыг хүсдэг. Нөгөө бизнес эрхлэгчид маань үндсэндээ 1 мэдээллийг олон байгууллага руу давтан явуулах ийм нөхцөл байдлууд үүсдэг нь аж ахуйн нэгжүүд дээр бас ачаалал үүсээд байдаг. Энэ

байдлыг яаж арилгах вэ. Хуулийн төсөл дээр үүнтэй холбоотой зүйлс гарч байгаа юу. Энэ асуудлыг цэгцлэх, аж ахуйн нэгжүүдэд ачаалал багатай байх ямар ямар ажлууд хийгдэж байгаа вэ гэдгийг мэдмээр байна.

Дараагийн 1 зүйл бол юу вэ гэхээр мөн аж ахуйн нэгжүүдтэй холбоотой. Ялангуяа жижиг, дунд бизнес, анхан шатны санхүү, үйл ажиллагааны бүртгэлийн стандартын дагуу хөтлөхгүй явдал гардаг. Ингээд стандартын дагуу хөтлөөгүйгээс болоод статистикийн байгууллагад бол нэлээд их хүндрэл учирдаг, мэдээллийн чанар алдагддаг. Алдаатай гарах ийм магадлал үүсдэг. Тэгэхээр энэ байгууллагууд, аж ахуйн нэгжүүдээ энэ талаар яаж чадавхжуулах ажил хийж байгаа вэ.

Дараагийн 1 зүйл. Түрүүн бас Эрдэнэболд гишүүн хэлээд байна. Энэ төрийн байгууллагууд өгөгдөл солилцох тал дээр хэрхэн ямар ахиц дэвшлүүд гарч байгаа вэ. Нэгэнт мэдээллүүд нь зөрдөг, статистикууд нь зөрдөг. Дээр нь хоорондоо мэдээлэл муу солилцдог, эс үгүй бол шуурхай солилцох цахим систем энэ тэр бий болсон уу гэдэг ийм асуудал байна. Энэ 2 дахь асуудал шүү.

3 дахь асуудал бол юу вэ гэхээр сая бас дурдагдаж байна. Энэ орчин үеийн технологийг нэгд нэвтрүүлэх, 2-т тэдгээрийг хэрэглэх эрх зүйн орчин хэр бүрдсэн бэ. Жишээ нь сая бүтээмэл оюуны тухай асуудал ярьж байна. Түүнчлэн блокчэйн системд уг нь бол бид нар шилжих ёстой шүү дээ. Тэгэхээр үүнд хэзээ шилжих юм бэ. Энэ хууль, эрх зүйн орчин нь бүрэн тодорхой болж байгаа юу гэдэг энэ асуудал бол яг үүнтэй холбоотой блокчэйнийг асууж байгаа зүйл бол нөгөө нууцлал, аюулгүй байдлын тухай асуудал давхар энд явж байгаа юм шүү. Энэ бол 3 дахь асуудал.

4 дэх нь хүний нөөцийн болоод чадавхын тухай асуудал. Ялангуяа сум, дүүргийн түвшинд ажиллаж байгаа статистикийн ажилтнуудын орон тоо цөөн, мэргэшсэн хүмүүс дутмаг байдаг. Цалин урамшуулал бага байдаг. Үүнээс болоод мэдээлэл цуглуулах, анхан шатны мэдээлэл цуглуулахад тодорхой хэмжээгээр саад учрах мэдээллийн чанаргүй байдал бий болгох ийм нөхцөлүүд үүсдэг. Энийг хэрхэн засаж залруулах вэ.

Дараагийн нэг зүйл. Энэ статистикийн тоон мэдээллүүд алдаатай байх тухай асуудал байдаг. Жишээ нь малын тоон дээр бид эргэлзээд байдаг. Энэ 58,1 сая. Яг малын тоогоо жишээ нь зөв бид нар тоолж чадаж байгаа юу. Давхцуулж тоолж байгаа юу. Зөндөө маргаанууд эргэлзээнүүд гардаг.

Дараагийн нэг зүйл жишээ нь, би жишээ болгож хэлж байгаа шүү. Хилийн чанад дахь Монгол иргэдийн асуудал бас яригддаг. Тэрийг хил хамгаалах газар тоолох юм уу, статистикийн байгууллага тоолох юм уу, Гадаад яам тоолох юм уу гээд ингээд өөр өөр адил бус тоонууд ирдэг. Тэгэхээр энэ алдаатай гэх үү, бүрэн тоолж чадахгүй байгаа асуудлуудаа яаж засаж залруулах вэ гэсэн нийтдээ бараг 5 асуулт суучих шиг боллоо. Эдгээр асуудалд хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Нэрээ хэлээд хариулаарай.

Б.Батдаваа: УСХ Батдаваа. Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт бид статистик мэдээлэл болон бусад мэдээллүүдээр аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн ачааллыг яаж бууруулж ажиллаж байгаа вэ гэдэг дээр цахимын багц хуулийн дагуу аж ахуйн нэгж байгууллагуудаас 1 авсан бол дахиж авахгүй гэдэг

зарчмыг баримталж ажиллаж байгаа. Үүний 1 жишээ нь юу вэ гэхээр энэ оны 4 дүгээр сард явуулсан эдийн засгийн тооллого буюу аж ахуйн нэгжийн тооллогоор төрийн 12 байгууллагын, 19 мэдээллийн санг нэгтгээд, төрд байгаа мэдээллийг аж ахуйн нэгжээс дахин давтахгүй, харин НҮБ-ын өмнө бид нарын хүлээсэн үүрэг буюу Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдийг аж ахуйн нэгжээс авч, энэ тооллогыг явуулдаг, судалгааг явуулдаг хэлбэр лүү шилжсэн. Цаашдаа ер нь бол бид статистик мэдээллийг илүү байгаа бэлэн өгөгдөл, захиргааны өгөгдлүүдийг нэгтгэх замаар явуулах ийм төлөвтэй ажиллаж байгаа.

Төрийн мэдээлэл солилцооны хувьд бол энэ цахимын багц хуулийг дагаад статистикийн байгаа хуулиудаар бид бололцоог ашиглаад, төрийн мэдээлэл солилцооны Хур системийг ашиглаад дата интеграци, нэгтгэлийг бол явуулж байгаа. Тухайлбал, хүн амын тооллогыг урьд нь 10 жил тутам давтамжтай явуулдаг байсан бол одоо бид 14 байгууллагын 29 мэдээллийн санг ашиглаад, жил болгон явуулах бололцоог цахим хэлбэрээр явуулах ийм үйл ажиллагаа явуулж байгаа.

Гэхдээ энэ хуулиар бид зарим нэг хуулийн хязгаарлалтаас шалтгаалаад мэдээлэл солилцдоггүй байдлыг бол тодорхой хэмжээгээр бас зохицуулахаар хууль дээр хууль санаачлагчид маань оруулсан байгаа. Технологийн ашиглалтын хувьд бол ҮСХ маань бол уламжлалт хэлбэрээс бүрэн цахимжсан хэлбэр лүү шилжиж байгаа. Үүний хүрээнд бид бол мэдээлэл цуглуулалтаас тархалт хүртэл бүх үзүүлэлтийг, мал тооллогоос бус дээр бол цахим хэлбэрээр явуулдаг болсон. Нэмээд веб скрабын орон зайн мэдээллийн цуглуулалт гээд энэ аргачлалуудыг нэвтрүүлэн ажиллаж байгаа.

Хүний нөөцийн хувьд бол орон нутагт бол хүндрэлтэй байгаа. 1 дүгээрт цалин мөнгөний асуудал яригддаг. 2 дугаарт сум дээр төрийн сангийн мэргэжилтэн статистикийн ажлыг давхар хариуцаж явдаг. Энэ хуулийн тодорхой зохицуулалтуудаар бол энийг шийдвэрлэхийг хууль санаачлагчид маань зорьсон байгаа.

Статистикийн мэдээллийн чанарын тухай асуудлуудыг бол бас их ярьдаг. Энэ хүрээнд бол бид хуулийн шинэчилсэн зохицуулалт дээр чанарын тайланг байнга тайлагнаж, энийг Үндэсний статистикийн зөвлөл болон Улсын Их Хурал дээр бүх үзүүлэлтүүд дээр чанарын тайланг гаргах, чанарын алдаа илрэх юм бол эргээд олон нийтэд мэдээлж, залруулга явуулах зохицуулалтуудыг оруулсан байгаа.

Гадаадад байгаа иргэдийн хувьд бол 1 эх үүсвэр байгаа. Энэ бол ҮСХ-ны хүн амын тооллого. 2025 оны тооллогоор бол 201,4 мянган иргэн гадаад амьдарч байна гэдэг ийм мэдээлэл байгаа. Үндсэн эх үүсвэр бол ХХЕГ тооллогын мэдээллүүд байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Гүйцээгээд 4 номер хариулъя.

Б.Батдаваа: Сүүлийн үед хөгжиж байгаа энэ машин сургалт хиймэл оюун блокчэйний ашиглалтын хувьд бид нар статистикийн байгууллагад нэвтрэлт ямар байна вэ гэхээр бид нар хиймэл оюун ашиглаж статистик мэдээллийг хялбар хүргэх энэ аргачлалуудыг, шийдлүүдийг нэвтрүүлсэн байгаа. Үүний 1 нь болохоороо манай статистикийн нэгдсэн мэдээллийн сан дээр хиймэл оюуны чатбот ажиллаад, хэрэглэгчид асуултаа авч хариулах ийм систем нэвтрүүлсэн. Нэмээд бид нөатус-ын

систем дээр нэвтэрсэн байдаг 2 сая гаруй кодлогдоогүй бараа бүтээгдэхүүний машин сургалтын аргаар кодлох аргачлалыг Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтраад хэрэгжүүлсэн.

Нэмээд бид хүн амын тооллого болон бусад энэ үзүүлэлтүүдээ уялдаагүй үзүүлэлтүүд буюу алдаа гарч буй захиргааны мэдээллүүдээ гаргах үзүүлэлтийг хиймэл оюун машин сургалтаар олох ийм туршилтын аргуудыг нэвтрүүлж байна. Нэмээд бас бусад тооллогууд дээр видео дүрснээс шууд тоолох гэх мэт ийм .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Одоо би үг хэлэх ёстой. Ийшээ микрофонд хурууны хээ хийсэн учраас болохгүй байна. Ерөнхий сайдыг бас хүлээж байхыг бол хүсэж байна. Яагаад гэвэл энэ Оюутолгойгоос орж ирэх энэ ногдол ашигтай холбоотой хэрхэн яаж зарцуулах талаар бас санал асуулга явуулсан. Яг энэ талаар үг хэлнэ. Та хүлээж байгаарай. Би өөрийнхөө хувийн байр суурь илэрхийлэх учраас өөрийнхөө суудал дээрээс үг хэлнэ.

Өнгөрсөн 3 удаагийн сонгуулиар Их Хурлын гишүүн болж, 10 жилийн туршид сөрөг хүчнийхээ үүргийг биелүүлсэн. МАН өнгөрсөн хугацаанд маш их хулгай хийсэн. Энэ бүхнийг олон нийтэд илрүүлж, хэлж, сөрөг хүчнийхээ үүргийг хийж байсныг бүгд мэднэ. Тэгэхээр энэ эх орноо тонон дээрэмдсэн энэ их хулгай ямар түвшинд явсныг Монголын ард түмэн мэдэж байгаа. Гэвч сүүлийн үед эрх баригч нар гадаадын тонуулчидтай нийлж Монголынхоо баялгийг тонож байна. Энэ бол тэр хулгай бүр дээд шатад гараад бүр макучи зиндаанд очлоо. Үүний 1 жишээ бол 2016 оны сонгууль, 2020 оны сонгууль, 2024 оны сонгуулиар МАН-д зөвлөгөө өгсөн Солонгосын компани. Энэ 10 аймаг дахь дулааны станцын тендерийг авсан юм байгаа юм. Тэгээд энэ тендерээ хийхгүй зугтаагаад алга болчихсон. Одоо тэр оруулж ирсэн төмөр нь 2 жилийн дараа гэхэд хогийн хаягдал, хог болж хувирах ийм юмыг хийчихсэн. Энийгээ энэ 2027 оны сонгууль, 2028 оны сонгууль дээр маш их тийм ноцтой, сонгуульд нь хохирол учруулах учраас өнөөдөр энэ Оюутолгойн ногдол ашгаар энэ дулааны станцуудыг санхүүжүүлж, ашиглалтад оруулах тухай ярьж байгаа юм.

Монголын ард түмэнд очих ёстой энэ хөрөнгө энэ хулгайч нарын гадаад, дотоодынхондоо нийлсэн хулгайч нарын луйврыг нөхдөг ийм хэрэгсэл болж болохгүй. Тэгэхээр Ерөнхий сайдын энэ санаачилж байгаа юунд хөрөнгө оруулалт хийх вэ гэдэг энэ санаачилгыг би бас эсэргүүцээд байгаа юм. Өөрөөр хэлбэл 20 дугаар зуунд, 21 дүгээр зуунд Монголын тусгаар тогтнолыг баталгаажуулахад энэ өнөөдрийн хөгжлийн үндэс суурийг тавихад хувь нэмэр оруулсан тэр ахмадын асуудлыг эн тэргүүнд шийдэх ёстой. Ер нь бол ойролцоогоор 10 их наяд төгрөгөөр үе шаттайгаар 3 он дамжуулаад, 10 их наяд төгрөгөөрөө санхүүжүүлчих юм бол нийгмийн даатгалын сан асуудалгүй болж, энэ ахмадын тэтгэврийг юун 1 сая 500 мянга тэрнээс дээш болгох, тэтгэврийн зөрүү арилгах ийм боломжийг бий болгох юм. Дээрээс нь нийгмийн даатгалын санд ордог мөнгө зөвхөн тэтгэвэртээ зарцуулагддаг. Тэндээс хулгайлах боломж байхгүй. Ийм учраас энэ Оюутолгойгоос орж ирж байгаа энэ ногдол ашгийг нийгмийн даатгалын санд хуваарилах, ахмадуудынхаа асуудлыг шийдвэрлэх ийм шаардлагатай гэж би үзэж байгаа.

Ер нь бол залуу халуун насан дээрээ байгаа, хөл гартай тэр залуучууд хөдөлмөрлөж, ажил, хөдөлмөр эрхэлж байж энэ амьдрал ахуйгаа авч явах ёстой.

Нийгмийн халамж хүсээд суугаад байх ёсгүй. Тийм учраас энэ ахмадын асуудлыг эхний ээлжид шийдэх зорилгоор энэ 3 их наяд төгрөгийг нийгмийн даатгалын санд хуваарилж, ахмадуудынхаа тэтгэврийг нэмэх, тэтгэврийн зөрүүг арилгах ийм зайлшгүй шаардлагатай байгаа шүү. Энэ дээр анхааараарай гэж хэлмээр байна.

Одоо Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэхийг бол зарчмын хувьд дэмжиж байна. Би тэгээд хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Өмнөх хуулийг бодвол ямар шинэлэг гэдэг юм уу зохицуулалтууд орсон бэ. Ер нь зүгээр хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ шаардлага юунд байв. Энийг бас иргэд олон нийтэд бас хэлж өгөөч.

2 дугаарт энэ статистикийн мэдээллийг хэрэглэх, хэрэглээнд оруулах эдийн засгийн төлөвлөлт энэ зөвхөн төр талдаа биш хувийн хэвшил ч гэсэн статистикийн бодит мэдээлэл дээр тулгуурлаж зах зээлийнхээ дүн шинжилгээг хийх ийм зүйл байж байгаа. Тэгэхээр энийг нөгөө өгөгдөл болгон ашиглах буюу энэ чиглэлдээ ер нь ямар зохицуулалтууд буюу хэрэглэгчийн эрх өнцөг талаас нь ямар зохицуулалтууд, ямар боломжууд орж байгаа вэ. Энийг бас тайлбарлаж өгөөч.

2 дугаарт Монгол Улс бас маш олон гэрээ конвенцуудаар нэгдэж ордог. Үүний тайланг хамгаалах энэ асуудал дээр манайх бас арга зүйн талаасаа жоохон учир дутагдалтай байдаг. Олон улсын байгууллагууд юу вэ гэхээрээ тоон мэдээллээр л энийгээ тайлагнаач, маш товчхон. Тоо нь гарч өгдөггүй. Тэгээд энэ статистикийн арга зүй талдаа байдаг юм уу, ер нь төрд цуглуулж байгаа энэ захиргааны мэдээлэл, статистикийн мэдээллүүдийн арга зүй байдаг юм уу, ерөөсөө л 1 оновчтой гарч өгдөггүй. Тэгэхээр бид хэд цаашдаа энэ статистикийн арга зүйд нийцүүлээд олон улс болон ер нь иргэдэд хэрэгтэй, хувийн хэвшилд хэрэгтэй тэр дата, өгөгдлийг гаргахад төрийн байгууллагуудтайгаа яаж хэрхэн уялдаж ажиллахаар энэ статистикийн хуульд бас орж байгаа вэ.

Засгийн газраас бас Өгөгдлийн хууль өргөн барьсан. Үүнтэйгээ бол нийцэх ёстой. Төр байж байж давхар давхар ажил хийж болохгүй. Ямрыг нь бас статистикийн байгууллага шууд татаж авах, ямрыг нь статистикийн байгууллага олон нийтэд өгөгдөл хэлбэрээр ашиглуулах гэдгээ бас ийм зохистой уялдааны асуудлууд эндээс бас шаардлагатай байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас хууль санаачлагч юу гэж бодож байна.

Би зүгээр хууль зүйн салбарын 1 жишээг авъя. Хууль зүйн салбар дээр жишээ нь шүүх эрх мэдлийн байгууллага буюу шүүхийн статистик тусдаа гарчихдаг. Цаг хугацааны хувьд ч тэр. Прокурорын байгууллага нь тусдаа гарчихдаг. Ингээд манай цагдаа, хууль сахиулах байгууллагуудын статистик тусдаа гараад, ер нь аль тоогоо барьж явах асуудал жишээ нь бас цаасан суурьтай байхад хэцүү байдаг юм. Тэгэхээр иймэрхүү зүгээр цаг хугацааны зөрүүтэй байдлаас шалтгаалж статистикийн үнэн бодит ч гэдэг юм уу, эргээд олон нийтийг эргэлзүүлдэг ийм зүйлүүд байдаг. Тэгэхээр ер нь ийм байгууллагуудын статистиктай холбогддог байгууллагуудын үйл ажиллагааг хэрхэн яаж уялдуулахаар бас энэ дээр орж байгаа вэ гэсэн асуултуудыг асууя.

Б.Пүрэвдорж: Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Сайнзориг гишүүнд баярлалаа. Ер нь бол би түрүүн хуулийн төслийн танилцуулгадаа хэлсэн. Манай шинэ тутам үүсэж байгаа мэдээллийн эх үүсвэрийг бас ашиглах хэрэгтэй гэж. Тэгэхээр энэ дотроо жишээлбэл и-баримт, НӨАТ-ын мэдээллийг ашиглаж, хэрэглээний үнийн индексийг тооцдог байвал маш сайн. Бид нар бол яг одоо 7 хоногийн 3 дахь өдөр болгон тогтсон цэг дээрээ манай тоологчид очиж өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний сагстай холбоотой бүхий л мэдээллүүдийг бас авдаг шүү дээ. Тэгэхээр гэх мэтчилэн шинэ тутам үүсэж байгаа энэ мэдээллүүдийг төр бол өөрөө ашиглах хэрэгтэй.

Байгууллагууд хоорондоо мэдээллүүдээ солилцдоггүй. Яагаад гэхлээр тухайн байгууллага бүр өөрөө бас байгууллагын нууцыг мөрдөх ёстой шүү дээ. И-Монгол хөтөлбөрийг манай Учрал Ерөнхий сайд бас цахимын сайд байсан шүү дээ. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд байхдаа бас яг энэ И-Монголыг Эстонитой адилхан тэр зарчмаар Монгол Улсдаа нэвтрүүлсэн эхлэл нь бол тавигдаад, нэлээд олон жил боллоо. Гэхдээ одоог хүртэл энэ маань бас сайн жигдэрч өгөхгүй байгаа нь тухайн байгууллага бүр дээр энэ цахимжилтын ажил, түүнтэй холбоотой төсөв хөрөнгө тавигдахгүй байгаатай холбоотой. Байгууллага бүр өөрөө уг нь яг энэ техникийн, IT-ийн чиглэлийн хүмүүстэй байгаад, өөрсдийнхөө мэдээлэл, мэдээллийн бааз, эх үүсвэрээ сайжруулах ийм албатай байж эхэлсэн байдаг. Гэхдээ эргээд нөгөө И-Монгол академи байгуулсантай холбоотой бүхий л тэр бүтцүүдийг татан буулгачихсан. Тэгээд 1 талдаа цахимжих гээд байдаг. Мэдээллээ хоорондоо солилцох гээд байдаг. Хур системийг бий болгочихсон байдаг. Дан системийг нь оруулчихсан. Хурдан тухайн байгууллагууд хоорондоо мэдээллээ солилцоно гэдэг бодлого нь цаасан дээр байвч нөгөө талдаа байгууллагуудын ажиллах орчныг нь бид нар бүрдүүлж чадаагүй байна. Тэгэхээр яах вэ, манай хуультай шууд болон шууд бусаар бол яг энэ мэдээллийн чанар, аюулгүй байдал, мэдээллийг хоорондоо солилцох тал дээр нь нэлээд сайн, дажгүй сайжруулалтууд орж ирэх байх гэсэн ийм хүлээлттэй байна.

Гэрээ конвенцод дэгдсэн асуудлын талаар мэдээж олон улсын байгууллагууд өөрсдөө бас тухайн аргачлал дээр нь хамтарч ажилладаг. Тухайлбал, тогтвортой хөгжлийн зорилгууд дээр гэдэг ч юм уу. Тэгэхээр мэдээллийн эх үүсвэрүүдийг бий болгоход бас л дахиад л нөгөө хөрөнгө, санхүү шаардлагатай байдаг учраас энэ дээр ч гэсэн бид нар анхаарах ёстой. Шүүх, прокурор дээр жишээлбэл, Тэмүжин сайд байхдаа шиг санаж байна. Бүхий л шүүхийн эцсийн шийдвэрийн мэдээллийн системийг прокурорын байгууллага хариуцна гээд уг нь тухайн үед бодлого гарсан. Тэгтэл одоо мэдээллээ солилцож бас чадахгүй байгаа учраас энэ мэдээлэл маань эцэслэж өгөхгүй байгаа ийм дутагдлын асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр мэдээлэл ашиглах тал дээр хуулийн 16.6 дээр бас байгаа. Тухайн анхдагч өгөгдлийг хувь хүн хуулийн этгээдийг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд 1997 онд баталсан хуулийг үзэл баримтлалын түвшинд дахин тодорхойлж, ялангуяа олон улсын сайн жишгийг тусгаж оруулж ирж байгаа дээр дэмжиж байгаа. Хэд хэдэн асуултууд байна. Хуулийн төслийн 4.2 дээр статистикийн зорилгоор энэ хуульд заасан мэдээлэл

гаргуулах, мэдээллийн сан, өгөгдөлд хандах, ашиглах, мэдээлэл татах ажиллагаанд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Байгууллагын нууцын тухай хуульд заасан зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд уг ажиллагаа нь зөвхөн энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан зорилго, хамгаалалтын нөхцөл, хандалтын бүртгэл, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагын хүрээнд хэрэгжинэ гэсэн хуулийн төсөл дээр ийм заалт байна л даа. Тэгээд бид нар чинь уг нь Үндсэн хуульдаа иргэний хувийн нууцыг халдашгүй байдлаар хуулиар хамгаална гээд заачихсан байгаа юм.

2 дугаарт Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуульд хуульд заасан үндэслэлээр эзний зөвшөөрлөөр статистикийн мэдээллээ цуглуулах бол эзний зөвшөөрөл авах, мэдээллийн эзэн татгалзах эрхтэй байх зэргээр Үндсэн хуулийн заалтуудыг ингээд бэхжүүлээд өгчихсөн байгаа юм. Энийг юу гэж ойлгох вэ гэдгийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт хуулийн төслийн 4.3 дээр хүн, хуулийн этгээдээс албан ёсны статистикийн мэдээллийг нэмэх, хасах, өөрчлөх, хувиргах, жишин харьцуулах зэргээр анхдагч агуулгаас өөрөөр албан бус статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтлэх харилцаанд энэ хууль үйлчлэхгүй гээд заачихсан. Асуулт нь юу вэ гэхээр хувь этгээд статистикийн үйл ажиллагаа эрхлэхэд энэ хууль үйлчлэх үү гэдэг асуулт байна. Тэгээд энэ салаа утгаар ойлгогдоод байгаа юм биш биз дээ. Тэгэхээр хуулийн төсөлд заасан статистикийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал зэрэг нь хувиараа статистик мэдээллийн ажил эрхлэхэд нийтлэг үйлчлэх боломжтой гэж үзэхээр юм шиг харагдаад байгаа. Тэгээд энийг юу гэж тайлбарлах вэ гэдгийг асууя.

Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн албан хаагчдын дунд үүссэн цалингийн ялгаатай байдлыг арилгах дээр чиглэл барьж ажиллаж байгаа. Та бас өөрөө сайд байхдаа энэ тал дээр их дуугардаг байсан. Тэгээд хуулийн төслийн 22.3 дээр статистикийн байгууллагын ажилтны албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал олгох журам, цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал тогтооно гээд оруулаад ирсэн. Тэгэхээр энэ өөрөө ялангуяа статистикийн байгууллагын ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшуулал олгох журам, цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал тогтоохоор заасан байгаа нь өөрөө таны тухайн үед андуураагүй бол тэр зарчимтай сөргөлдөх юм биш үү. Энийгээ эргэн хараад, Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг зохицуулалтаар явах нь зүйтэй биш үү гэдэг асуулт байна. Тэгээд төгсгөлд нь хуулийн төслийн 8.11 дээр албан ёсны статистикийн дунд хугацааны хөтөлбөрийг Улсын Их Хурал батлахаар 7.4-д нь заасан байтал 8.11 дээр зөвлөл батална гээд оруулаад ирчихсэн байна. Энэ яг аль нь батлах юм бэ гэдгийг асуумаар байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Аюушийн Ариунзаяа гишүүн хариулна.

А.Ариунзаяа: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. Тухайн иргэнээс мэдээллийг төр авч байгаа, угаасаа тогтмол авдаг мэдээллийг Хурдан системээр төр хоорондоо мэдээллүүдийг солилцоод байгаа шүү дээ. Тэгэхээр тэр болгондоо мэдэгдэл очиж, зөвшөөрөл авах гэдэг тийм үл ойлголцол 1 хэсэг яваад, тэгээд хүмүүс өглөө болгон миний амьд эсэхийг шалгадаг нийгмийн даатгалынханд баярлалаа гээд тийм юм яваад байсан шүү дээ. Санаж байна уу. Тэгэхээр тэр

асуудлыг л ер нь зохицуулж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Яагаад гэхээр төр угаасаа хүний тухайн мэдээллүүдийг угаасаа л авч байгаа шүү дээ. Угаасаа байгаа байхгүй юу. Төр өөрөө энэ мэдээллийг ашиглаж байгаа. Тэгэхээр тэр мэдээллээ хоорондоо солилцох, бүр тэр байгууллага таны мэдээллийг статистикийн зорилгоороо ашиглаж байгаа гэдгийг заавал тухай бүр мэдэгдэх шаардлага байхгүй гэдгийг хэлж байгаа юм. Яагаад гэхээр үнэхээрийн л НДЕГ-тай манайх чинь мэдээллүүдээс солилцдог. Эрүүл мэндийн байгууллагатай ч солилцдог. Тухай бүрдээ мэдээллийн солилцоо үүсэж байгаа учраас аль болох энийг түүвэр судалгаагаар биш, аль болох тооллогоор биш, аль болох захиргааны мэдээллүүдийг ашиглая гэдэг ийм үндсэн концепц явж байгаа учраас тухай бүрээ тухайн хүнээс мэдээллийг чинь ашиглаж байна шүү гэдэг зөвшөөрөл авна гэдэг агуулгаар нь явах юм бол энэ чинь маш их хүндрэлтэй болно шүү дээ. Тэгэхээр одоо байгаа зарчмаа л ер нь концепцынх нь хувьд оруулж ирж байна гэсэн үг.

Цалин хөлсний талд та хэллээ. Би хэлдэг. Цалин хөлсний бодлого нэгдмэл байх ёстой. Яг одоо цалин хөлсний бодлого нэгдмэл бус байна. Статистикийн байгууллага өөрөө Улсын Их Хурлын харьяа байгууллага. Улсын Их Хурлын харьяа 8 байгууллага байгаа. Аудит байна, СЕХ байна, ХЭҮК байна. Манай статистик байна. Хэд хэдэн Улсын Их Хурлын харьяа байгууллагууд байгаа. Тэгэхээр энэ дотроо жишээлбэл зөвхөн аудиттай манай статистикийн байгууллагыг харьцуулахад статистикийнхан орон нутагт 1,6 сая төгрөгийн цалинтай байхад аудитынхан 2,3 сая төгрөгийн цалинтай байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө буруу юм. Улсын Их Хурлын харьяа байгууллагууд ижил тэгш байх ёстой. Ажлын ачаалал нь ямар байгаа юм гэдгийгээ харах ёстой. Тэгэхээр 1 байгууллагынх нь цалин хөлсийг нь эндээ шийдчихээд, нөгөө байгууллагаа алаг үзэж болохгүй байхгүй юу. Тэгэхээр энийг л адил түвшинд Улсын Их Хурал авч үзнэ гэж бусад Улсын Их Хурлын харьяа байгууллагуудтай гээд байгаа шүү дээ. Улсын Их Хурлын байгууллага, Улсын Их Хурал өөрийнхөө Улсын Их Хурлын Тамгын газрын цалинг ч гэсэн тогтоодог байхгүй юу. Тэгэхээр Улсын Их Хурлын харьяа байгууллага юм бол Улсын Их Хурал хүүхдүүддээ ижил тэгш хандах ёстой гэдэг л ийм концепцын өөрчлөлт байгаа юм. Тэгэхээр хэрэвзээ Засгийн газар энийгээ шийднэ гэвэл бүхий л бусад байгууллагуудаар тогтоож байгаа бүх асуудлуудыг нэгдсэн байдлаар 1 хуулиар зохицуул. Тэр нь тусдаа явдгаараа явах ёстой гэсэн байр суурь маань хэвээрээ байгаа гэдгийг хэлье.

Сүүлийн асуултад манай Батдаваа дарга хариулаад өгчих үү. Нөгөө зөвлөлтэй .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Батдаваа: ҮСХ Батдаваа. Гишүүний асуултад хариулъя. Энэ шинэчилсэн найруулга дээр ер нь гол концепцын өөрчлөлтийн 1 нь бол юу байгаа. Энэ статистик гаргана гэдэг маань өөрөө зөвхөн ҮСХ биш, тухайн улсын бусад төрийн байгууллагуудын юу байдаг. Тэгээд энэ нэгдсэн Зөвлөл нь батлахаар бид нар анх төлөвлөсөн байгаа.

Б.Пүрэвдорж: Батмөнхийн Батдаваа Статистикийн газрын дарга. Уг нь байгууллагаа их сүрхий удирдаад аятайхан яваад байгаа юм. Би мэдээд байгаа юм. Тэгэхдээ 1 л жижигхэн алдаа байгаа шүү. Өөрөөр хэлбэл инфляцыг тогтоохдоо бас жоохон Засгийн газрын нөлөөнд ороод байгаа юм уу, яагаад байгаа юм. Жоохон

дараад байгаа ийм тал байгаад байгаа шүү. Тэр дээрээ анхааараарай. Бат-Эрдэнэ гишүүн нэмж тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Хялбарчлах гээд байгаа гэдгийг аягүй сайн ойлгож байгаа Ариунзаяа гишүүн ээ. Тэгээд бид нар Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Үндсэн хууль гээд энэ заавал тухайн эзнийх нь зөвшөөрлөөр статистикийн мэдээлэл цуглуулах бол эзний зөвшөөрөл авах, мэдээллийн эзэн нь татгалзах эрх гээд ингээд юмнууд байгаад байна л даа. Тэгээд эсвэл нөгөө хуулиа өөрчлөх юм уу. Одоо хэдүүлээ хялбарчлах гэж байгаа юм чинь Статистикийн хуулиа дагуулаад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиа оруулж ирээд өөрчлөх юм уу, яах юм. Энийг яг ялгаж салгаж бас зарчмынх нь хувиар хараасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарх нь тэр Монгол Улс уг нь нэгдмэл улс шүү дээ. Тэгээд аудит өндөр цалин аваад байна. Статистик бага аваад байна гээд, тэгээд өөрсдөө энэ тусгайлсан энэ хуулиудаараа итгэлцүүр оруулж ирээд цалин өөрчлөөд байхаар манай байгаль орчныхон цаг уурын хууль оруулж ирээд, 5 жилийн нэмэгдлээ авъя, цалингаа нэмүүлье гээд байгаа байхгүй юу. Жишээлэх юм бол тэгээд нөгөөдүүл нь өндөр аваад байгаа та нар бага аваад байна гээд яриад байхад бас их .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Чинбаатарын Анар гишүүн алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн алга байна. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Хэрлэн: Тэгэхээр төрийн бодлого, шийдвэрийн үндэслэл болдог статистик мэдээллийг бэлтгэдэг энэ салбарынхныг энэ салбараа бас бэхжүүлэхэд чиглэсэн ийм хуулийн төсөл оруулж ирж байгааг зарчмын хувьд дэмжиж байна.Надад 3 асуулт байна.

Нэгдүгээрх нь энэ статистикийн байгууллагын ажилтан, төрийн захиргааны албан тушаалтан байна гэж энэ хуулийн төсөлд заасан байна.

2 дугаарт нь статистикийн байгууллагын ажилтны албан тушаалын цалин хөлс, урамшууллыг Улсын Их Хурлаас тогтооно гэсэн байна.

Тэгэхээр энэ 2 санаа өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн албаны тухай хуультай нийцэж байна уу. Төрийн албаны ангиллыг Төрийн албаны хуулиар тогтоодог. Бас цалин хөлсний асуудлыг бас Төрийн албаны хуулиар ерөнхийдөө шийдвэрлэдэг. Өнөөдөр төрийн тусгай болоод улс төрийн өндөр албан тушаалтны цалинг Улсын Их Хурлаас тогтоож байгаа. Энэ хуулиар болоод ирэхээр статистикийн байгууллагын ажилтны бүх цалинг бол Улсын Их Хурлаас тогтооно гээд ороод ирчхэж. 1 дүгээр асуулт энэ.

2 дугаар асуулт. Энэ бол энэ танхимд сууж байгаа 126 улс төрчдөд бүгдэд нь хамааралтай асуудал байгаа. Тэгэхээр энэ статистикийн мэдээллийг улс төрийн зорилго, агуулгаар боловсруулах, тархаахыг, түүнчлэн статистикийн үйл ажиллагаа эрхлэх, мэдээлэл тархаахыг хориглоно гэсэн 29-д ийм заалт орж ирсэн байгаа. Тэгэхээр олон намын тогтолцоотой, парламентын засаглалтай улс орны хувьд энэ статистикийн үйл ажиллагаа эрхлэхийг нь хориглох, статистикийн мэдээллийг улс

төрийн зорилго агуулгаар боловсруулах, тархаахыг хориглох энэ заалт ер нь хэр нийцэж байгаа вэ гэдгийг асууя.

Энэ дээр бас ийм байгаад байгаа юм. 21.2-т нь статистикийн мэдээлэл, түүний тоон болон бусад агуулгыг урьдчилан нотлох, батлах зорилгоор статистикийн мэдээлэл боловсруулахыг хориглоно гэж байгаа юм. Тэгэхээр судалгаа, шинжилгээний байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулийн багш, оюутнууд энэ статистикийн мэдээллүүдийг янз янзын таамаг дэвшүүлээд, тэрийгээ нотлох зорилгоор ашигладаг л даа. Энэ нь эргээд нь хориотой болоод явчих уу. Ер нь энэ статистикийн мэдээллийг эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулахад энэ заалт бас хязгаарлалтыг тавьж байгаа юм биш байгаа даа гэж. Энийг нэг тодруулна уу.

3 дахь нь энэ хуулиар статистикийн улсын байцаагч маш их хэмжээний эрх олгогдож байгаа. Статистикийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавиад, хэрвээ зөрчсөн бол зөрчлийн хуулиар шийтгэл ноогдуулах эрхийг энэ хүнд олгож байгаа. Тэгэхээр ямар хугацаагаар энэ байцаагчийг томилох вэ. Байцаагчийн хяналт, шалгалт нь бодитой эсэхийг ямар бүтэц, зохион байгуулалтаар хянаж, нягтлах вэ. Хэрэв байцаагчийн тавьсан шаардлага, шалгалтын дүн, илрүүлсэн зөрчлийг үндэслэлгүй гэж үзвэл хаана, хэнд хандаж эрхээ хамгаалуулах вэ. Хэнд хандаж гомдлоо гаргах вэ гэдэг асуудал бас энэ хуулийн төсөлд дутуу байна гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ 3 бүлэг асуултад хариулна уу.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Манай статистикийнхан бас нэмэлтээр хариулчихна биз. Цалин хөлсний асуудал бол Улсын Их Хурлын харьяа байгууллагын цалин хөлсийг Улсын Их Хурал одоогоороо тогтоож байгаа. Тэгэхээр энэ дотроо ямар нэгэн юу гэдэг юм нэгдмэл бодлоготой байх ёстой, Төрийн албаны тухай хуульд нийцүүлэх ёстой гэвэл Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг одоо Засгийн газар боловсруулж байгаа юм билээ. Ер нь л аль нэг байдлаар төрийн байгууллагууд ажлын ачаалалтай нэг нь бага цалинтай байж эсхүл байршлаасаа хамаарч, хаана ажиллаж байна вэ гэдгээсээ хамаарч өөр өөр цалин, зэрэг дэвтэй байж болохгүй шүү дээ. Тэгэхээр энийг нэгдсэн байдлаар тогтоох ёстой. Хуулийн хувьд одоо ч гэсэн статистикийн байгууллагын зэрэг дэвийг тогтоож байгаа. Энэ дотроо орон нутаг нь орхигдсон байсан. Энийг бол системээр нь нэмэлтээр оруулж ирж байгаагаараа онцлог байна. Тэгэхээр энэ дээр ер нь Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчдын эрх зүйн байдлыг нэгдсэн томоор харах ёстой. ТАЗ-ийг ч гэсэн энэ асуудал дээр дорвитойхон ажиллаач ээ, дуу хоолойгоо хүргээч ээ гэдэг асуудлыг би бас тогтмол хэлж явдаг.

Улсын байцаагчийн хувьд өмнө нь ч хэрэгжиж байсан, одоо ч гэсэн байгаа. Тухайн мэдээллийн чанар болоод мэдээлэл өгч байгаа байдал, тухайн захиргааны байгууллагуудын, жишээлбэл бид нар энэ асуудлыг ярина шүү дээ. Захиргааны мэдээлэл нь өөрөө буруу байна уу, зөв байна уу, тэрийг зассан байна уу, нуун дарагдуулсан байна уу гэдгийг шалгаж явж байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө Зөрчлийн тухай хууль дээр ч одоогоороо байгаа. Мөн түүнчлэн одоогийн хэрэгжиж байгаа хуулиараа ч гэсэн улсын байцаагч бол байх ёстой. Эрхийг нь бол манай УСХ-ны дарга өөрөө тогтоож өгдөг байгаа. Тэгэхээр энэ дээрээ алдаатай байна уу, үгүй байна уу, яагаад ийм тогтмол алдаа гараад байна вэ гэдэг дээр арга зүйн зөвлөл ч

гэсэн ажилладаг. Тухайн байцаагч нь өөрөө буруу акт тогтоосон байна гэдэг асуудал гарах юм бол хаана хандах вэ гэж байна. Тэгэхээр одоогоор ийм асуудал гараагүй байгаа учраас энэ яах вэ магадгүй байгууллага бол тэгээд Захиргааны шүүхээрээ явах энэ боломжууд нь гарах болов уу л гэж бодож байна л даа. Гэхдээ ер нь бол энэ байцаагч нь өөрөө мэдээллийн эх үүсвэрийн чанар, мэдээллийнх нь зөв байгаа байдал зэрэг дээр нь анхаарал хандуулж ажилладаг ийм чиг үүрэгтэй гэдгийг онцолж хэлье.

Мөн түүнчлэн дараагийн асуудлууд нь юу байлаа манай статистикийнхан бас анхаараад хариулаад өгчихгүй юу. Дутуу хариулсан байгаа бол.

Б.Пүрэвдорж: Баянмөнхийн Батдаваа дарга хариулъя Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Батдаваа: ҮСХ Батдаваа. Гишүүний асуултад хариулъя. Энэ албан ёсны статистик болон албан бус буюу хувь судлаачид, хувийн хэвшлийн гаргаж байгаа судалгааны мэдээллүүд, мэдээлэл цуглуулалт, түүвэр судалгаа, академик судалгаанууд дээр бол энэ хууль үйлчлэхгүй байгаа. Энэ дээр хуулийн 4 дүгээр бүлэг дээр тодорхой заасан байгаа. Гол нь яагаад энэ улс төрийн нөлөөнөөс хараат бус, яагаад урьдчилж энэ статистикийг ийм үзүүлэлт гарга гэдгээр энийг хориглосон бэ гэхээр ер нь бол олон улсдаа яг англи хэл, нөгөө жимс түүх гэж ярьдаг. Гоё үзүүлэлтүүдээ түүж авчраад, ингэж статистикийн байгууллагуудаар гаргаад, муу үзүүлэлтүүдийг нь ард нь орхих тийм үзэгдлээс сэргийлэх зорилгоор мөн хараат бус байдлаар оруулах зорилгоор бол энэ заалтуудыг оруулсан байгаа.

Б.Пүрэвдорж: Тодруулъя.

Б.Хэрлэн: Тэгэхээр энэ хуулийн төслийн 29, 21.2-т статистик мэдээллийг хэрэглээний талаар, ашиглах талаар нэлээн том хязгаарлалтууд ороод ирсэн байгаа. Энэ хязгаарлалт улс төрийн намуудад, улс төрчдөд, бие даасан судлаачдад, эрдэм шинжилгээний байгууллага, багш, оюутан, сурагчдад хэн хэнд нь хамаатай, маш их хязгаарлалт үүсгэсэн ийм зохицуулалт ороод ирсэн байгаа. Тэгэхээр энийг эргэж харж нягтлах хэрэгтэй.

2 дугаарт нь ерөнхийдөө тэр төрийн албан хаагчийн цалин хөлс, төрийн албан хаагчийн ангилал зэрэглэлтэй холбоотой зохицуулалт бол өнөөдөр Монгол Улсын төрийн албаны хуулиар тогтоосон зохицуулалтуудтай үл нийцэж байгаа гэдгийг бас хуулийн төсөл санаачлагчид энийгээ бас анхаарах хэрэгтэй байгаад байгаа шүү.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ

Л.Соронзонболд: Энэ одоогийн ҮСХ-ны ашиглаж байгаа хэрэглээний үнийн индексийн сагсанд болохоор энэ хүнсний бүлэг гээд, хүнсний бүлгийн жин ойролцоогоор 26,7хувьтай, харин орон сууц, ус, цахилгаан, хий болон бусад түлшний бүлэг нь 9,6 буюу 10 хувьтай байгаад байгаа юм. Гэтэл яг бага орлоготой өрхийн хувьд бол энэ хүнсний бүлэг бол тухайн айлын бараг 70-80 хувийг нь эзэлж байх магадлалтай байхгүй юу. Тэгээд ингээд бодоод үзэхээр энэ статистикийн шинэчилсэн хуулийн найруулгын төсөл дээр энэ өрхийн орлоготой холбоотой асуудлыг ер нь яаж шинэчилсэн найруулгад тусгасан бэ. Өөрөөр хэлбэл зөвхөн

хэрэглээний үнийн индекс биш, тухайн өрхийн орлогын түвшнээс хамаараад хэрэглээний бүтэц нь ямар байгаа юм, худалдан авах чадварын өөрчлөлт нь яаж энэ инфляцаас хамаарч өөрчлөгдөж байгаа юм бэ гэдгийг нь тусад нь ингэж авч судалдаг. Хамтад нь судлахгүй бол зөвхөн инфляц улсын хэмжээнд тэд байна гээд л ингээд гаргачихдаг. Гэтэл тэр чинь болохоор бол бага орлоготой өрхөд их хэмжээгээр нөлөөлөөд байдаг. Одоо энэ бензин шатахууны үнэ өсчхээд байна. Энийг энэ чинь болохоор нөгөө айлын өрхийн орлогоосоо хамаараад айл бүр дээр очиж байгаа дарамт нь өөр өөр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг шинэчилсэн найруулга дээрээ ямар байдлаар тусгасан бэ гэдэг асуулт байгаад байгаа юм.

2 дугаарт энэ амьжиргааны өртгийн хямралын асуудал дэлхий даяар яригдаж эхэлж байна л даа. Тэгэхээр манай Монгол Улсын хувьд өнгөрсөн хугацаанд амьжиргааны өртгийн хямрал ер нь бүртгэгдсэн юм уу гэдэг 1 асуулт байна.

Тэгээд статистик тайлангаа гаргахаас илүүтэйгээр бас яг гарсан тайлан дээрээ үндэслээд бодлогын зөвлөмж өгөх асуудлаар ер нь бол манай энэ шинэчилсэн найруулгын хуулийн төсөл дээр ямар байдлаар тусгагдсан бэ. Зөвхөн инфляц ийм байна, үнэ ингэж өслөө гэхээсээ илүүтэйгээр ийм байгаа учраас ийм бодлого авах нь зүйтэй байна ч гэдэг юм уу ийм бодлогын зөвлөмж гаргах талаар энэ шинэчилсэн найруулгын төсөл дээр яаж туссан бэ.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа хууль санаачлагч тайлбарлая.

А.Ариунзаяа: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт яах вэ, хэрэглээний үнийн индексийн талаар хүмүүс инфляц тийм байна. Гэтэл амьдралд мах ийм үнэтэй байна шүү дээ зэрэг асуудлуудыг тавьдаг л даа. Ойлгомжтой. Ер нь бол хэрэглээний үнийн индексийн дэлхий нийтээрээ мөрдөгдөж байгаа энэ Консима Прайс индекс Си Пи Ай тэгээд энэ болохоор Дэлхийн банк, ОУВС-ийн нэгдсэн аргачлалаар дэлхийн улс орнууд бүгдээрээ адилхан аргачлалаар энэхүү мэдээллээ цуглуулж, олон нийтэд тархаадаг. Дэлхий нийт адилхан энэ аргачлалаараа явж байж аль улсад инфляцын түвшин ямар байна вэ гэдэг энэ харьцуулалтаа ч гэсэн хийдэг байхгүй юу. Тэгэхгүй бол улс орон болгон өөр өөрийн хэрэглээний үнийн индексийн сагсаа бүрдүүлээд, өөр өөр аргачлалаар хэрэглээний үнийн өсөлтийг хэмждэг байх юм бол улс орнуудыг хооронд нь харьцуулах боломжгүй болно. Ийм учраас НҮБ-ын статистикийн комисс, тэгээд ОУВС, Дэлхийн банк бол энэ Си Пи Ай индексийг нэгдсэн аргачлалаар явуулдаг. Бидний дутуу хийдэг юм юу вэ гэхээр бид нар тайлбараа дутуу хийгээд байдаг. Мэдээж энэ Статистикийн байгууллага бол Улсын Их Хурлын гишүүдэд жишээлбэл сар болгон тухайн сарын танилцуулгыг гаргадаг. Бүтэн жилийн эмхэтгэлүүдийг бас ирүүлдэг. Тэгээд энэ дотор болгонд нөгөө бүх тоонууд нь байгаа байхгүй юу. Тэгээд аль нэг тоог нь ялгаж яриад, тайлбарлаад яриад байх нь өөрөө бас бодлогын зөвлөмж өгнө гэдэг нь өөрөө яг статистикийн чиг үүрэг мөн үү, биш үү гэдэг нь бас дараагийн асуудал. Яагаад гэхээр бид нар энэ тоогоо гаргаад, энэ дээр нь тусдаа анализ хийдэг бодлогын зөвлөмжийг гаргадаг тусдаа бүтэц байх ёстой. Төр өөрөө энэ мэдээллүүдээ зөв уншиж харж, тэгээд мэдээллүүд дээрээ ажиллах ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бол манай статистик дээр уг нь байхгүй. Гэхдээ яах вэ, бид нар энэ судалгаануудыг явуулж байхад яг энэ ядуурлын судалгаа. Жишээлбэл, өрхийн орлого, зарлагын судалгаа гэж бас тусдаа хийгддэг. Та сая яг зөв хэллээ. Өрх дээр энэ чинь яаж орж ирж байгаа юм бэ гэж. Тэгэхээр

өрхийн орлого, зарлагын судалгаа бол тусдаа. Өрхийн орлого нь бүтцээрээ бас задардаг. Мөн түүнчлэн зарлага нь бас бүтцээрээ гараад, тэгээд түүн дээрээ хэрэглээ нь юу байгаа юм бэ гэдэг дээр нь суурилж, судалгааг улирал тутам гаргадаг. Өрхийн орлого, зарлагын судалгаа. Энэ бол түүвэр судалгаа. 16 мянган өрхтэй түүвэр нь ядууралд тооцдог жилээ, бусад жилээ 12 мянган өрхийн түүвэр дээр суурилж явагддаг. Тэгэхээр яг энэ өрхийн орлого, зарлагын судалгаан дээрээ илүү дүгнэлтүүдийг хийх нь тухайн өрхийн бодит орлого, бодит зарлага хэрхэн яаж нэмэгдэж өөрчлөгдсөн юм. Бодит гэдэг нь өөрөө нөгөө ердийн орлого, зарлага яг тоон дүнгээрээ. Мөн түүнчлэн бодит буюу тухайн юу гэдэг юм, тухайн жилийн үнийн өсөлтийг арилгасан энэ дүнгээрээ ч гэсэн манай статистикийн байгууллага тооцоогоо гаргадаг л даа. Тэгэхээр яг энэ .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Үгүй ээ, харин тэгэхээр ингээд байна шүү дээ. Өрх болгоны чинь орлого нь өөр өөр байхгүй юу. Тийм учраас тэр ялгаатай өрх, бага орлоготой өрхийн хувьд бол инфляц бараг 30 хувьтай байгаа шүү дээ. Их орлоготой айлын инфляц нь бол аягүй бол 6 хувь ч юм уу. Тэр чинь хэрэглээний бүтэц нь өөр байгаад байна шүү дээ. Тэр утгаар нь би асуугаад байна. Статистикийн тухай хууль дээр энэ талаар юу тусгасан юм бэ л гэж аягүй тодорхой асууж байна шүү дээ. Тэгэнгүүт шал өөр юм яриад байх юм.

Өрхийн орлого, зарлагын судалгаа гэдгийг чинь мэдэж байгаа л даа. Гол нь ингээд улсын хэмжээнд инфляц 13 хувь байна гэдэг чинь одоо өрхийн орлого хэрвээ 1 саяас доош орлоготой айлын хувьд бол инфляц нь 30, 40 хувь байгаа байхгүй юу. Тийм учраас хүмүүс юмны үнэ өөр байна гээд яриад байгаа чинь тэнд байна шүү дээ. Тэгээд энэ талын асуудлыг хууль дээрээ яаж тусгасан юм бэ гээд асуугаад байна.

Дээрээс нь амьжиргааны өртгийн хямралыг бүртгэсэн үү гэж асуусан. Тэр дээр Статистикийн хороо хариулах юм уу.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хэнээс асуух юм. Индрийн 4 дүгээр микрофон. Батмөнхийн Батдаваа дарга хариулъя.

Б.Батдаваа: ҮСХ Батдаваа. Гишүүний асуултад хариулъя. Хэрэглээний үнийн индексийг бид тооцохдоо та яг хэллээ. Бид бол Монгол хүний өрхийн дундаж хэрэглээний сагсыг бүрдүүлээд тооцож байгаа. Дунджаар бол 9 дүгээр сарын байдлаар 12,9 хувь гээд ингээд явж байгаа. Яг таны хэлдгээр өрхийн орлого буурах тусам өрхийн хэрэглээний сагсанд эзлэх хүнсний бүлгийн жин бол нэмэгдээд явдаг. Өөрөөр хэлбэл одоо хэлэхэд бол хамгийн бага орлоготой 20 хувь дээр хүнсний жин бол 42,4 болоод, тэрнээсээ доошлохоор улам бүр нэмэгдээд байгаа. Бид нарын хамгийн их санаа зовж байгаа юм юу вэ гэхээрээ хүнсний инфляц сүүлийн саруудад бол 20 хувиас дээш явж байгаа. 7 дугаар сард бүүр 26 руу орж байсан. Одоо 20,8 хувьтай явж байгаа. Яг ингээд жинлээд тооцохоор бол дунджаас орлого багатай өрхүүдийн инфляц бол өндөр байгаад байгаа..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Чинбаатарын Анар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Анар: Сайн байцгаана уу. Тэгэхээр энэ хуулийн төслийг бол үзэл баримтлалын хүрээнд нь дэмжиж байна. Бас нэлээн дажгүй чамбай болсон хууль байна гэж үзэж байгаа юм. Гэхдээ бас Монгол Улсад анх удаа төрийн өгөгдлийг системтэйгээр ашиглах нэлээн нарийн зохицуулалт бүхий хууль орж ирж байгаа. Энэ дээр нь өөрөө анхдагч өгөгдөл гэдэг маань үндэсний аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын томоохон асуудал. Үүнтэй холбогдуулан хэд хэдэн асуултууд байна. Цаашлаад ажлын хэсэг дээр анхаарах шаардлагатай байх гэж бодож байна.

Жишээ нь, 3.1.5 дээр аюулгүй судалгааны орчин гэж байгаа юм. Аюулгүй судалгааны орчин дээр судлаач зөвшөөрөл авах юм бол өгөгдөлд хандах эрхтэй болж байгаа юм. Энэ дээр гадаадын иргэн, ОУБ хандах эрхтэй байх юм уу. Хууль дээрээ зохицуулж өгөхгүй бол энэ чинь эмзэг мэдээллүүд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ өгөгдлийн засаглалынхаа талаар Кибер аюулгүй байдлын зөвлөл, ҮАБЗ-өөс энэ асуудалтай холбогдуулж санал авсан уу. 1 дүгээр асуулт.

2 дугаарт энэ 4.2-ын талаар Эдийн засгийн байнгын хороон дээр асуугаад бас тодорхой хариулт авч чадаагүй. Энэ хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг заасан зөвшөөрөл авах шаардлагагүйгээр маш өргөн хүрээтэйгээр энэ өгөгдлийг шууд авах эрх үүсэж байгаа юм. Тэгэхээр ҮСХ бол тусгай чиг үүргийн байгууллага шиг дурын өгөгдлөө зөвшөөрөлгүйгээр авах эрх бүхий маш томоохон институт болж байгаа. Энэ нь ч гэсэн тийм шаардлагатай байгаа. Гэхдээ эргээд энэ нь өгөгдөлд хяналт тавих, дуусах, устгах зэрэг процессууд нь хууль дээр заагдаагүй байна. Энийг яагаад оруулаагүй вэ. Энэ асуудал дээрээ ХЭҮК, Кибер аюулгүй байдлын зөвлөлөөс санал авсан уу. Энэ бол маш эмзэг асуудал.

3 дугаарт үндсэндээ ҮСХ дээр зовлон байдаг. Энэ төрийн байгууллагууд тоо баримтаа зөрүүлж өгдөг. Тэрийг нэгтгэсэн байдлаар нэгтгэх нь Статистикийн хорооны их төвөгтэй ажил гэж ойлгодог. Тэгэхээр энийг нэгдсэн 1 цонхоор мэдээллээ авч олон нийтэд тайлагнах эрх зүйн үндэс нь энэ хуулиар бүрдэж чадаж байгаа юу. Дараа нь тодруулъя. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ. Индрийн 4 дүгээр микрофон дээр Батмөнхийн Батдаваа дарга х ариулъя.

Б.Батдаваа: ҮСХ Батдаваа. Гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн зохицуулалт болон одоо явж байгаа зохицуулалтуудаар бид төрийн болон албаны нууцтай холбоотой асуудал бол тусдаа хуулиар буюу Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагдаж байгаа. Тийшээ бол хөндөгдөхгүй орохгүй гэсэн үг. Зөвхөн хуулиар зөвшөөрсөн статистик мэдээллийг бол хуулийн заасан зохицуулалтаар ашиглах ийм зохицуулалтууд явж байгаа. Тэгээд жишээлбэл жишээ дурдахад бид 2025 оны хүн ам, орон сууцны тооллогыг явуулахад төрийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэхдээ төрийн хур системээр дамжуулаад холбогдох журам, хуулийн дагуу дамжуулаад иргэн болгонд таны энэ өгөгдлийг чинь ийм зорилгоор хуульд заасан зорилгоор ашиглалаа гэдэг мэдэгдлийг хүргүүлэх замаар ийм зөвшөөрөгдсөн хүрээнд бол ашиглаж явж байгаа. Энэ нь өөрөө эргээд мэдээлэл цуглуулалтыг газар дээрээс хийх хугацаа, цаг, зардлыг бол хэмнэж байгаа ийм үйл ажиллагаа гэж үзэж байгаа.

Таны хэлдэг тэр төрийн байгууллагуудын мэдээлэл зөрдөг асуудал бол мэдээллийн чанартай холбоотой асуудлууд байгаа. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагуудын захиргааныхаа үйл ажлын хүрээнд цугларч байгаа мэдээлэл маань зарим тохиолдолд чанарын шаардлага хангадаггүй. Энийг цаашдаа бид өгөгдлийн засаглал тал руу нь илүү хөгжүүлэх, мэдээллийн чанар, энэ өгөгдлийг эргэлтэд оруулах асуудлуудаар бол илүү анхаарч ажиллах шаардлагатай байгаа. Энэ хүрээндээ Үндэсний статистикийн зөвлөл гээд энэ хуульд заасан зөвлөл маань энэ төрийн байгууллагууд хоорондын өгөгдөл солилцоо, чанар, хамтын ажиллагаа уялдааг сайжруулах чиглэлээр бас тодорхой хэмжээний шийдвэр гаргах зөвлөмж өгөх ийм чиг үүрэгтэйгээр оролцож байгаа гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Анар гишүүн тодруулъя.

Ч.Анар: Процесстой холбогдолтойгоор нөгөө ХЭҮК, Кибер аюулгүй байдлын зөвлөл, ҮАБЗ-өөс зөвлөмж, дүгнэлт авсан уу. Гадаадын иргэн, ОУБ өгөгдлийг нууцалсан процессынх нь дагуу хандах эрх боломжтой байгаад байна. Энэ тал дээр ямар байр суурь дуртай байгаа вэ.

Нөгөө талаасаа Засгийн газраас Өгөгдлийн тухай хуулийг өргөн барьж байгаа гэж ойлгож байгаа. Тэр хуультай хэрхэн уялдах вэ. Энэ хууль маань бараг Монголын төрийн хамгийн анхны өгөгдлийг нэлээн нарийн зохицуулсан хууль болж орж ирэх гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ аюулгүй байдлын шаардлагуудаа хэрхэн хангасан бэ. Улс төрийн хараат гээд яг яагаад асуугаад байгаа юм бэ гэхээрээ гадаадын нөлөөллийн үйл ажиллагаанд орох эрсдэлтэй байна. Тийм учраас энэ тодорхой хүний эрхийг бас зөрчих асуудлууд байна. Мөн хууль хэдийгээр 17.5-д заагдсан ч гэсэн улс төр хууль хүчний байгууллагын нөлөөлөлд орох эрсдэлд байна гэж үзээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Анар гишүүний асуултад хариулъя. Ер нь бол яах вэ, манайх чинь өөрөө 2024 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Яг л энэ хувь хүний мэдээлэлтэй тогтмол л ажиллаж явж байгаа. Хуулиараа статистикийн зорилгоор мэдээллийг ашигладаг гэдгийг дахиад тодруулж хэлмээр байна. Статистикийн зорилгоор. Эгээд судлаачид, хувь хүнд анхдагч өгөгдлийг тухайн хувь хүн, хуулийн байгууллагыг таних боломжгүй болгосон. Статистикийн зорилгоор гарч ирж байгаа тэр мэдээллийг судалгаандаа илүү нарийвчилж ашиглах боломжийг нь нээлттэй болгож өгч байгаа. Одоо ч гэсэн ерөнхийдөө судалгааны мета датаг авах эрх нь байгаа л даа. Гэхдээ энийгээ илүү нарий нарийвчилсан бүхий л асуулгаар нь гэдэг ч юм уу, статистикийн судалгааны тэр анхдагч мэдээллийг ашиглах энэ боломжийг нь олгож өгч байгаа. Гэхдээ дахиад бүртгэлийн процесстой, зөвшөөрлийн процесстой явж байгаа. Энэ хуулийн 16.4 дээр мэдээллийн санд хандах, ашиглах, мэдээлэл татах журам, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын нийтлэг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Анар гишүүн дахиад нэмж тодруулъя.

Ч.Анар: Гадаадын иргэн, ОУБ хандах эрхтэй байна. Энэ дээр ямар байр суурьтай байгаа юм бэ.

Дахиад Кибер аюулгүй байдлын зөвлөл, ҮАБЗ-өөс дүгнэлт авсан уу. Хүний эрхийн комиссоос тэр өгөгдөл хянах, дуусгах, устгах зэрэг асуудал нь энд орж ирээгүй байна. Мэдээж Статистикийн хороо бол статистикийн зорилгоор мэдээллээ авч байгаа. Гэхдээ тэнд цуглаж байгаа анхдагч мэдээлэл маань өөрөө бүх мэдээлэл цуглачхаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр аюулгүй ажиллагаагаа хангах тал дээрээ нэлээн анхаарах хэрэгтэй байна. Энэ процессыг сайжруулах шаардлагатай байна л гэж байгаа юм. Тэрнээс энэ хуулийг бол дэмжиж байгаа. Хариултаа л авъя.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Яах вэ, манай Батдаваа дарга бас нэмээд хариулна биз. Манайх чинь статистикийн байгууллага олон улсын байгууллагуудтай угаасаа хамтарч ажилладаг байхгүй юу. Дэлхийн банк, ОУВС, бусад статистикийн байгууллагуудын гадаад зөвлөх ажилтнууд орж ирж, бид нарын энэ дата дээр ажилладаг шүү дээ. Тэгэхээр гадаад ажилтныг судалгааны энэ юундаа оруулж болохгүй гэж хориглох нь өөрөө юу л бол. Зүгээр таны яриад байгаа бусад асуудлууд дээр яг зөв ойлголцоод байна уу, буруу ойлголцоод байна уу гэдгийг тусдаа дахиад ярилцъя даа тэгэх үү. Тэгэхгүй л бол энэ мэдээллийг үзүүлж болохгүй, ашиглаж болохгүй гэхээр чинь бид нар бусад олон улсын өмнө хүлээсэн үүргээ яг биелүүлж чадах уу, үгүй юу гэдэг ийм сонин л асуудал болох гээд байна л даа. Тэгэхээр эргээд ярилцъя даа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Одоо Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Би статистикийн байгууллагыг бол хамгийн нарийн бутархай орноор нь хүртэл тасалж тоо гаргадаг ийм байгууллага гэж бодсон. Тэгсэн чинь энэ оруулж ирж байгаа хуулийн төсөл ажлын хэсэгт статистик бүтэн байгууллага байж байж ийм хуулийн төсөл оруулж ирж байгаа гэдэгт би бол үнэхээр гайхаж байна. Энэ хуулийн төсөл бол хэлэлцэх хэмжээнд бэлэн биш байна. Би зүгээр жишээ хэлье л дээ. Энэ маш чухал салбарын шинэчилж байгаа ийм хууль байтал энэ дотор бол маш олон алдаанууд байна. Би зүгээр жишээ нь эхнээс нь хэлье. Энэ өөр хуулиудаас хуулаад тавьчихсан юм уу. Одоо жишээлбэл үр нөлөөний тайлангийн дүгнэлт дээр Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэрийг оруулчихсан явж байна шүү дээ. Энийгээ ядаж та хэд зас л даа. Энийгээ хар. Зардлын тооцооны хуудсан дээр чинь Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гэчихсэн явж байна.

Засгийн газраас санал аваад, энэ хуулийн төсөл чинь 35 бүлэгтэй гээд одоо жишээлбэл юун дээр биччихсэн байна. 31 болгочихсон байгаа шүү дээ. Тэгэхдээ энийгээ засаагүй. 35 бүлэгтэй гээд хуулийн танилцуулга дээр чинь явж байна. Тэгээд энэ зардлын тооцоонууд дээрээ байхгүй, 30, 31, 32 гээд байхгүй зүйлүүдийг эшилчихсэн байна. Тэр шаардлагатай бол гэсэн зарим юмнуудыг жишээлбэл шаардлагатай юм шигээр тооцоонууддаа оруулчихсан байх жишээтэй. Дээр нь энэ цалингийн тооцоон дээр бас та хэд алдаа гарсан байна. Энийгээ шалгаарай. Тэгэхгүй бол тэр нөгөө боловсролын багш нарын цалинтай холбоотой асуудал гарч магадгүй. Дээр нь Төрийн албаны тухай хууль дээр статистикийн улсын байцаагчийг цагдаа, тагнуулын байгууллагатай адилтгаж ийм тусгай албан хаагч болгоно гэсэн байна. Энэ статистик агуулга дээр нь болохоор төвлөрлийг сааруулж, төвлөрүүлж орон нутгийн удирдлагаас хараат бус болгоно гэсэн мөртөө засаг захиргааны нэгжийн тухай хууль дээр дээрээ энэ статистик гаргах сумын чиг үүрэг болгосон байна.

Тэгээд энэ дагаж мөрдөх журмын тухай хуульд дээрээ 6.7, 7.3.1, 7.3.3, 7.3.8, 32.2.7 гээд бүгдээрээ байхгүй заалтуудыг эш татчихсан. Тэгээд ийм байж байж та хэд яаж статистик гаргадаг юм бэ. Ариунзаяа гишүүн ээ, хууль санаачлагч гишүүний хувьд ийм бүрдүүлбэр шаардлага хангахгүй. Энэ бөөсийг чинь түүвэл дуусахгүй юм билээ. Тэгэхээр хуулиа жишээлбэл хэлбэрийн хувьд хангасан юм шиг боловч дотор нь бол бөөн алдаа. Ингэж хууль оруулж ирмээргүй байна. Тэгээд энэ салбарын хууль байгаа. Бүхэлд нь шинэчилж байгаа. Хариуцлагатай байхгүй бол ийм замбараагүй байдлаар энэ бүтэн салбарын хуулийг шинэчилж ингэж оруулж ирмээргүй байна.

2 дугаарт тэр хувь хүний мэдээлэлтэй холбоотой асуудал. Энэ өмнө бол жишээлбэл анхдагч мэдээллүүдийг хариуцсан байгууллагууд нь авч боловсруулдаг байсан бол одоо шууд статистикийн төв газар өөрөө энэ мэдээлэлд шууд хандалт хийх хэрэгтэй болж байна. Тэгэхээр Статистикийн төв газрын маань жишээлбэл удирдлагууд нь энэ улс төрөөс хамааралгүй байж чадахгүй байгаа. Өнгөрсөн томилгоонуудыг ч гэсэн ингээд харахаар бас тодорхой хэмжээнд улс төрийн жишээлбэл санал зорилготой ч юм уу иймэрхүү томилгоонууд явагддаг байсан. Тэгэхээр энэ хувь хүнийг таних боломжгүй болгож статистикийн зорилгоор ашигладаг байсныг одоо шууд статистикийн төв газар шууд энэ таксистай болж байна. Тэгэхээр энэ нь өөрөө хувь хүний мэдээллийг хамгаалахтай холбоотой харилцаа дээр эрсдэл учрахаар байна. Тэгэхээр үүнтэй холбоотой хамгаалалтын зохицуулалт бол ерөөсөө байхгүй. Тэгээд одоо бас Өгөгдлийн тухай хууль гээд өргөн барьчихсан байгаа. Энэ хуультайгаа нийцүүлэх зайлшгүй шаардлагууд харагдаад байна.

Тэгээд энэ дээр бас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дээр хаалттай мэдээллийг жишээлбэл ашиглаж болохоор хувь хүний эрүүл мэндтэй холбоотой нарийн хаалттай мэдээллүүдийг ч гэсэн шууд ашиглаж болохоор ийм заалтууд орчихсон байна. Тэгэхээр энэ хамгаалалт хязгаарлалттай холбоотой юм байхгүйгээр энэ хуулийг бол дэмжих .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Яах вэ, хуулийн хэрэгцээ шаардлага, үнэлгээний судалгаа бүх юмнууд ч эхлээд нь явж байгаад, байгууллагуудаас саналыг нь аваад, эцсийн байдлаар өргөн барьж байгаа энэ хуулийн төсөл чинь өөр болоод л орж ирдэг шүү дээ Энхтүвшин гишүүн ээ. Эрх биш анхны хууль өргөн барьж байгаа. Бас мэднэ шүү дээ та. Та ч гэсэн олон л хууль өргөн барьдаг. Энэнтэйгээ адилхан зөрж байгаа асуудлууд байдаг шүү дээ. Тодорхой хэмжээний алдаанууд гарсан бол яах вэ, тэрийгээ засаад явж болно. Гэхдээ одоо бол тэр урьдчилсан судалгаанууд гэхээсээ илүүтэй хуулийн төсөлтэйгөө бид нар ярих ёстой шүү дээ. Хуулийн төсөлтэйгөө ярих ёстой. 1924 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хууль, эрх зүйн орчныг одоо шинээр өргөн барьж байгаа Өгөгдлийн тухай хуулийн дагуу хийх ёстой гэдэг чинь бас юу гэсэн үг вэ. Тэр чинь өөрөө тусдаа асуудал шүү дээ. Тусдаа асуудал. Татваргүй орчин бүрдүүлж байна. Би Өгөгдлийн тухай хуулийг нь бүтэн уншаагүй л дээ. Гэхдээ тэр чинь шал тусдаа асуудал. Энэ чинь статистикийн зорилгоор албан ёсны үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын асуудал.

Үгүй ээ, эрүүл мэндийн мэдээллийг нь ашиглахгүйгээр бид нар ДОХ-оор өвдсөн хүмүүсийн мэдээллийг тэгээд яаж энэ сарын танилцуулгууддаа оруулах юм.

Ойлгохгүй байна. Энэ мэдээллүүдээ яаж хийх юм. Тэгэхээр яах вэ, та шүүмжилж болно. Асуудалгүй. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүдтэйгээ хамтдаа шийдвэр гаргах байх гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хариулчихлаа шүү дээ. Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Ариунзаяа гишүүн ээ, ийм жоохон хүүхдийнх шиг юм ярьж болохгүй. Хуулийн төсөл бол санал авсан бол тэрийгээ өөрчлөөд хийдэг юм. Бид нар ч гэсэн би ганц жижиг хууль хийгээд ч гэсэн бүх юмнуудаа авсан санал дээрээ үндэслэж өөрчилдөг юм. Тэгэхгүй бол санал авахаас өмнөхөөрөө оруулж ирнэ гэж байхгүй.

Тэгээд энэ хувь хүний мэдээлэлтэй холбоотой юм чинь шал өөр байгаа байхгүй юу. Та өөрөө ярьж байгаа юмаа ч сайн ойлгохгүй байгаа юм уу. Тэр хувь хүний мэдээллийг хамгаалалтгүйгээр ингээд авах гээд байгаа байхгүй юу. Өмнө нь бол хувь хүнийг нь таних боломжгүй болгочхоод, тэр асуудлуудыг аваад статистик чинь одоо таны үзүүлээд байгаа ном чинь тэгж гардаг байсныг шууд хандалт хийх бололцоог нээхдээ энэ хамгаалалтын асуудлуудыг нь дагуулж оруулж ирээгүй байна. Тэгэхээр сайн өшөө боловсруулаад, энэ үг, үсэг алдаануудаа засаад оруулж ир гэж хэлмээр байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Чинбатын Ундрам гишүүн асуулт асууна.

Ч.Ундрам: Миний хувьд энэ статистикийн тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд бол дэмжиж байгаа. Мэдээж сайжруулаад явах юмыг ажлын хэсэг байгуулагдаад сайжруулаад явах байх.

Энэ хуулийг боловсруулах үед хуулийн танилцуулга дээр статистикийн анхан, дунд шатны нэгжийн удирдах, гүйцэтгэх ажилтнуудтай хийсэн уулзалтын үеэр ийм ийм санал нэлээд их гарлаа гээд энэ дээр биччихсэн байна. Жишээлбэл, бие даасан хараат бус байдал гэдэг санал маш их гарсан байна гэж байгаа юм. Статистикийн байгууллага хараат бус байх ёстойг өнөөдөр гишүүн болгон л хэлж байна. Тэгээд Улсын Их Хурлын дарга санал болгосноор Их Хурал томилдог, Их Хурлын доорх байгууллага шүү дээ. Тэгэхээр тэнд хараат байдал байгаад байгаа болохоор ажилчид нь тийм асуудлыг дэвшүүлээд байна гэж харагдахуйц байна л даа. Тэгэхээр ийм хараат зүйл байдаг юм уу. Энэ төв газраа биш юм гэхэд аймгуудад ч юм уу, дүүрэгт байгаа энэ нэгжүүдэд нь тийм хараат байдал үүсээд байдаг юм уу. Ямар нэгэн тоо баримтыг улс төрийн нөлөө шахаан доор өөрчлүүлэх гээд байдаг юм уу гэдэг ийм асуулт гараад байна. Хэрвээ тийм байдаг бол бид нар яаралтай энийг илүү энэ хуулиараа хараат бус байдлыг хангахуйц болгох ёстой гэж бодож байгаа.

2 дугаарт төрийн байгууллага хоорондын өгөгдлийн солилцоог сайжруулах зохицуулалт орж ирсэн байна. Энэ бол маш чухал гэж би бодож байна. Жишээлбэл, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд ажиллаж байхад ер нь бол манай яаманд соёлын салбарын статистик гэж ерөөсөө тийм тодорхой юм байхгүй. Спортын салбарт нь ч тодорхой юм байхгүй, аялал жуулчлалын салбарт нь ч тодорхой юм байхгүй маш тийм ямар тоо баримт харж шийдвэр гаргадаг нь тодорхойгүй ийм нөхцөл байдалтай байсан. Тэгээд тухайн үед Батдаваа дарга болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаад, бид нар эхний ээлжид энэ бизнесээ

дэмжих салбар луу буюу аялал жуулчлалын салбарын статистик мэдээллийг судалгаа хийгээд ингээд гаргая гээд эхний мэдээллийг гаргаж байсан. Тэгэхээр энэ заалт орсноор ер нь яамд хоорондын, тэгээд татвар, нийгмийн даатгалын газар, улсын бүртгэл гээд хоорондоо өгөгдлөө солилцоод Монгол Улс 1 тодорхой тоо баримттай болно гэж ингэж харж байгаа.

3-д нь зарим судлаач, эрдэмтэн гишүүд маань хэлж байна. Судалгаа, микро өгөгдлийн ашиглалт маш муу байдаг гээд хэлж байна. Тэгээд яах вэ, гадаад улс орнуудыг хараад байхаар Канад ч юм уу, Австралийн Үндэсний статистикийн газар нь мэдээж үндсэн статистикийг нийтэд үнэ төлбөргүй болон шийдвэр гаргах байгууллагуудад өгч байгаа. Гэхдээ яг тодорхой зарим судалгаа, хувь судлаачийн хүссэн ч юм уу, аль 1 компанийн хүссэн судалгааг төлбөртэйгөөр олгодог. Тэгэхдээ тэр нь заавал нөгөө ашиг хийх гээд байгаа юм биш л дээ. Тэр судалгааг хийхэд гарч байгаа зардлаа захиалагч талаас нь авчихдаг. Хэрвээ тэгэх юм бол Монголд ядаж энэ доктор хамгаалж байгаа хүмүүсийн докторын судалгааны чанар нь сайжрах байхгүй юу. Манай Статистикийн үндэсний хороо бол үнэхээр ачаалалтай ингээд ажиллаж байгаа, цөөхөн хүнтэй. Тэгэхээр судлаач болгоны хүссэн юмыг нь гаргаад өгөх ямар ч боломжгүй байдаг болохоор тодорхой ийм бодит зардлыг нь өгөөд, захиалаад очерлож байгаад ингээд авдаг энэ боломжийг бид нар бий болгох шаардлагатай гэж бодож байгаа.

Тэгээд дээрээс нь энэ статистикийн байгууллагын боловсон хүчин яг хаана яаж бэлтгэгддэг юм бэ. Энэ талаар бас асуумаар байна. Яг ямар хөтөлбөрөөр хэдэн хүн жилд бэлтгэгдээд, ажилд орж байна вэ. Орон нутагт байгаа статистикийн байгууллагын албан хаагчид нь яг мэргэжлийн хүмүүс байж чадаж байгаа юу. Тэндээс чинь л нийт улсын статистик чинь бүрдэж гарч ирж байгаа шүү дээ гэсэн ийм асуултууд байна.

Б.Пүрэвдорж: Хэн нь хариулах юм. Та хариулах уу. Хууль санаачлагч Аюушийн Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Статистикийн байгууллагын ялангуяа аймаг, орон нутгийн бие даасан байдал дээр хамгийн наад захын жишээ нь бол нөгөө томилгооны асуудал байгаад байдаг. Тэгэхээр аливаа сонгуулийн дараа энэ хэлтсийнхээ даргыг солимоор байна гэсэн ийм саналууд нөгөө ялсан талаас нь ирээд байдаг. Тэгээд аз болж манайх өөрсдөө хэлтсийн даргаа томилдог байхгүй юу. Тэгэхдээ одоо ингээд сүүлд бас 1 өргөн барьсан хуулийн төслөөр хэвтээ байх ёстой гэх зэрэг ийм саналууд яваад байгаа шүү дээ. Тэгэхээр яг статистикийн байгууллага бол хараат бус байдлыг маань заавал байлгаж өгөөрэй, энэ чухал шүү гэдэг. Тэгэхээр статистик гэдэг маань зүгээр хэн нэгний хийчхээд байдаг ажил бас биш байхгүй юу даа. Тэгэхээр энэ дээр мэргэшсэн байдал, яг энэ тухайн асуудлаа мэддэг байх, олон жил туршлагатай байх зэрэг асуудлуудыг хамгийн наад зах нь томилгоогоор нь харах хэрэгтэй. Нөгөө талдаа бол мэдээж нөгөө статистикийн байгууллагын хэлтсийн дарга бол тухайн Засаг даргатайгаа тухайн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал дээрээ, тухайн аймагт тулгамдаж байгаа асуудлууд дээр нь зөвлөгөө өгч, мэдээллээр хангаж ингэж ажилладаг. Тэгэхээр энэ дээрээ бас зарим аймгуудад үл ойлголцох асуудал гардаг ч юм уу, тиймэрхүү асуудлууд байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ аль болох мэргэжлийн хараат бус байлгах нь чухал гэж энэхүү хуульдаа бас нөгөө өмнө нь байсан заалтаа ч гэсэн бас оруулж ирж байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, ер нь нөгөө яамдын гаргаж байгаа захиргааны мэдээллийг бид нар бас Статистикийн арга зүйн зөвлөлөөрөө аргачлалыг нь баталж, мэдээлэх давтамжийг нь баталж, арга зүйн зөвлөмжийг нь өгч бас ажилладаг. Тэгэхээр шинэ тутам шинээр бий болгох ёстой мэдээллийн баазуудыг бол тухайн статистикийн байгууллагын хамтаар тухайн байгууллага өөрийнхөө захиргааныхаа мэдээллийг бий болгодог. Тэгэхээр таныг яам дээр бас ажиллаж байхад өмнө нь та сонссон бол нөгөө Шаравжамц Спортын газрын дарга байхад манай Статистикийн хороо биеийн тамирын анхны тооллогыг бас хийж байсан. Нөгөө судалгааны баримтыг хийж байсан. Тэгээд тэрийгээ үргэлжлүүлээгүй, бүр хаа байсан 2015 онд билүү дээ бид нар хийж байсан юм. Тэгээд тэрнийгээ уг нь захиргааны мэдээлэл болгоод, тогтмол мэдээллээ авдаг, бүртгэдэг байх юм бол энэ чинь өөрөө албан ёсны статистик болоод л явах учиртай. Тэгэхээр энийг бол яг одоо цаашлаад яг тухайн байгууллага бүр өөрийнхөө албан ёсны захиргааны мэдээллээ Статистикийн хорооны арга зүйн зөвлөлөөр орж, тухайн ямар асуулгын хуудсаар байх юм, ямар аргачлалаар байх юм, ямар давтамжтай мэдээллээ цуглуулж байх юм бэ гэдгийгээ батлаад, тэгээд олон нийтэд тархаагаад явдаг. Тэгэхлээр байгууллагуудтай хамтарч ажиллаад явсан нь зүйтэй.

Судлаачдын хувьд бол үнэн. Би 2016 онд статистик дээр Статистикийн даргаар очиж байхад бид нар бас төлбөртэй мэдээллээ өгдөг байсан. Тэгэхээр тэрийг бол үнэ төлбөргүй болгоод, одоо ч гэсэн үнэ төлбөргүй байгаа. Мета мэдээлэл буюу бүр тэр анхдагч өгөгдлийг хувь хүний нууцлалыг хангасан мэдээллийг бас нээлттэй авч болохоор оруулж ирж байгаа нь бас шинэлэг, судлаачдад илүү хэрэг болох юм болов уу гэсэн ийм заалт байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Ариунзаяа гишүүн болон 7 гишүүний санаачилж оруулж ирсэн хуулийг дэмжиж байгаа. Ер нь бол аливаа орон ялангуяа шийдвэр гаргагч түвшинд бол мэдээллээ л сайн баталгаажуулж, үнэн зөвийг нь нотлох ёстой. Энэ дээр бүр ач холбогдол өгч, тэр хүмүүсийнхээ аюулгүй байдал, тэр хүмүүсийнхээ статусыг дээшлүүлье, цалин хөлс хангамжийг нь дээшлүүлье гэдэг утгаар орж ирж байна. Энэ бол цаг үеэ олсон асуудал.

Дэлхий даяар өнөөдөр биг дата, кибер аюулгүй байдал гээд ингээд бүгд ярьж байхад бид өнөөдөр статистикийнхаа энэ мэдээллүүдийг баталгаажуулж, түвшнийг нь дээшлүүлье гэдэг бол цаг үеэ олсон асуудал. Мэдээж дэлхий дээр байдаг юм. Эрх баригчдад таалагдсан тоо хэрэгтэй. Тэр тоог нь захиалгаар статистикийн газрууд нь гаргадаг ийм гунигтай явдал дэлхий даяар байдаг. Манайд ч гэсэндээ бүүр гаарчихсан. Энэ байдлаасаа гарах арга зам болов уу гэж горьдож байна.

Нөгөө Жефферсоны хэлсэн үг байна шүү дээ. Ардчиллын амин сүнс л гэж орчуулъя даа. Каренси гэж байгаа юм. Ардчиллын жинхэнэ гол мөнгөн тэмдэгт, үнэт зүйл бол мэдээлэл юм гэж үг хэлсэн шүү дээ. Одоо энэ танхим дотор би орж гараад 10 хэдэн жил ярьж байна. Тоо баримт мэдээлэлгүй ярина. Дандаа сэтгэлийн хөдлөлөөр. Оюутолгой ямар ч тоогүй ярьсан учраас л энэ. Миний ганц асуудаг юм тоо баримт, шинжээчийн дүгнэлт хаана байна вэ л гэж асуудаг. Бүгд таг. Цээжээ дэлдэж ярьж байгаад л дараад нь арааараа зад авхуулдаг. Тэгэхээр статистикийг Их Хурлын яг дэргэд хатуу байлгана гэдэг бодитой болгоё гэж оруулж ирж байна гэж би ойлгож байна.

Тэгээд би асуух зүйл бас адилхан. 22.1, 22.2, 22.3 л хамгийн чухал байгаа шүү дээ. Статистикийн байгууллагын төсөв нь энэ хуулийн 7.1.4-д заасан үзүүлэлт, тооллого судалгаа үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна гэж байгаа юм. Хэдийг хүрэлцээтэй гэж яриад байгаа юм. Хэдэн хүнд дунджаар хэдэн төгрөгийн цалин өгдөг юм. 3 жил ажиллаж байгаа мэргэжилтэн яг хэдэн төгрөгийн цалинтай байна. Надад энийг хэлээд өгөөч. Яг баталгаатай юу эсвэл хэн нэгэн даргын захиалгаар мэдээлэл өгөхөд бэлэн байхаар байх вэ гэдгийг л тоо баримттай тодорхой хэлж өгөөч. Ерөнхий л яриад байвал харин жинхэнэ статистикийн асуудлыг чинь тодорхой ярья л даа. Хэдүүлээ надад энэ асуултад хариулж өгөөч. Хэдэн хүн ямар цалинтай юм.

2 дугаар асуулт байна шүү дээ. Статистикийн байгууллагын ажилтны албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал олгох журам, цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал тогтооно гэж байгаа. Энэ яг хангалттай байгаа юу. Одоо та нар чинь Засгийн газар болон аймаг, орон нутгийн удирдлагуудын бас тоо аваад, тэдний талаар хийж байгаа, барьж байгаа үр дүнгүүдийг нь тоогоор баталгаажуулах гэж байгаа тэднээсээ хараат биш байна гэдгээрээ Их Хурлын дэргэд байх ёстой. Та нарын энэ систем үнэхээр хараат бус байхаар ажиллаж чадаж байна уу.

3 дугаар асуулт. Одоо бүр сумуудаар явах юм. Та нар н ажлын байрны зураглалаа дахиж хийгээч. Ерөөсөө сумд очоод л төрийн албан хаагчид нь нөгөө иргэдэд үйлчилнэ гэхээсээ илүү дээрээс ирсэн заримдаа ч хэнд ч хэрэггүй тоог л зүгээр өдөр тутам явуулах юм. Чухал баримт, мэдээлэл, чухал бус мэдээлэл 2-ыг л ялгахгүй бол чухал бус мэдээлэл хэнд ч хэрэггүй хог болно. Их Хурал дээр гардаг мэдээлэл, шийдвэр гаргалтууд дандаа хог болно л гэсэн үг. Тэгэхээр энэ үр дүн, мэдээллийн давхцал, оновчлол эффишенси гэдэг юман дээр та нар ажлын байрны зураглалаа дахиж хийх боломж байгаа юу. Одоо ингэж бүтэц, энэ сайхан Их Хурлын түвшинд ярьж байна. Энэ ер нь ёстой цаг үеэ олсон асуудал. Энэ дээр би гуравхан асуулт асуулаа. Хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Батдаваа дарга хариулъя.

Б.Батдаваа: УСХ Батдаваа. 1 дүгээрт гишүүн УСХ-ны ажилчдын цалингийн асуудлыг асуулаа. Их Хурлын дэргэдэх байгууллагуудын цалин 2021 онд бол яамдаас бол 20-30 хувиар бага байсан. 2025 оноос эхлээд жигд, харьцангуй өрсөлдөх чадвартай болсон байгаа. Одоо орон нутгийн статистикийн ажилчдын цалин бол нэлээн хүндрэлтэй байгаа. Мэргэжилтэн бол 1,5 сая төгрөгийн цалинтай байгаа.

Таны хэлдгээр тэр сумдад байгаа статистикийн хариуцаж байгаа төрийн сангийн мэргэжилтэн, багийн дарга нарын ачаалал бол үнэхээр хүнд байгаа. Энийг бид орон нутаг дээр ажиллахдаа бол маш их хардаг. Сумдын ажилчид маань өрхөд тохиолдсон үйл явдлаас эхлээд төрийн мэдээлэл цуглуулалт, төрийн санхүү гээд бүх үйл ажиллагаан дээр оролцоод, ачаалалтай явдаг байгаа. Бид нар хуулийн төслийн шинэчилсэн найруулгаар гол оруулж ирж байгаа 1 зүйл юу вэ гэхээрээ төрд байгаа мэдээллийн сангуудыг илүү түлхүү ашиглах чиглэлээр орж ирж байгаа. Энэнийхээ хэрээр бол орон нутгийн нэгжүүд дээр ирж байгаа мэдээллийн ачаалал буурна. Аж ахуйн нэгжүүдийнх буурна. Жишээ дурдах юм бол 2021 онд бид орон нутгаас нийтдээ 52 төрлийн статистик мэдээллийн маягтаар цуглуулдаг байсан

маань одоо 30 орчим болоод буурч байгаа. Цаашдаа төрийн мэдээллийн сангуудыг ашиглах тусам энэ ачаалал бууraад, илүү нөгөө орон нутагт байгаа төрийн албан хаагчид маань иргэддээ хүрэх ажил руугаа анхаарах боломжтой болно гэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя С.Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: 1 тодруулах зүйл байна. Одоо Ариунзаяа гишүүнээс л асуучихъя даа. Хаанаас тодорхойлдог вэ. Энэ 19.1-ийг л асуух гээд байгаа юм. Үндэсний статистикийн тогтолцооны байгууллага, түүний ажилтан статистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ мэргэжил арга зүйн үйл ажиллагаа, төсвийн хувьд гэж байгаа юм шүү. Төсвийн хувьд хүрэлцэхүйц аливаа этгээдээс хараат бус байна гэж байгаа юм. Үүнийг хэн тодорхойлох вэ. Хэн энийг баталгаажуулах вэ. Яг одоо энэ 19.1 яг баталгаатай хэрэгжиж байгаа гэдэг дүгнэлт хаанаас гарсан бэ. Би итгэлтэй байж болох уу.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Яах вэ, нөгөө статистикийн байгууллагын тоон мэдээлэл, судалгаа өмнөх хуулиар буюу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд тоон судалгаа нэр төрлийг нэрээр нь заачихсан байдаг. Тэгэхээр энэ нэрээр нь заасан асуудал нь эргээд тэр судалгаанаас өөр судалгаануудыг хийж болохгүй юм шиг ийм төөрөгдлийг төрүүлээд байдаг. Тэгэхээр нэрээр нь хуулиар заахаасаа илүүтэй арга зүйн зөвлөл болон Статистикийн зөвлөл энэ асуудлуудаа ярьдаг, эргээд нийгэм, эдийн засгийн чухал судалгаануудыг төсвийг нь хасах гээд байдаг. Тэгэхээр чинь тэр бага төсвөөр тухайн судалгаагаа хийж чадахгүй шүү дээ. Тэгэхээр хүрэлцээтэй байх ёстой гэдэг нь тэр мэргэжлийн ажлыг явуулахад, судалгааг хийхэд мөнгө нь хүрэлцээтэй байх ёстой гэдэг л ийм санаа орж ирж байна гэсэн үг. Зүгээр цалин хөлсний хувьд та бас ярилаа. Сумдад бол манайх орон тоо байхгүй шүү дээ. Статистикийн байгууллагын орон тоо байдаггүй байхгүй юу. Тэгээд хавсарч байгаа өмнө нь 20 хувийн нэмэгдлийг өгдөг байсан юм. Аймар ачаалалтай шүү дээ тэр хүмүүс чинь..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хариуллаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг .... эхлээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн алга байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн индрийн 1 дүгээр микрофон дээрээс үг хэлнэ.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу. Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж байгаа энэ үед 1 зүйл онцлон хэлье. Улсын хөгжлийн бодлого, төсөв, салбарын төлөвлөлт,

хэрэгжилтийн үнэлгээ бүгд үнэн зөв, бодит, цаг үеэ олсон мэдээлэл дээр тулгуурлах ёстой. Эрүүл мэнд ч, боловсрол ч, нийгэм хамгаалал ч, эдийн засаг ч бүх зүйл дээр тэр. Статистикийн тухай хуулийн энэ найруулгыг хэлэлцэж байх үед дата тэгээд бас олон жил энэ дээр ажиллаж байсан судлаач багш хүний хувьд аливаа бодлогыг бид нар зөвхөн зорилго, төсөв, хийсэн ажлаар нь биш бодит үр дүнгээр нь дүгнэх зайлшгүй шаардлагатай байдаг. Үүний тулд үнэн зөв, бодитой, хараат бус харьцуулж болохуйц энэ статистик маш чухал байр суурийг эзэлдэг. Ийм мэдээлэл бид нарт хэрэгтэй. Тэгэхээр мэдээллийг хэрхэн цуглуулсан юм, арга зүй нь зөв юм уу, үр дүнг нь бие дааж тайлбарлаж болох юм уу. Энэ нь шийдвэрийн чанарт шууд үр дүнгээ үзүүлдэг. Магадгүй энэ мэдээ мэдээллийг бид нар хагас дутуу, чадахгүй, мэдэхгүй, ойлгохгүй, ач холбогдол өгөхгүйгээсээ болж одоо хүртэл гаргаж байсан шийдвэрүүд нь амьдрал дээр хөрсөн дээр буухгүй буруу зөрүү асуудлуудад шийдвэрийг гаргадаг байх гэж би бодож байна.

Одоогийн энэ хууль нь 1997 оноос хойш олон удаа нэмэлт, өөрчлөлтөөр шинэчлэгдсэн гэсэн ч өнөөгийн өгөгдөл, мэдээллийн орчин болон бодлого төлөвлөлтийн хэрэгцээг бүрэн зохицуулах энэ шаардлага яах аргагүй бий болсон байна. Иймээс статистикийн тогтолцоо, мэдээллийн эх үүсвэр, чанарын хяналт, нууцлал байгууллагуудын үүрэг хариуцлагыг нэг мөр болж зорилгыг нь хуулиа шинэчлэн найруулах нь бол яах аргагүй зүйтэй санагдаж байна.

Энэ төслийн чухал ач холбогдол нь ҮСХ-ны мэргэжлийн хараат бус байдлыг баталгаажуулах. Энэ бол маш чухал. Статистикийн мэдээллийг боловсруулах, нийтлэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс огт нөлөөлөхгүй байх. Магадгүй улс төрийн нөхцөл байдлаас хамааraад шаардлагатай мэдээ, мэдээллийг хэлэхгүй цаг тухайд нь, эсвэл нуун дарагдуулах, эсвэл орхигдуулах, эсвэл зүгээр чимээгүй өнгөрөх гэх мэтчилэн эдгээр нөлөөллөөс сэргийлэхэд оршиж байна.

Мөн төрийн байгууллагуудын мэдээллийн санг статистикийн зорилгоор ашиглах зохицуулалт нь давхардсан тайлан судалгааг нь багасгах, шийдвэр гаргалтад хэрэгтэй мэдээллийг шуурхай, чанартай, сайн гаргах. Эдгээр одоо боломжийг бий болгох. Гэхдээ мэдээж бас саяын гишүүдийн хэлээд байгаа санал шүүмжлэлтэй бол санал нийлж байгаа. Мэдээлэл солилцох, өгөгдлийг ашиглах эрхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ иргэн, хувь хүн, аж ахуйн нэгжийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг бодитоор зайлшгүй хамгаалах шаардлагатай. Энэ дээр засаж сайжруулах хэрэгтэй зүйлүүд харагдаж байна. Энэ анхдагч мэдээллийг зөвхөн статистикийн зорилгоор ашиглах, хэнд ямар журмаар хандахыг тодорхой болгох, зөрчилд хүлээлгэх хариуцлагыг бүр сайн оруулахыг онцгой анхаарч, ажлын хэсэг дээр нь нэмж ажиллуулах төслийн санаачлагчид хүсье. Тийм шаардлага тавья.

Төслийн үзэл баримтлалыг бол дэмжиж байгаа. Хэлэлцүүлгийн явцад хараат бус байдал, мэдээллийн нууцлал, хэрэгжилтийн хяналтыг улам тодорхой болгох, батлагдсан хууль нь бодитой, найдвартай статистикт суурилсан энэ бодлогыг боловсруулах нөхцөлийг бүрдүүлнэ үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Отгоны Саранчулуун гишүүн индрийн 1 дүгээр микрофоноос үг хэлнэ.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу. Миний хувьд энэхүү Статистикийн тухай хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ санал бас байна. Энэхүү хууль дээр 3.1.19, 5.1.3, 7.1.9, 25.4.2 зэрэг заалтуудад хүртээмжтэй байх тухай асуудлуудыг оруулсан байгаа. Ямар хүртээмж ярьж байгаа вэ гэхээр статистикийн мэдээлэл, үйлчилгээ, харилцааг хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хэрэглэх, хүлээн авах, ашиглах боломжийг хангасан байх тухай хэлбэрийн тухай заасан байгаа. Бусад заалтууд дээр статистикийн мэдээллийн арга зүй, мэдээлэл цуглуулах үйл явцад хүртээмжийг хангахтай холбоотой асуудал, хэрэглэгчийг мэдээллээр хангахтай холбоотой, хэрэглэгчийн саналыг авах зэрэг дээр мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр тархах тухай саналуудыг оруулж, энэхүү хуулийн төсөлд бас оруулсан.

Энэ нь ач холбогдлын хувьд яг ямар зүйлийг авчрах гээд байгаа вэ гэхээр богино хугацаанд Статистикийн үндэсний хороо болон холбогдох байгууллагууд бидний мэддэг 1212.mn аппликэйшнүүд тайлангуудаа олон улсын цахим хүртээмжийн стандартыг тохируулан шинэчлэх шаардлагыг үүсгэж байгаа гэсэн үг. Энийг дагаад цахим хүртээмжийн зардал, тохируулга нэмэгдэх хэрэгтэй болно. Ингэж байж бид нарын саяын ярьсан хуулийн заалтууд амилна.

2 дугаарт нь формат хэрэгслийн бэлтгэл хэрэгтэй болно. Жил бүрийн тооллого судалгааны агуулгуудыг брэйл, аудио, хялбаршуулсан текст болон дохионы хэлний хэлбэрт оруулах ажлуудыг эхний 1-3 жил хийж байж энэ үйл явц, шилжилт амжилттай болно.

3 дугаарт нь Статистикийн үндэсний хороо, статистикийн ажилтнууд, тоологчдод зориулсан үе шаттай сургалт хэрэгтэй болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс мэдээлэл цуглуулахдаа боломжит зохицуулалтыг хийх, хэрхэн яаж харилцах талаар сургалтууд явуулах ажлууд энэ хуулийн дагуу эхний 3 жилд бол батлагдвал шаардагдах нь.

Урт хугацаанд ямар үр дүн гарах вэ гэдгийг харъя. 3-10 жилийн хугацаанд бид нар арай илүү нотлох баримтад суурилсан бодлого боловсруулах боломжтой болно. Өнөөдрийг хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх тоо баримт ойлгомжтой тодорхой бас биш байгаад байна. Энэ нь өөрөө тэдэнд чиглэсэн нийгэм, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг оновчтой хуваарилах хэрэгжүүлэхэд саад болдог учраас. Тэгэхээр энэ нь хэрэгтэй.

2 дугаарт нь мэдээллийн тэгш бус байдал Монголд бий болсон. Хаа сайгүй байдаг. Тэгэхээр энэ нь өөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэм, эдийн засгийн мэдээллээс хоцрохгүй байх боломжийг үүсгэж байгаа. Хэрвээ энэ шилжилтийг хийж чадах юм бол улс орны хөгжлийн явцад шийдвэр гаргалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо сайжрах ийм боломжтой харагдаж байгаа.

3 дугаарт нь институцийн соёл бас өөрчлөгдөнө. Мэдээллийн хүртээмжийг тусгайлан үзүүлж байгаа халамж биш гэж харах хэрэгтэй. Төрийн үйлчилгээ өөрөө заавал байх ёстой стандарт учраас энэ хандлагыг бүх шатанд тогтоосон ийм өөрчлөлтийг бас авчрах боломжтой юм.

Ер нь бол жил болгон бид нар мэдээлэл өгч, авдаг хэрэглэгч байна. Эдгээр хүмүүст бол хамгийн том боломжит өөрчлөлтүүд, саадгүй оролцог бий болгоно.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, хүн ам орон сууцын тооллого зэрэгт оролцохдоо хараа, сонсгол эсвэл хөдөлгөөний бэрхшээлээс хамааран гадуурхагдахгүй байх нөхцөлийг нөгөө талдаа өөрт тохирсон хэлбэрээр мэдээлэл авах боломжийг өгч байгаа гэдэг агуулга нь энэ хуульд тусгасан учраас миний хувьд энэ хуулийн дэмжиж байна.

Бас 1 зүйл нь бол боломжит зохицуулалт буюу бэрхшээлтэй мэдээлэгчийн онцлогт тохируулж мэдээлэл авах, тухайн цаг хугацааг уян хатан тооцох, гэрт нь тохиромжтой хэлбэрээр очих тэр боломжууд бүрдэнэ гэсэн үг. Эдгээр зүйлүүдийг энэхүү хуулийг дагасан зохион байгуулалт зардал дээр бас нэмж оруулах хэрэгтэй болчихно гэсэн үг. Энэ бүх үр нөлөөнүүд нь ямар хэрэгтэй юм бэ гэхээр Монгол Улс 2009 онд НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нэгдэж орсон. Ингэж орсныхоо дагуу хуулийн эдгээр заалтууд нь уг конвенцын дараах зүйл заалтуудад шууд биелж байгаа эрх зүйн баталгааг үүсгэж байгаа. Конвенцын 31 дүгээр зүйл статистик ба мэдээлэл..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Түрүүн Энхтүвшин гишүүний хэлээд байсан бас энэ хууль өргөн барих үйл явц дээр бас тодорхой асуудлууд гарсан. Бямбадулам дарга аа, Тамгын газрын дэд дарга Бямбадулам дарга аа, Энхтүвшин дарга бас тодорхой асуудал гишүүн яриад байна лээ шүү дээ. Яг өргөн барьснаасаа өөр өөр агуулгатай зүйлүүд орж ирсэн. Бас янз янзын асуудлууд байна гээд. Тэгээд энэ дээр чинь сая Лодойсамбуу гишүүн ч гэсэн хэлж байна. АН-ын гишүүдийн өргөн барьсан хууль болохоор ерөөсөө болохгүй байна гээд буцаагаад л байдаг. Гэтэл ийм зөрчлүүдтэй асуудлууд орж ирсэн энэ хуулийг өргөн бариад хэлэлцээд явчихсан байх жишээтэй. Тийм учраас энэ дээрээ бас жоохон анхааараарай гэдгийг бас хэлье.

Тэгээд хэлэлцүүлгийн явцад бас тодорхой энэ чинь хууль өргөн барих эрх нь бүгдээрээ энэ Ариунзаяа гишүүнд байгаа тэгэхдээ энийг хэлэлцээд зөв болгоод явах нь бол Их Хурлын парламентын бас үүрэг юм гэдгийг хэлье. Яг өргөн барих үйл явц дээр бас 2 нүүр гаргаад байгаа тал байгаа шүү гэдгийг хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг 13 цагаас нэгтгэж явуулна.

12.09 цаг.

3 дугаар асуудал.

Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Энхцэцэг: Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Улсын Их Хурал дээр 18 гишүүд оролцсон ажлын хэсэг байгуулаад, Дулаан хангамжийн тухай анхдагч хуулийг боловсруулж 31 гишүүд өргөн бариад байна. Эрчим хүчний салбар нь өнөөдөр Эрчим хүчний тухай хууль гээд 2001 он буюу 25 жилийн өмнө батлагдсан хуулиар харилцаагаа зохицуулж байна. Энэ хууль нь нийтдээ 15 удаагийн өөрчлөлт буюу 53 хувьд нь өөрчлөлт орогдсон. Хуулийн 40-

өөд хувь нь зөвхөн тусгай зөвшөөрлийн тухай байдаг. Мөн хуульд дулаан хангамжийн тухай зохицуулалт 5 хувьтай байдаг. Өөрөөр хэлбэл дулаан хангамжийн салбарт зохицуулагдаагүй харилцаа асар их байдаг.

Дээрээс нь энэ хууль нь маш ерөнхий зохицуулалттай учраас дулаан, цахилгаан хангамжийн салбар маань нийтдээ 800 гаруй журмаар бол харилцаагаа зохицуулж байна. Харилцаагаа журмаар зохицуулдаг салбарыг зохицуулалтын хувьд тогтворгүй эрсдэлтэй гэж үзээд хөрөнгө оруулалт оруулдаггүй. Дээрээс нь хэрэглэгчээс нь авхуулаад дамжуулах, түгээх сүлжээ, хөрөнгө оруулагч хүртэл тасралтгүй хүндрэл бэрхшээлтэй тулгарч, гомдол санал их гардаг ийм асуудалтай байдаг юм байна. Тийм учраас эрчим хүчний тухай хуулийг цаашдаа бол эрчим хүчний ерөнхий хууль, түүний доор Цахилгаан хангамжийн тухай хууль, Дулаан хангамжийн тухай хууль, Хийн хангамжийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль гэсэн 5 багц хуультай байхаар шинэчлэх нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Ингээд бид бүхэн цаашдаа бол цахилгаан хангамжийн тухай хуулийг боловсруулж, цахилгаан хангамжийн өрсөлдөөнт бөөний зах зээл рүү шилжих ёстой. Мөн одоо хийн хангамжийн хуультай болох ёстой. Одоогоор бол Сэргээгдэх эрчим хүч хэмнэлтийн тухай хууль байдаг.

Ингээд Дулаан хангамжийн тухай хуулийг бид бүхэн боловсруулахын тулд бусад улсын туршлагыг бол судалсан байгаа. Тухайлбал манай улс оронтой яг ижилхэн хүйтэн уур амьсгалтай, хэрэглэгчээ дулаан цахилгаанаар хангах шаардлагатай энэ орнуудын хууль эрх зүйн орчныг Казакстан, Дани, Унгар, Эстони гээд ийм 4 улсыг судалж үзэхэд, энэ улсууд маань бие даасан дулаан хангамжийн хуультай, бие даасан цахилгаан хангамжийн хуультай.

Дээрээс нь энэ хуулиуд нь бүгд процессын зохицуулалттай буюу харилцаагаа журмаар биш хуулиар зохицуулдаг ийм орнууд байсан. Энэ тохиолдолд тэр хөрөнгө оруулалтыг татах хүндрэл бэрхшээлтэй тулгарах нь бага байдаг байх нь. Зохицуулалтын хувьд бол тогтвортой салбар гэж үздэг байх нь.

Ингээд дулаан, цахилгаан 2 маань яагаад тусдаа зохицуулалттай байх ёстой юм бэ гэхээр дулаан бол орон нутгийн шинж чанартай. Өөрөөр хэлбэл тухайн 1 эх үүсвэрээс тухайн сумыг, тухайн бүсийг, тухайн аймгийг хангадаг бол цахилгаан бол системийн хэмжээнд улс орны хэмжээгээр яригддаг. Дээрээс нь дулаан хангамжийн асуудал бол зөвхөн өвлийн улиралд борлуулалт байгаад бүх улирлуудад борлуулалт байдаггүй учраас үнэ тарифыг нь зохицуулж амьдруулдаг ийм салбар бол цахилгаан хангамжийн хувьд бол цаашдаа өрсөлдөөнт бөөний зах зээл буюу зах зээлийнхээ зарчмаар явдаг ийм систем рүү орох ёстой гэх мэтчилнээр олон шалтгааны улмаас зохицуулалтын хувьд энэ хоёр маань тусдаа байх бүрэн боломжтой байдаг учраас бусад улсууд энийг хэрэгжүүлээд явдаг юм байна.

Ингээд бид бүхэн дулаан хангамжийн асуудлыг бие даасан хуультай болгох гээд нийтдээ 12 бүлэгтэй ийм хуулийг 2025 оны 4 сард боловсруулаад, нийтдээ 34 удаагийн 2000 гаруй оролцогч давхардсан тоогоороо оролцогч талуудад хэлэлцүүлэг хийгээд, 159 компаниуд руу албан бичиг хүргээд, давхацсан тоогоороо 800 гаруй санал ирүүлээд, үүний дагуу дулаан хангамжийнхаа хуулийг сайжруулаад өргөн барьсан байгаа. Ингээд нийтдээ 12 бүлэгтэй.

Дулаан хангамжийн талаар төрийн хүлээх нийтлэг үүрэг, дулаан хангамжийн үйл ажиллагаа, дулаан хангамжийн систем, ангилал, дулаан хангамжийн сүлжээнд холбох тоолуурын систем, үнэ тариф хэрэглэгчийн гэрээ дулаан хангамжийн салбарт үзүүлэх төрийн дэмжлэг, техник технологи, норм стандарт, аюулгүй байдлын шаардлага, хяналт шалгалт бусад гээд ингээд нийтдээ 12 бүлэгтэй хуулийг өргөн бариад байна. Дулаан хангамжийн салбарын бодлого төлөвлөлтөд төрийн байгууллагууд маань ямар үүрэг, ямар хариуцлагыг үүрээд явж байх ёстой. оОрон нутгууд маань ямар ажлуудыг хийгээд явж байх ёстой юм бэ. Бодлого, төлөвлөлт, хэрэгжилт дээр гэдэг тусгайлан зохицуулж өгсөн байгаа.

Дээрээс нь дулаан хангамжийн системийн хувьд бид бүхэн зөвхөн төвлөрсөн дулаан хангамжийн системийн талаар бид нар мэднэ. Одоогийн хууль дээр байдаг. Тэгвэл энэ хууль дээр хэсэгчилсэн дулаан хангамж, бие даасан дулаан хангамж гэдэг 2 том ойлголт шинээр орж ирж байгаа. Хэсэгчилсэн дулаан хангамж гэдэг нь төвлөрсөнд холбогдох боломжгүй, тухайлбал жишээ нь Ургах наран хороолол ч юм уу. Энэ тохиолдолд хэсэгчилсэн гэж байгаа. Бие даасан гэдэг нь та зөвхөн өөрийнхөө гэр оронд зориулаад эсвэл өөрийнхөө үйлдвэрт зориулаад дулаан хангамжийн байгууламж бариад ажиллахыг бол бие даасан гэж байгаа. Тэгэхээр энэ хэсэгчилсэн болон бие даасан 2 дээр төрийн оролцоог ерөөсөө байхгүй болгоё. Хувийн хэвшил энэ дээр одоогийн хуулиар бол та зөвхөн өөрийнхөө үйлдвэрт зориулаад дулаан хангамжийн эх үүсвэр барьсан ч ТЭЗҮ хийлгэ, тэдэн 100 сая, тусгай зөвшөөрөл ав, тэдэн 100 сая гэдэг. Энэ хууль дээр бол энэ хэсэгчилсэн бие даасан 2 дээр бол ерөөсөө хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлье, төр оролцохоо больё гэж байгаа. Энэ тохиолдолд бид нар олон мянган хэрэглэгчийг дулаанаар хангаж чадахгүй байгаа. Энийг хувийн хэвшлийнхэн маань хийгээд явах юм байна. Ийм боломж бололцоог нэмэгдүүлж байгаа гэж ингэж харж байгаа.

Түүнээс гадна дулаан хангамжийн системийн үйл ажиллагаа үйлдвэрлэх, дамжуулах, түгээх энэ хангах үйл ажиллагааг бол маш нарийвчлалтайгаар тодорхой болгож энэ хууль дээр оруулж өгсөн. Түүнээс гадна дулаан хангамж хэмжээнд сүлжээнд холбогдоно гэдэг нь бас асар хүндрэлтэй асуудал байдаг.

Одоо бол зөвхөн энэ маань журмаар явдаг. Хууль дээр бол ганцхан журмыг батална гэсэн ганцхан өгүүлбэр байдаг. Дээрээс нь дулаанд холбоход 100 мянган төгрөгийн хураамж л хураана. Тэгээд далд төлбөр асар их хэмжээгээр байдаг. Тэгвэл энэ хууль дээр бол техникийн нөхцөлийг авах, дулаанд холбох хүсэлт, дээрээс нь дулаанд холбох тэр өртгийн хэмжээг, зардлын хэмжээг яаж тооцоолж тов тодорхой байх ёстой юм бэ. Дээрээс нь хувийн сүлжээ ямар тохиолдолд нийтийн сүлжээ болж хувирах вэ гэдэг ийм зохицуулалтуудыг нэлээн нарийвчилж оруулж ирсэн.

Үүний дараа тоолуур, тоолуурын систем. Өнөөдөр бид бүхэн бол дулаанаа метр квадрат, метр кубээр тоолдог. Энэ бол асар их хэмжээний хүндрэлийг учруулж байгаа.

1 дүгээр асуудал нь үнэхээр та бүхэн бодит дулаан хэрэглэсэн төлбөрөө төлж чадахгүй байгаа. Магадгүй та өвлийнхөө улиралд 2 сараар гадаад явж болно. Тэр тохиолдолд метр квадратаар таны дулааны төлбөр гүйгээд явж байдаг.

2 дугаар асуудал нь бид нар тохируулж чадахгүй учраас асар өндөр үнэтэй үйлдвэрлэсэн дулаанаа цонхоо онгойлгоод, порчикоо онгойлгоод дулааныг асар их хэмжээгээр хэмнэхгүй алддаг.

Дараагийн 1 асуудал нь нэгэнт метр квадратаар тоолж байгаа учраас нөгөө байшингаа дулаалах асуудлыг ерөөсөө эдийн засгийн хөшүүрэг байдаггүй гэх мэтчилнээр олон дутагдалтай зүйлүүд байгаа учраас бид бүхэн цаашдаа бол дулааныг тоолж байх ёстой. Тоолж байж бид нар хянаж чадна, хэмнэж чадна, тохируулж чадна. Үүний үндсэн дээр асар их хэмжээний дулааны нөөц бий болно. Хэрэглэгч маань бодитой хэрэглэсэн дулааныхаа төлбөрийг төлдөг болно гэсэн ийм асуудлуудыг бол нэлээн нарийвчилж зохицуулж өгч байгаа.

Дараагийн 1 асуудал болохоор үнэ тарифын асуудал. Үнэ тариф дээр одоо үнэ тарифыг бодох олон төрлийн зохицуулалтууд байдаг. Одоогийн хууль дээр бас яг адилхан журмаар зохицуулна л гэсэн байдаг. Энэ хууль дээр бол үнэ тарифыг ямар аргачлалаар тооцож байх юм, ямар ямар асуудлыг авч үзэх ёстой юм, тэр хүний нөөцтэй холбоотой, хөрөнгө оруулалттай холбоотой, ашиглалтын зардал, урсгал зардалтай холбоотой асуудлуудыг яаж тусгаж байх ёстой вэ гэдэг нарийн зохицуулалтуудыг оруулж ирсэн.

Дээрээс нь дулаан хангамж маань нэгэнт зохицуулдаг салбар учраас зохицуулалттай үйлчилгээний санхүүгийн хөтөлдөг стандарт гэж тусгайлан байдаг юм байна. Өөрөөр хэлбэл тэр хөрөнгө оруулалт нь бодитой юм уу, зардал нь бодитой юм уу гэдгийг хянахын тулд санхүүг нь тодорхой стандарттай байдаг юм байна. Энийг бас тодорхой оруулж өгсөн. Дээрээс нь зохицуулалттай үйлчилгээний аудит гэдэг тусгайлан юм байдаг. Тэгэхээр энэ аудитын асуудлыг бас тусгайлан энэ хууль дээр ингээд зохицуулж оруулж өгсөн байгаа. 1 тусгай оруулж ирсэн юм юу вэ гэхээр дулаан хангамж гэдэг асуудал дээр бол орон нутгийн оролцоо бол маш өндөр байдаг юм байна. Орон нутаг маань 5 жил тутамдаа тэр орон нутгийнхаа бүс болгоныг яаж дулаанаар хангах юм бэ, ямар эх үүсвэр барих юм бэ ямар шугам сүлжээ барих юм бэ гэдгийг тэр хот төлөвлөлттэйгөө, зам талбайтайгаа, барилга байгууламжтайгаа уялдуулаад, төлөвлөөд, хэрэгжүүлээд явах энэ үүрэг нь орон нутгийн засаг заргаа, иргэдийн Төлөөлөгчийн Хурал дээр маш тодорхой болж ингээд зохицуулалтаар бол энд орж ирж байгаа. Тэгээд орон нутгууд маань 5 жилийн хугацаанд дулаан хангамжийнхаа хөгжлийн схемийг боловсруулаад, иргэдийн Төлөөлөгчийнхөө Хурлаар батлуулаад ингээд ажиллаж байх ёстой гэдэг асуудал энэ дээр тусгагдсан байгаа.

Түүнээс гадна дулаан хангамжийн салбар дээр төрийн дэмжлэг чухам ямар байх ёстой юм бэ. Мэдээж эх үүсвэрийн хувьд бол хувийн хөрөнгө оруулалтыг бол бид нар татахаар маш нээлттэй оруулж өгч байгаа. Тэгвэл яг үндсэн судас буюу шугам сүлжээнийхээ асуудлыг дэмжих дээр шугам сүлжээнийхээ асуудлыг хэрвээ өртгөөрөө нөхөж чадахгүй бол, тарифаараа нөхөж чадахгүй бол төрийн татаасаар, төрийн хөрөнгө оруулалтаар нөхөхөөс аргагүй байдалд орно. Тэгэхээр энийг бас ингээд нэлээн нарийвчлалтай байдлаар ингэж тусгаж ингэж оруулж өгсөн байгаа.

Ингээд дулаан хангамжийн олон тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, дулаан хангамжтай холбоотой олон харилцааг нарийвчлан зохицуулсан ийм журмын тоог цөөлөх, тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх ийм анхдагч хуулийг Улсын Их Хурлын 18 гишүүн, 31 гишүүн, дээрээс нь ЭХЯ, Улаанбаатар дулаан

түгээх, дулаан дамжуулах сүлжээ, дулааны станцууд, мөн салбарын төрийн бус байгууллагын олон мэргэжлийн хүмүүс оролцож, бараг жил гаруй хугацаанд боловсруулаад, салбартаа хэлэлцүүлээд, өргөн бариад энэ хуулийг та бүхэнд хэлэлцүүлэхээр оруулж ирж байна.

Ийм учраас эрхэм гишүүд минь ээ,

Дулаан хангамжийн асуудал бол бид нарын тулгамдсан асуудал. Ийм учраас энэ хуулийг дэмжиж баталж өгөөч гэж хүсье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 31 гишүүн 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Эрчим хүчний тухай хууль 2001 онд батлагдсанаас хойш 15 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч дулаан хангамжийн салбарын бодлого, төлөвлөлт, байгууллагуудын чиг үүрэг, хөрөнгө оруулалт, үнэ тариф, сүлжээний холболт, тоолууржуулалт, аюулгүй ажиллагаа, хяналт шалгалтын харилцааг цогцоор зохицуулах хэрэгцээ шаардлага байгааг харгалзан салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг дэмжих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, төрийн зохицуулалт, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор бие даасан Дулаан хангамжийн тухай хуультай болох шаардлагатай гэж үзлээ.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээдээс шууд гарах зардал үүсэхгүй гэж тооцсон байна. Харин үйлчилгээ үзүүлэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс болон улс, орон нутгийн төсвөөс техник тоног төхөөрөмж, мэдээллийн нэгдсэн систем, хөгжлийн схем хөгжүүлэхэд шаардлагатай тодорхой зардлууд гарахаар тооцсон байна.

Уг хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат дулааны эрчим хүчний хэмнэлт, хөрөнгө оруулалтын тооцоо, барилгыг дулаан хангамжид холбох зөвшөөрлийн үйл явцын хүндрэл, салбарын ажилтнуудын нийгмийн баталгаа, хэрэглэгчийн дулааны хэрэглээг тоолуураар зохицуулах боломж болон тарифын индексжүүлэлтэд үйлдвэрлэлийн зардал, цалингийн өсөлтийг хэрхэн тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл дулааны эрчим хүчийг дамжуулан худалдах хувийн дулааны шугамын өмчлөл, ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой зохицуулалт, дулааны шинэ эх үүсвэр болон инновацыг дэмжих эрх зүйн орчин, салбарын улс төрийн нөлөөлөл, боловсон хүчний томилгооны асуудал, дулааны эх үүсвэрийг

нэмэгдүүлэх монополыг хязгаарлах талаар хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Дулаан хангамжийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлд Улсын Их Хурлын бүрэн эрхийг тусгасан үндэслэл, хэсэгчилсэн болон бие даасан дулаан хангамжийн зохицуулалтын уялдаа, үнийн гомдол шийдвэрлэх босго нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад үзүүлэх нөлөө, 6 дугаар цахилгаан станцын байршил болон аж үйлдвэрийн парктай уялдуулах боломж, эрчим хүчний салбарын удирдах ажилтны томилгоонд улс төрийн намын нөлөөлөл байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон хэрэглэгчдийн тоолуурын хамрагдалт, төвлөрсөн холболтоос салгах нөөц бололцоо, эрчим хүчний хэмнэлт гаргасан хэрэглэгч, аж ахуйн нэгжийг урамшуулах механизм, хэсэгчилсэн болон бие даасан дулаан хангамжийн давуу тал, саарал усны ашиглалт болон Барилгын тухай хууль, Усны тухай хууль зэрэг холбогдох хуулиудтай уялдуулах, дулааны шугам сүлжээний шинэчлэлийн санхүүжилт, бодит өртөг төвлөрсөн дулаан хангамжийн хот төлөвлөлтөд үзүүлэх нөлөөллийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл дулаан хангамжийн салбарын дамлан худалдах үйл ажиллагаа зөвшөөрөлтэй холбоотой ашиг сонирхлын зөрчил, улс төрийн нөлөөлөл болон уурын зуухны өмчлөл ашиглалттай холбоотой асуудлыг судалж шийдвэрлэх чиглэлээр Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг байгуулах санал гаргаж, уг ажлын хэсэгт ажиллах хүсэлтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд сум, багийн жижиг уурын зуухыг хувийн хэвшилд шилжүүлснээс үүдэн гарч буй өндөр өртөг, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх, цөөн хүн амтай сумтай дулаан хангамжийн тогтвортой ажиллагааг хангах, шаардлагатай тохиолдолд төрөөс татаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг анхаарч үзэх талаар байр сууриа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулахад Дулаан хангамжийн тухай хуулийн төслийг 68 хувиар, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 68 хувиар, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 68 хувиар, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 64 хувиар, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 68 хувиар тус тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Мягмарын Доржпалам “УБДС” ТӨХК-ийн Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга, Батбуянгийн Эрдэнэбаяр “УБДС” ТӨХК-ийн Техник, төлөвлөлтийн хэлтсийн

дарга, Рагчаасүрэнгийн Батмөнх Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн төрийн өмчит үйлдвэрийн газрын зөвлөх инженер, Хоролын Эрдэнэчулуун Монгол Улсын зөвлөх инженер.

Энэ дулааны сүлжээ компанийн ерөнхий захирал нь яагаад ирээгүй юм. Хэлэлцүүлгийн явцад энэ хүнийгээ уриарай. Энэ чинь хэлтсийн дарга нар байгаад байна. Эрчим хүчний сайд, ТНБД бас байх ёстой. Өөрөөр хэлбэл яг энэ дулааны станцтай холбоотой маш их тийм авлига, хээл хахуулийн асуудал яригддаг. Энэ дээр бас тодорхой асуултуудыг дараа нь хэлэлцүүлгийн явцад 2 дугаар хэлэлцүүлэг дээр асууна шүү.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүн Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв хариулах үүрэгтэй. Хэрвээ худал мэдээлэл өгсөн бол хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Одоо Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Бас ийм чухал хууль оруулж ирж байгаад талархалтай байгаагаа илэрхийлмээр байна. Энхцэцэг гишүүн болоод салбарынханд. Маш олон асуудлууд байдаг. Тэгээд энэ хуулийн төслөөр их олон асуудлуудад бас хариулт хайж, шийдэл хайж, бас тодорхой хэмжээгээр шийдлээ санал болгож оруулж ирж байгаа гэж ойлгож байна. 2 асуултад хариулт авмаар байна.

1 дүгээрт энэ хэр их хэмнэлт хийх вэ. Метр квадратаар биш тоолууруар тоолдог болох гээд байна. Тийм ээ. Тэгэхээр тоолууруар тоолдог болсноор энэ дулаан үйлдвэрлэгчид, ДЦС-ууд хэмнэлтээ магадгүй цаашдаа ашигтай, үр ашигтай байх нөхцөл байдал бүрдэх юм байна гэж ойлгоод байгаа. Тэгэхээр энэ дээр тооцоолол хийж үзсэн үү. Хэр их хэмнэлт хийх боломжтой вэ. Цаашдаа ашигтай ажиллах ямар ямар боломжууд нээгдэж байгаа вэ. 1 дүгээрт.

Нөгөө талдаа дулаан хэрэглэгчид буюу айл, өрхийн дулааны сар болгон төлдөг зардалд ямар өөрчлөлт орох вэ. Ийм тооцоолол хийж үзсэн үү. Өөрөөр хэлбэл метр квадратаараа сард тодорхой хэмжээний 50 юм уу, 100м2-тай байртай айл байлаа гэхэд сард тэдийг төлж байлаа гэж үзэхэд тоолууртай болсноор хэдийг төлдөг болох вэ. Тэр чинь өөрсдөө зохицуулж болдог учраас зүгээр миний ойлгож байгаагаар хэмнэлт хийх боломж айл өрхөд ч гэсэн гарч ирэх юм шиг санагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр бас яг мэргэжлийн байгууллага маань, хүмүүс маань бас тооцоолол хийж үзсэн болов уу. Ард иргэд ч гэсэн бас энэ хууль батлагдсантай холбоотойгоор, тоолууртай болсонтой холбоотойгоор бас өрхийн төсөвт нь тодорхой хэмжээгээр нь хэмнэлт үүсэх юм уу. Эсхүл нэмэгдэл төлбөр үүсэх юм уу, ямар юм болох юм гэдэг ийм асуултыг бас сонирхож байгаа болов уу гэж бодож байна.

Түүнчлэн, тоолууртай болох, айл өрх болгон тоолууртай болох гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар зардал гарах вэ. Тоолуур нь ямар үнээр байх юм. Айл

өрхүүдийг бүгдийг нь тоолууртай болгоно гэхээр тэрийг хаанаас хариуцаж, хэн хийх юм. Айл өрхүүд өөрсдөө тоолуурынхаа мөнгийг гаргаад тавиулах юм уу. Энэ дээр бас хариулт авмаар байна.

Дараагийн 1 зүйл юу вэ гэхээр мэргэжлийн байгууллагууд ямар байр суурьтай хандаж байгаа вэ. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юу. Хэдэн зуун мэргэжлийн байгууллага байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр хууль санаачлагч маань мэргэжлийн байгууллагынхаа саналыг хэрхэн тусгасан бэ. Саналыг хэрхэн авсан бэ. Яагаад гэхээр D-Parliament.mn дээр бол нэг их олон санал ирээгүй харагдаад байна. Гэтэл бол их олон байгууллагууд байгаа гэж ойлгож байгаа. Тэр байгууллагууд маань хэрхэн дэмжиж санал нэгдэж, эсхүл магадгүй эсэргүүцэж, эсэргүүцэх байр суурия илэрхийлж байгаа вэ. Тэр саналуудыг нь хэрхэн тусгасан бэ гэдгийг тодруулмаар байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ. Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Би хариулаад, нэмэлтээр бас ажлын хэсэг хариулъя. Дулааныг бид нар метр квадрат, метр кубээр хэмждэг байсныг болиулаад дулааны тоолууртай болсноор асар их хэмжээний хэмнэлт гарна.

1 дүгээр том хэмнэлт бол яах вэ гэхээр эрчим хүчний дулааны эх үүсвэр маш их хэмжээний хэмнэлт гарч ирнэ. Эх үүсвэр бий болно. Энэ дээр би 1 жишээг авах их дуртай л даа. Жишээ нь, Эрдэнэтийн цэвэрлэх байгууламж бүр ингээд халиад урсаад, бараг шинэ цэвэрлэх байгууламж барья, өргөтгөе гэдэг асуудал ярьж байсан. Бүх айлуудад тоолуур тавьсан. Нөгөө цэвэрлэх байгууламж нь бүр ингээд дундраад явчихсан. Яг үүнтэй адилхан бид бүхэн дулааны тоолууртай болсноороо дулаатай болсноороо дулааныг балансслуулаад, тэр станцаас гарахдаа ямар дулаан гарч байгаа, дамжуулахаас гарахдаа хэд гарч байгаа, түгээхээс гарахдаа хэд очиж байгаа, хэрэглэгч дээр очихоор хэд болж байгаа гэдгийг балансслуулснаараа бол дулааны асар их хэмжээний хэмнэлт бий болно, эх үүсвэр бий болно гэж байгаа юм.

2 дугаар асуудал болохоор мэдээж хэрэглэгч маань яг бодит хэрэглэсэн дулааныхаа л төлбөрийг төлнө. Одоо бол бодит бусаар төлдөг байх нь байна шүү дээ. Та жишээ нь ингээд гэрээ түгжээд хэдэн сараар гадагшаа явчихсан байхад метр квадратаар үржигдээд л мөнгөө авдаг байх нь.

Дээрээс нь та бүхэн мэдэж байгаа. Хөдөө, орон нутагт энэ дулааны эх үүсвэрүүд яадаг вэ гэхээр аж ахуйн байгууллагуудаас 1м3-ээр нь үржүүлж авчхаад л тэрэндээ бүр санаа амарчхаад, хувийн хэвшлүүдийг, хувь хүмүүсийг дулаанд холбодоггүй асуудал маш их гардаг. Тэгэхээр өөрөөр хэлбэл тэр дээр бодит бус дулааны өртөг явагдаад байна л гэсэн үг. Тэгэхээр ялангуяа дулааны төлбөрийн асуудал дээр нэлээн бодит юм руу орж ирнэ гэсэн үг.

Зардлын хувьд эрчим хүчний зохицуулах хороо тооцоолсон байна лээ. Өнөөдрийн хэмжээнд бол аж ахуйн нэгжүүд 99 хувь тоолууртай байгаа гэж байгаа юм. Харин айл өрхүүдийн маань 2 хувь нь л тоолууртай байна. 98 хувь нь тоолуургүй байна. Нийтдээ 300 гаруй мянган айл өрхүүдийг тоолууртай болгох эрэлт хэрэгцээ байна. Үүний тооцоолол, нарийн судалгааг зохицуулах хороо хийгээд, нийтдээ бол 300 орчим тэрбум төгрөг шаардлагатай байна. 5 жилийн

хугацаанд бол жилдээ 50 орчим тэрбум төгрөгийг зарцуулаад явахад бол бүрэн тоолууртай болгох юм байна гэдэг тооцооллыг Эрчим хүчний зохицуулах хороо бол хийсэн байсан.

Тэр санал авах асуудал дээр яг таны хэлж байгаа зөв. Онлайнаар бол бараг хэн ч санал ирүүлдэггүй юм байна лээ. Тийм ч учраас бид бүхэн 2025 оны 4 сард хуулиа боловсруулчхаад, 159 компаниуд руу албан бичгээр хүргэсэн. Энэ хууль батлагдахаар та бүхний эрх ашгийг хөндөнө. Дээрээс нь энэ салбарын жаргал зовлонг та бүхэн үүрч явж байгаа учраас энэ хуульд оролцох нь та нарын үүрэг. Нэг талаар урьж байна гэдгээр албан бичиг явуулаад, давтсан тоогоор 800 гаруй санал ирж, энэ хууль дээр дахин сайжруулах ажлыг хийж ажилласан байгаа. Тэгэхээр энэ дээр бол маш бодитой хандсан. Онлайнаар санал ирдэггүй гэдэг дээр бид нар яг үнэхээр олж харсан учраас албан бичгээр хуулийнхаа төслийг хүргэж ажилласан байгаа. Товчхондоо иймэрхүү дээ. Нэмэлтээр манай Эрдэнэчулуун зөвлөх хариулъя.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон дээр нэрээ хэлээд хариулаарай.

Х.Эрдэнэчулуун: Хуулийн ажлын хэсэгт зөвлөхөөр ажилласан зөвлөх инженер Эрдэнэчулуун байна. Асуултад хариулъя. Ямар хэмжээний эх үүсвэрийг хэмнэх боломжтой вэ гэвд. Энэ дээр болохоор Монгол Улсын эрчим хүчний салбарын стратеги төлөвлөгөөг Жайка ОУБ-ын хэмжээнд нэгдсэн ийм тойм судалгаа хийсэн. Тэгээд энэ дээр болохоор зэрэг өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хэрхэн хангах вэ гэдэг энэ тайланд болохоор зэрэг дулаалга болон дулааны тоолуурыг бий болгох замаар одоо байгаа хэрэглээг хэмнэх боломж потенциал нь бол 30-40 хувь байна гэсэн ийм судалгаа гаргасан байдаг.

Айл өрхийн төлбөрийн хувьд ямар хэмжээгээр буурах вэ гэж асуухаар бас энэнд хариулахад аягүй хэцүү. Яагаад гэхээр зэрэг одоо байгаа айл өрхөд борлуулж байгаа дулааны эрчим хүчний үнэ тариф маань бол бодит өртгөөсөө бараг 2 дахин доогуур байгаа гэсэн ийм мэдээллийг зохицуулах хороо гаргадаг. Зүгээр энергийн хувьд бол хэрэглэгч өөрөө эрчим хүчээ хэмнэх боломжтой болно. Тохируулах боломж .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Батын Батбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Сархадын Зулпхар гишүүн алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн сая байсан даа. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна. Алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн алга байна. Одоо Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Юуны өмнө энэ их чухал ийм хуулийг бас салбарын яам нь ч оруулж ирж чадахгүй байхад мэргэжлийн бас Улсын Их Хурлын салбарын төлөөлөл болсон гишүүний хувьд нэлээн чамбай хууль боловсруулж оруулж ирж байгаад талархал илэрхийлье. Тэгээд хуулийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа.

Бид нар дулаан хангамж гээд гэхээр нэлээн олон асуудлууд байгаа. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд бол дулааны хомсдол, хуучирсан дэд бүтэц, техникийн алдагдал, хөрөнгө оруулалтын дутагдал, тарифын бодлого нь бас хуучирсан. Дээр нь нэмээд хэрэглэгчийн эрх ашгаа бид нар яаж хамгаалах вэ

гэдгийг ингээд 1 тогтолцоогоор нь харах ийм шийдэл бол үнэхээр хүлээгдэж байсан. Тэгээд энэтэй холбоотой бас хэд хэдэн асуулт бас асууя гэж бодож байна.

Ер нь бол дулааны хомсдол маш их байгаа. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотод барилгажилт ихсэж байгаа. Манай Өргөдлийн байнгын хороон дээр ирж байгаа энэ орон сууцтай холбоотой, техникийн нөхцөлтэй холбоотой захиалга өгөөд хохирчихсон иргэдийн бас нэлээдгүй хувь нь дулаан хангамжийн асуудал дутагдалтай байгаа учраас зөвшөөрөл өгч болохгүй байна, холболт хийж болохгүй байна гээд удааширчихдаг. Нөгөө баахан мөнгөө өгөөд хохирчихсон иргэд маань хэдэн жил хүлээгээд, хэдэн сар хүлээгээд ингээд хохироод байдаг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар ер нь дулаан хангамжийн асуудал Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК-ийн мэдээллээр үзэх юм бол ер нь нөгөө суурилсан хүчин чадлынхаа 40-60 хувьд нь хэтэрчихсэн байгаа гэдэг судалгаа яваад байдаг. Тэгээд энэ хууль батлагдсанаар 1 дүгээрт дулааны хомсдолыг бууруулах ямар тодорхой механизм бий болгож байгаа вэ гэдгийг хууль санаачлагчаас асууя.

2 дугаарт мэдээж дулаан, эрчим хүчтэй холбоотой хууль тогтоомж дээр хэрэглэгчдээс илүү их мөнгө авах замаар энэ асуудлаа, алдагдлаа нөхөх юм уу, эсвэл дутагдал, тэр эрчим хүчний алдагдлаа бууруулах замаар зардлаа багасгаад салбарынхаа үр ашгийг дээшлүүлэх үү гэдэг ийм бодлогын сонголтууд байгаа. Энэ 2-ыг яаж баланслах вэ гэдэг бол маш чухал. Энэ хамгийн эмзэг ийм баланс байдаг. Тэгэхээр энэ дээр би зүгээр асуумаар байгаа нь алдагдалтай гээд бид нар чинь дулааны алдагдал 17,56 хувьтай гээд гаргачхаад байна шүү дээ. Нийт явж байгаа дулааны маань бараг 20 орчим хувь нь алдагдал, хэрэггүй болчхоод байна. Тэгэхээр энэ алдагдлын эх үүсвэр нь тэр дамжуулах шугам сүлжээндээ байдаг юм уу, барилгын дотоод системдээ байдаг юм уу. Түгээх сүлжээндээ байдаг юм уу. Хаана хэдэн хувийн алдагдал байдаг юм бэ. Үүний нэгдсэн судалгаа байна уу. Эндээсээ хамааралд та бүхний санал болгож байгаа тоолуурын асуудал хэр үр дүнтэй байх юм бэ. Алдагдлаа хэдэн хувь буулгах юм бэ гэдэг маань гараад ирэх байх л даа. Тэгээд яах вэ, энэ дээр аудитын байгууллагаас бас төрийн хэт давамгайлсан зах зээлийн бус зохицуулалттай дулааны эрчим хүчний судалгаатай холбоотой ийм гүйцэтгэлийн аудитын тайлан гарсан. Тэр дээр нийт хэрэглэгч, аж ахуйн нэгж, иргэдийн хэрэглэгч дундаас 20,5 хувь нь тоолуур суулгах боломжгүй нөхцөлд байна гэдэг ийм дүгнэлтийг гаргачхаад байгаа юм. Тэгэхээр бид нар яг энэ хуулийн зорилт, үр дүн нь яаж гарах вэ гэдэг дээр дулаан алдагдлыг бид нар яг хаана, яаж хэмнээд, яаж гарах гээд байна гэдэг дээр бас судалгаа байгаа юу гэдгийг асууя.

Гуравдугаарх асуудал бол мэдээж тарифын бодлого байгаа. Тарифын бодлогыг бас нэлээн нарийвчилж энэ хууль дээр 7 дугаар бүлэг дээр оруулсан байна. Дулаан тариф тогтоох зарчмыг ер нь зах зээлийн зарчимтайгаа уяад, ашгийн зохистой түвшинд байна, хөрөнгө оруулалтаа нөхөхүйц байна гээд ингээд олон зарчмыг баримтална гээд ингэчихсэн байгаа. Тэгэхээр одоо бол мэдээж манай Монгол Улсад дулааны тариф бол маш хямдхан байгаа. Ерөөсөө судалгаагаар байшин, орон сууцанд төвлөрсөн дулаанаас авч байгаа хүмүүс бол гэр хороололд сууж байгаа, түлш авч байгаа хүмүүсээс 4 дахин бага зардлаар дулааны хэрэгцээгээ хангаж байна гэдэг бүр судалгаа гаргачихсан. Бид нар байшин, орон сууцтай байгаа хүмүүстээ илүү таатай, гэр хороололд байгаа хүмүүстээ илүү таагүй л ийм дулаан, эрчим хүчний хангалттай байгаа гэдэг тооцоолол байдаг. Тэгэхээр энэ дулааны тарифын бодлогоор яг энэ зарчмаараа тооцохоор ер нь одоогийн

дулааны хэмжээ хэд болж өсөх гээд байна. Тэгээд энэ дээр бичсэн байсан. Үнэхээр энэ зүй ёсны монопол салбар байдаг. Тэгээд салбарын монополын .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Номинчимэг гишүүн 1 минут нэмж тодруулъя.

О.Номинчимэг: Салбарын монополын асуудал дээр, тарифын асуудал дээр 1 асуудал гараад байдаг нь одоогийн Монополын тухай хуулиар тарифтай холбоотой эрчим хүчний асуудлыг монополын хуулийн үйлчлэх хүрээнээс гаргачихсан байдаг байхгүй юу. Тэгээд тариф нь үнэхээр яг зүй ёсны монополын дагуу хамгийн боломжит түвшиндээ байна уу гэдгийг хянах нөхцөл нь тэгвэл хаанаа байх юм бэ гэхээр салбартаа байна гээд байдаг. Тэгэхээр энэ дулааны тариф дээр ийм зарчмаар гаргах юм байна. Гэхдээ л энэ бол монопол салбар. Үүний тарифын хяналт нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс хэн хяналт тавьж байх юм бэ. Хэрэглэгчээ хамгаалах механизм нь яаж ашиглах юм бэ. Энийг яаж энэ хууль дээрээ тусгаж өгсөн бэ гэдэг ийм 3 асуултыг асууя.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Баярлалаа. Тэгэхээр дулааны хомсдолын асуудлыг бууруулах ямар механизмууд орж ирсэн бэ. Тэгэхээр энэ дээр бид нар сая хэллээ. Хэсэгчилсэн, бие даасан дулаан хангамжийн систем гээд цоо шинээр орж ирж байгаа. Тэгэхээр энэ систем дээр ерөөсөө тэр тусгай зөвшөөрөл авах, үнэ тариф батлуулах, зураг төсөл хийлгэх, ТЭЗҮ хийлгэх гэдэг дээр төр ерөөсөө оролцохоо больё гэж байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд бид нарын дулаанаар хангаж чадахгүй байгаа олон мянган хэрэглэгчийг хувийн хэвшлийнхэн хангаад явах бүрэн боломж бололцоо нээж өгч байгаа гэж харж байгаа.

Дээрээс нь бид нар төвлөрсөн дулаан хангамжаасаа болоод маш их төвлөрчхөөд байгаа учраас энийг тархмал байдлаар шийдэх энэ эрх зүйн орчин бас ингээд бүрдэж өгч байгаа. Тэгэхээр энэ дээр бол ингэж хомсдолыг бууруулахад хувь нэмэр оруулж чадна гэж харж байгаа.

Дулааны тоолууртай болсноороо алдагдлыг яаж бууруулах юм бэ. Тэгэхээр ер нь бид нар ингээд тоолж чадахгүй байгаа болохоороо үнэхээр хэмнэх, хаана нь чухам алдаад байгаа гэдгээ ч мэдэхгүй байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл дамжуулах сүлжээн дээрээ алдаад байгаа юм уу, түгээх сүлжээ дээрээ алдаад байгаа юм уу, хэрэглэгч дээр очоод яг хэдэн хувь нь алдаад байгаа юм бэ гэдгээ тодорхой сайн мэдэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тоолууртай болгож өгснөөрөө бид нар хаана чухам алдаад байгаа гэдгийгээ мэднэ. Энэ дээр хэмнэлт гаргаж чадна гэж байгаа.

2 дугаар асуудал нь болохоор тоолуургүй учраас хэрэглэгч ерөөсөө хэмнэх сэтгэхүй байхгүй байна. Байшингаа дулаалах бас тэр сэдэл нь ерөөсөө байхгүй байгаад байгаа. Тэгэхээр тоолууртай болгоод өгөхөөрөө хүн цаашдаа байшингаа хүртэл дулаалах ийм шийдэл рүү орно гэж байгаа.

Тэр тарифын бодлогын хувьд болохоор яг зүйтэй. Үнэхээр тарифыг ялангуяа төвлөрсөн дулаан хангамжийн системийн хувьд л ганцхан эрчим хүчний зохицуулах хороо тарифыг зохицуулна. Олон төрлийн аргаар бодно гэж ингэж байгаа. Энэ дээр тэгээд хяналт тавих, хэрэглэгчийн оролцоо ямар байх вэ гэж байна. Тэгэхээр эрчим

хүчний зохицуулах хорооны зохицуулагчийг Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулагч гэж тусгайлан томилдог байгаа. Тэгэхээр энэ хүний бас 1 үүрэг роль нь болохоор үнэхээр тариф дээр хэрэглэгчийн эрх хангагдаж байна уу гэдэг дээр бас хяналт тавьж явах үүрэг роль нь байж байдаг.

2 дугаар асуудал болохоор хэсэгчилсэн дулаан хангамжийн хувьд бас яг адилхан. Хэрвээ ингээд явцын дунд хэрэглэгч үнэхээр үнэ тариф өндөр байгаад байна гэдэг гомдлыг 50 дээр нэмэх нь 1 гэсэн хэрэглэгч гаргах юм бол тэр дээр бас хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зохицуулах хороо аудит хийнэ. Энэ гомдол одоо 3 удаа гарсан тохиолдолд тэр үнэ тарифыг бодит өртөгт нь тааруулах, зохицуулах юм руу шилжиж орно гэсэн байдлаар зохицуулсан байгаа. Ингээд нэмэлтээр манай ажлын хэсгээс бас хариулж өгье.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Судлаач Эрдэнэчулуун.

Х.Эрдэнэчулуун: Зөвлөх Эрдэнэчулуун байна. Дулааны алдагдал дээр нэмэлт тайлбар хийе. Дулааны алдагдлын Номинчимэг гишүүний дурдсан 17,5 гэдэг тоо бол зөвхөн дамжуулах сүлжээн дээр гарч байгаа алдагдлын хэмжээ байж байгаа. Эцсийн хэрэглэгчдэд тоолуур байхгүй байгаа учраас бид нар түгээх сүлжээн дээр ямар хэмжээний алдагдал гаргаж байгааг бол яг тодорхой тооцож хэмжиж бол чадахгүй байгаа. Тоолуур суурилуулах боломжгүй хэсгүүд дээр болохоор зардал хуваарилах төхөөрөмж гээд тоолуурыг орлуулахуйц хэмжих хэрэгслийг ашиглана гэсэн заалт хуульд орсон байгаа. Хяналтын хувьд бол энэ зохицуулалттай үйлчилгээний нэгдсэн дансны жагсаалт болон зохицуулалтын аудит гэсэн бүлгийн хүрээнд 2 жил тутамд дулааны бодит өртөг зардлыг хараат бусаар хянаж аудит хийнэ гэсэн заалт орсон байгаа.

Б.Пүрэвдорж: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя. Лувсанжамц гишүүн асуулт асууна

Г.Лувсанжамц:. Номинчимэг гишүүн тодруулъя гэж байна шүү дээ. 1 минутыг нь өгөхгүй юм уу та. Би тэгвэл эхнээс нь минутаа авчихъя.

Б.Пүрэвдорж: Асуулт асуухгүй учраас тасаллаа. Оюунсайханы Алтангэрэл гишүүн алга байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ер нь яах вэ зүгээр дулааны станцууд нь өөрсдөө алдагдалтай ажиллаад байдаг. Түгээхүүд нь бүгдээрээ ашиг, орлого өндөртэй, авлигажсан хэлбэр дээр ажиллаад байдаг. Ингээд одоо энэ хуулиар бас тодорхой хэмжээний харилцааг нь зохицуулаад өгчих болов уу гэж харж байгаа. Хуулийн хүрээнд, үзэл баримтлалын хүрээнд бол ялангуяа энэ бодлогын тогтвортой байдлыг хангах улсын болон орон нутгийн төсөвтэй холбоотой харилцаагаар хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой харилцаа дээр бол дэмжиж байгаа. Хэд хэдэн асуултууд байна.

1 дүгээрт энэ Дулаан хангамжийн тухай хуулийн төслийн дулаан хангамжийн талаар баримтлах зарчим гэсэн 3 дугаар зүйл дээр дулаан хангамжийн салбарт үзүүлэх дэмжлэг гэсэн 9 дүгээр бүлэгт төрөөс дулаан хангамжийн бодлого, чиглэлийг тодорхойлж, дэмжлэг үзүүлэх хэлбэрүүдийг заасан. Тэгээд энэ хуулийн

төслийн эдгээр тунхагласан зорилго, чиглэлүүд яг яаж бодитоор хэрэгжих вэ. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг яаж тооцох юм бэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт энэ өмчлөгч, эзэмшигчтэй холбоотой харилцаа зайлшгүй хөндөгдөхөөс өөр арга байхгүй байгаа. Энэ 2026 оны 7 дугаар сард хийсэн Үндэсний аудитын газрын дүгнэлт дээр болохоор 59,4км урттай гадна дулааны шугамын өмчлөлийн харьяалал тодорхойгүй, дундын эзэмшилд ашиглаж байна гэсэн ийм дүгнэлт гарсан байна. Тэгэхээр энэ дулааны шугам сүлжээний найдвартай ажиллахад өмчлөгч эсвэл эзэмшигчийн асуудал өнөөдөр чухал зүйлүүдийн 1 болчхож байгаа. Тэгээд бид нар энэ хуулийн төсөлд дулааны шугам сүлжээний өмчлөгчийн харьяаллыг хэрхэн тогтоох, дулаан хангамжийн системийн өмчлөгч, өмчлөгчөөс эрх авсан этгээдийн эрх, үүргийг хэрхэн тодорхойлсон, хувийн өмчийн хөрөнгөөр баригдсан шугам сүлжээг төрийн өмчид шилжүүлэх тухай нарийвчилсан ямар зохицуулалтууд тусгагдсан бэ гэдгийг асуумаар байна.

3 дугаарт ер нь зүгээр энэ шинээр баригдсан хотхон хорооллын орон сууцыг ашиглалтад оруулсны дараа ерөнхий дулааны шугамын сүлжээтэй холбосон салаа дулааны шугамыг түүнтэй ойр байгаа конторуудад нь хариуцуулаад өгчихдөг. Гэтэл энд ямарваа нэг асуудал үүсэхэд тухайн конторууд бол хүн хүч, техник, бололцоо байхгүй. Бид нар бол энийг хийж чадахгүй гэдэг ийм нөхцөл байдлаар бол ханддаг. Тэгэхээр энэ хуулийн төсөлд төрийн болон хувийн хэвшлийн дулааны сүлжээ, тэдгээрийн харилцан ойлголт, үнэ тариф, засвар үйлчилгээ зэрэг гарч байгаа бодит хүндрэлтэй нөхцөл байдлыг шийдвэрлэх талаар ямар зүйл заалт, ямар нөхцөлүүдийг тусгасан бэ гэдгийг асуумаар байна.

Энд 1 ноцтой юм байна манайхан. Энэ Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар дагаад оруулаад ирчихсэн. Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т төрийн албан хаагч гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Тэгсэн чинь төрөөс гэсний дараагаар нь болон хуулиар зөвшөөрсөн тохиолдолд төсөвт байгууллагын өөрийн орлогоос гээд нэмж оруулахаар заагаад өгчихсөн. Тэгээд энэ байж болохгүй ээ Энхцэцэг гишүүн ээ. Ингээд хууль дагаад, ингээд дагуулаад гуя дагаж хүзүү гэдэг шиг ийм юм ерөөсөө явуулмааргүй байна. Энэ Төрийн албаны зөвлөлөөс санал авсан юм уу. Яагаад ийм юмыг оруулж ирж байгаа юм. Энэ Нэгдсэн Монгол Улсын бодлого гэж байна. Цалингийн бодлого, хөдөлмөрийн бодлого гэж байна. Тэгтэл энэ дулаан хангамжтай холбоотой асуудал дээр ингээд шууд хуулиар зөвшөөрсөн тохиолдолд төсөвт байгууллагын өөрийн орлогоос гээд ингээд оруулаад ирж болж байгаа юм уу. Энэ ТАЗ бас байна уу, байхгүй юу. Хариулт өгөөсэй гэж хүсэж байна. Тэгээд ялангуяа энэ чинь өөрөө нөгөө төрийн албаны нэгдсэн үндсэн зарчим тогтолцоонд сөрөг үр дагаврууды бий болгоно шүү дээ. Ашиг сонирхлын зөрчил үүсгэхийг ч бас үгүйсгэхгүй. Тэгээд энэ нөхцөл байдлыг та бас сайн бодооч ээ. Энэ хэсгээ бол татаж авах зайлшгүй шаардлагатай. Энэ бол төрийн албан хаагчаас бас ялгаатай шүү. Төрийн албан хаагчид яагаад төрийн албан хаагч гэдэг утга агуулга нь ч гэсэн Төрийн албаны тухай хууль дээрээ байж байгаа юм. Тэгэхээр энэ байж болохгүй асуудал гэдгийг би бас танд хэлье. Тэгээд хариултаа авъя. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Дулааны шугам сүлжээг өмчлөх, эзэмшихтэй холбоотой асуудлууд үнэхээр маш их байдаг. Ялангуяа нийтийн сүлжээ буюу дулааны шугам сүлжээг өөрсдөө хөрөнгөөрөө барьчхаад, цаашаа асар их хэмжээний мөнгө төгрөгийг иргэдээс нэхээд сууж байдаг эсвэл дулааныг цаашаа өндөр өртгөөр зараад сууж байдаг гэдэг асуудал бол маш их байдаг. Тэгэхээр энэ асуудлыг бид бүхэн хууль дээрээ нэлээн тодорхой болгож зохицуулж өгсөн. Өөрөөр хэлбэл хувийн сүлжээ хэзээ нийтийн сүлжээ болох вэ гэвд. Өөрөө та жишээлбэл юу гэдэг юм 100 сая төгрөгөөр 110мвт-ыг дамжуулах шугам бариад, өөрөө 6мвт-ыг ингээд хэрэглэж байгаа нөхцөлд энэ бол хувийн сүлжээ. Та өөрөөр хэлбэл хэн нэгний эрх ашгийг хөндөхгүй хувийн сүлжээ, хувийн эзэмшил. Гэтэл таны 4мвт-ын нөөцийг би ашиглая гээд хоёрдогч хэрэглэгч гарч ирсэн тохиолдолд энэ маань нийтийн сүлжээ болох буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ шугамыг хариуцаад, дээрээс нь тэр 40 сая төгрөгийг шинээр 4мвт-ыг авах гэж байгаа хүнээс аваад, тэр анхны хөрөнгө оруулалтыг хийсэн хүнд өгөх ийм зохицуулалт бол орж ирсэн байгаа. Өөрөөр хэлбэл цаашдаа тэгээд олон хэрэглэгчийн эрх ашгийг мэргэжлийн өндөр түвшинд үйлчилгээ үзүүлээд явж байх ийм тусгай зөвшөөрөл рүү шилжүүлэх байдлаар зохицуулж өгсөн байгаа.

Шинэ хотхон, тосгоны хувьд яг таны хэлж байгаа үнэн. Маш олон хувийн түгээх сүлжээнүүд бол төрж гарч ирж байгаа. Тэгэхээр хувийн түгээх сүлжээнүүдийн хувьд болохоор бас яг тэр мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлж чадахгүй, дутагдал бол маш их байдаг юм байна лээ. Энэ асуудал дээр бид нар бас тусгайлан тухайн хувийн сүлжээний хүчин чадлыг томруулах, түгээх сүлжээг ялангуяа хүчин чадлыг нь 30мвт хүртэл байх гэдэг ийм хүчин чадлыг оруулж өгч байгаа. Ингэснээрээ өөрөөр хэлбэл олон шугамыг хариуцсанаараа зардал буурна. Тэгээд тухайн хувийн сүлжээ нь бас шаардлагатай гэж үзэх юм бол мэргэжлийн байгууллагаас гэрээгээр бас үйлчилгээ аваад явахаар ийм зохицуулалт орж ирж байгаа.

Тэр Төрийн албан хаагчийн эрх зүйн хууль дээр өөрчлөлт оруулсан асуудал дээр бас ажлын явцад тодруулаад, засаад явах бүрэн боломжтой, нээлттэй байгаа гэж харж байгаа. Тэгээд манай ажлын хэсгээс нэмэлт хариулт өгөх үү.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон хариулъя.

Х.Эрдэнэчулуун: Зөвлөх Эрдэнэчулуун. Дулаан хангамжийн салбарт үзүүлэх төрийн дэмжлэг гэдэг асуултад хариулъя. Үүний хүрээнд болохоор ер нь тодорхой ялангуяа орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдлага болохоор дулаан хангамжтай холбоотой асуудлуудаа ингээд төслөө хэрэгжүүлээд, бодлогоо төлөвлөөд явахад нэлээд ийм хязгаарлалтууд байдаг учраас ерөнхий байдлаар төрөөс ийм ийм дэмжлэгүүд байж болно гэдэг ерөнхий эрх зүйн орчныг нь нээж байгаа. Тэгэхдээ энийгээ яг ямар нөхцөлд жишээлбэл, улсын төсвийн хөрөнгө оруулалт гэдэг нь ямар дэмжлэг дээр үйлчлэх вэ гэхээр жишээлбэл дулаан хангамжийн хөгжлийн схемийг боловсруулах, дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх эсвэл оргил ачааллын эх үүсвэр барих гээд ингээд улсын төсвийн хөрөнгө оруулалт бол ийм, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бол ийм ийм хүрээнд дэмжлэг үзүүлнэ гэдэг байдлаар нэлээд нарийвчилж зохицуулж өгсөн байгаа.

Б.Пүрэвдорж: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Уг нь Найдалаа сайд бас байсан бол хэрэгтэй байлаа. Энэ эрчим хүчний системийн асуудал бол ний нуугүй хэлэхэд өнгөрсөн хугацаанд мэдээж хийх ёстой байсан ажил. Хэтэрхий авлигажчихсан юм байна лээ шүү дээ. Энэ түгээхүүд чинь тэр чигээрээ авлига. Битүү авлига. Хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэр дээр гэдэг юм оруулж ирж байгаад л тэр мөнгийг нааш нь цааш нь зохицуулдаг. Өнөөдөр байгаа энэ түгээхүүдийн асуудлууд, энэ ТӨК-удтай холбоотой асуудлуудаа та нар бас яг энэ хууль хийж байгаа учраас хараарай гэж хүсэж байгаа юм. Яагаад гэхээр энэ асуудлыг бид нар нэгэнт л хууль оруулж ирж байгаа бол тодорхой хэмжээнд шийдлүүдийг нь гаргах хэрэгтэй. Энэ контортой холбоотой асуудал байна. Энэ конторууд гэдэг бол үнэхээр хэцүү. Мөнгөө төлчихсөн хэрэглэгчийн цахилгаан дулааныг тасална гээд дайраад байдаг. Нийтээр нь, байраар нь. Тэгээд ийм асуудлуудыг та хэд маань бас хууль дээрээ сайн тухайлж бодоорой гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Бат-Эрдэнэ гишүүн маш зөв зүйлийг хэлж байна шүү дээ. Би тэр эхэндээ хэлсэн. Өөрөөр хэлбэл маш их авлигын асуудал байгаад байна. Ашиглалтад орж байгаа байрнаас хэдэн 10-аар нь байр авчихсан танай даргын асуудал яригдаад байдаг юм шүү дээ. Тэгээд дээрээс нь Энхцэцэг гишүүн ус сувгаас чинь дулаан, ус суваг чинь 40 төгрөгөөр зардал гаргаж усаа татдаг. Тэгээд буцаагаад 2 төгрөгөөр зардаг байхгүй юу даа. Тэгээд ийм нөхцөлд 1 хэсэг газраа доголдчихсон энэ асуудал чинь нөгөө дулаан хангамж дээр чинь бас дахиад л доголдол болоод очно. Ингээд гинжин урвал маягаар алдагдлууд чинь өсөөд явдаг ийм л юм болчхоод байгаа юм л даа. Энэ асуудлаа энэ хуулиараа яаж шийдсэн талаараа бас хэлж ярих хэрэгтэй. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Сайн байцгаана уу. Дулаан хангамжийн тухай хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байна. Тэгээд цаг үеэ олсон нэлээн өргөн хүрээтэйгээр 12 бүлэг, 66 зүйлтэйгээр оруулж ирсэн байна. Дэмжиж байгаа. Өнөөдөр гэхдээ Эрчим хүчний яамнаас байр сууриа илэрхийлэх ёстой болов уу гэж бодож байна. Тэгээд сайд нь байхгүй байна гэдэг дээр бол их шүүмжлэлтэй хандмаар байна.

Миний хувьд эхлээд төсөвт ирэх ачаалал, тэгээд хэрэглэгч дээр ирэх дарамт гэсэн энэ 2 зүйл дээр ялангуяа дэд бүтцийн салбарын хуулиуд анхаарах ёстой. Мэдээж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж оруулах, ашигтай байхыг нь мэдээж хамгаалах ёстой. Гэхдээ энэ үзэл баримтлалд болохоор хэрэглэгчид хүргэх дулааны өртгийг боломжит хэмжээнд бага байлгана гэж байгаа. Заасан байгааг нь бол дэмжиж байна. Мөн хуулийн төслийг боловсруулахад бас Дани, Эстони, Казахстан, Унгар гэсэн улсуудын жишээг судлаад, хувийн хэвшлийн ашгийг зохистой түвшинд нь байлгана гэсэн тийм заалтууд байдаг гэдгийг нь хэр тусгасан юм бол. Энэ хуулийн төсөл дээр болохлоор ашгийн доод хязгаарыг тавьчхаад, хувийн хэвшил маань өөрөө ашгийн дээд хязгаартай байх ёстой гэдэг зүйлд нь бол байхгүй байна. Тэгэхээр төр, хувийн хэвшил иргэдийн ачааллыг энэ зохистой түвшинд нь байлгах нь бол төрийн гол бодлого байх ёстой болов уу гэж бодож байна.

Эхний асуулт хуулийн төслийн 37.2-т түлшний үнэ, инфляц, валютын ханшийн аль нэг нь 5 хувиас дээш өсөх юм бол дулааны тарифыг тухай бүр индексжүүлээд нэмнэ гэж байгаа. Мөн 34.2-т нь цалин, хамтын гэрээний зардал зээлийн хүүг тарифт бүрэн шингээхээр заасан байгаа нь энэ компаниудад зардлаа хүссэнээрээ нэмээд, нөгөө талдаа хэмнэх, үр ашигтай ажиллах гэсэн сонирхлыг нь бууруулахаар

заалтууд байгаа юм байна шүү гэж бодож байна. Тэгэхээр энэ дулааны үнийн өсөлт нь шууд хэрэглэгч дээр ачаалал болоод, дарамт болохоор харагдаад байна л даа. Тэгэхээр үнийн өсөлтийн дээд хязгаарыг хуульд заагаагүй шалтгаан нь юу вэ гэсэн эхний асуулт.

2-т нь нэмэгдсэн тарифыг сая хэлсэн ингээд автоматаар 3 юм хөдлөнгүүт тариф нь нэмэгдчихэж байгаа юм. Гэхдээ нөгөө талдаа түлшний үнэ буурах ч юм уу. Тийм тохиолдолд бас автоматаар энэ дулааны үнэ буурдгаар тийм зохицуулалт оруулахгүй байсан уу. Тэгэхээр энэ тарифыг тооцохдоо бид нар ер нь бол олон улсын жишгийг бариад, 1 дүгээрт ийм зардлын аудитад суурилсан өртгийн арга, 2-т нь болохоор гүйцэтгэлд суурилсан урамшууллын арга гэсэн ийм 2 аргачлал байдаг. Энийг энэ хуулийн төсөлд тусгахаар зарчмын зөрүүтэй санал гаргавал та энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ.

Эрчим хүчний яамнаас уг нь энийг асуумаар байгаа юм. Хэрвээ өнгөрсөн жилийн бодит инфляц, ханшийн өөрчлөлтийг яг энэ хууль дээр заасан томьёогоор оруулах юм бол Улаанбаатарын 1 айлын сарын дулааны төлбөр хэдэн хувиар, хэдэн төгрөгөөр нэмэгдэх байсан бэ гэдэг тийм тооцоолол энэ хуулийн төсөл дээр саналаа өгөхдөө хийсэн болов уу гэдэг.

4 дэх асуулт нь төслийн 44.1.4, 49.2.1 дээр Засгийн газар тарифыг бууруулах эсвэл хойшлуулах юм бол зөрүүг нь төсвөөс даана гэж байгаа юм. 48.1 дээр бас эх үүсгүүр, дулаан дамжуулах сүлжээ барихыг төсвөөс санхүүжүүлнэ гээд заавал төр даахаар тусгачихсан байгаа. 44.1.9 дээр Засгийн газар баталгаа гаргана гэсэн мөртөө тэр дээр тавих шаардлага, шалгуур, дээд хэмжээг нь бас тусгаагүй байгаа. Энэ заалтууд нь юуг илэрхийлж байна гэхээр ингээд тариф өсгөх эсвэл төсвөөр нөхнө гэсэн ийм 2 сонголтыг л үлдээж байгаа гэсэн үг л дээ. Тэгэхээр нөгөө талдаа энэ тариф нь автоматаар хязгааргүй өсөөд байх юм бол энэ улс улсын төсөвт суугаагүй байх юм бол шууд айлуудын хэрэглээний зардал, дулааны зардал нь шууд өснө гэсэн үг. Тэгэхээр ийм зүйлүүдээ хэрхэн зохицуулах вэ гэдэг үндсэн яг ийм бодлогын л асуултууд байгаа юм шүү.

Тэгээд 5 дахь асуулт нь бас Эрчим хүчний яам хариулах ёстой асуулт л даа. Хууль хэрэгжиж эхэлсэн эхний 5 жилд яг энэ аргачлалаар тооцох юм бол улсын төсөв дээр жил бүр хэдэн төгрөгийн ачаалал үүсэх вэ. Тэгээд энэ дээр Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм бэ гэдэг асуултыг асуумаар байсан. Тэгэхээр Энхцэцэг гишүүн маань 3 асуултад, хариулаад үлдсэн 2-ыг нь Эрчим хүчний яамнаас бичгээр хариулт авъя даа.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Дулааны үнийг батлах аргачлалуудыг бол энэ хууль дээр нэлээн тодорхой тусгаж өгсөн байгаа. Тэр 34 дээр өртгийн аргаар тарифыг тогтоох. Өөрөөр хэлбэл өртөг гэдэг нь анхны хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал гээд. Тэгэхээр энэ асуудлуудыг тодорхойлохын тулд санхүүгийн нэгдсэн стандарт байдаг юм байна. Өөрөөр хэлбэл тэр өртөг нь яг бодитой юм уу гэдгийг нягталдаг, хянадаг, аудит хийдэг. Тэрнийхээ үндсэн дээр энэ үнэ тарифыг батлаад явж байх ёстой гэж байгаа. Тарифыг индексжүүлэх асуудал дээр ганцхан тариф өсөхтэй холбоотой асуудал бас тусгагдахгүй. Хэрвээ ингээд зах зээл дээр үнэхээр инфляц буураад, энэ

тохиолдолд бол бас индексжүүлнэ гэдэг нь зөвхөн өсөлтийн асуудал биш, бас буурах асуудал бол хамт тусгагдаж байгаа гэж ойлгогдож байгаа.

Дээрээс нь сая тэр хэрэглэгчийн үнэ тарифыг өсгөхтэй холбоотой зохицуулах хорооны гаргасан шийдвэрийг хэрвээ төр хүлээн зөвшөөрөхгүйгээр хойшлуулах эсвэл хүчээр бууруулах шийдвэр гаргах, энэ тохиолдолд яалт ч үгүй л тэр өртгийг нөхөх асуудлыг улс өөрөө шийдвэрлэхээс л арга байхгүй. Одоо ч гэсэн бид бүхэн бас л албан бусаар, татаасаар энэ асуудлыг шийдвэрлээд л хөрөнгө оруулалтыг нь хүртэл хийгээд л, засварыг нь шугам сүлжээг нь өргөтгөх засах юмыг нь хүртэл бид нар улсынхаа төсвөөр эсвэл гаднын зээлийн тусламжаар ингээд шийдвэрлээд л явж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг энэ дээр ингээд нарийвчилж, өөрөөр хэлбэл эцсийн хэрэглэгч дээр ачааллыг үүрүүлэхгүй байх арга хэмжээгээ төр өөрөө бас ингээд аваад явж байх ёстой. Гол нь зохицуулах хороо болохоор тэр үнийг үнэхээр яг бодитой юм уу, тэр өртөг нь үнэхээр бодитой юм уу, хөрөнгө оруулалт нь үнэхээр бодитой юм уу гэдгийг маш сайн хянаж нягталдаг. Хянаж нягтлахад нь зориулаад тэр санхүүгийн бүртгэл нь нэгдсэн стандарттай байдаг юм байна. Дээрээс нь зохицуулалттай үйлчилгээний аудит гээд тусгайлан стандарт байдаг. Тэрний дагуу аудитаа хийж байж, тэгээд үнэ тарифаа бодитой батлаад явж байх ёстой гэдэг ийм асуудлыг тусгасан байгаа. Тэгээд нэмэлтээр ажлын хэсгээс хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын зөвлөх инженер Эрдэнэчулуун. Индрийн 4 дүгээр микрофон.

Х.Эрдэнэчулуун: Дулааны өртгийг хамгийн бага байлгахад ашгийн дээд хязгаар, ашгийн түвшнийг хязгаарлахгүй байсан уу гэсэн асуулт байсан. Энэ дээр бол хязгаарлахаар зохицуулалт орж байгаа. Энэ дээр зохицуулах хорооны дэргэд хэрэглэгч, бизнес эрхлэгчид болон салбарын төлөөлөл орсон ийм хараат бус зөвлөл тарифт ашгийн түвшнийг хэдээр тогтоох вэ гэдэг ийм байдлаар тухайн жил болгон хэлтсээ тогтоогоод баталгаажуулаад явдаг байх гэсэн ийм зохицуулалт орж ирчихсэн байж байгаа. Таны дурдсан өртөгт суурилсан болон урамшуулалт тарифын зохицуулалт гэсэн энэ тарифын механизмуудыг бол бие даасан хэсгүүд болгоод хуульд тусгачихсан байж байгаа. Өртгийн механизм бол өмнөх жилийн санхүүгийн тайланд үндэслээд 1 жилийн хугацаатай мөрдөгдөх тариф. Урамшуулалт тарифын механизм гэдэг нь болохоор 5 жилийн хугацаанд хэрэгжих механизм байгаа. Тарифын индексжүүлэлтийн хувьд бол индексжүүлэлтийг өсөх биш макро эдийн засагт үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг гэчихсэн байгаа. Өөрчлөлт нь бол нэмэх, хасах утгатай байж болно.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Үдээс хойш 15 цагаас нэгдсэн санал хураалтыг явуулна. Үдээс өмнөх чуулган завсарласан. 14 цагаас үргэлжлүүлэн хуралдана.

ЗАВСАРЛАГА.

Б.Пүрэвдорж: 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн үдээс хойших чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье. Дулаан хангамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байгаа. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууна.

О.Алтангэрэл: Дулаан хангамжийн тухай хууль яригдаж байгаатай холбогдуулан бас дулаанаар баяжигчдын талаар асууна. Энэ 10 аймгийн дулааны

станц гэж дуусдаггүй сэдэв байгаа. Гэнэт л энэ 10 аймгийн дулааны станц явахгүй байсан шалтгаан авлигатай холбоотой байсан юм байна. Монголын ард түмний мөнгөөр дараа нь төлдөг тэр зээлийг Солонгост авах зээлийг дундаас нь албан тушаалтнууд авчихсан юм байна, завшчихсан юм байна гээд ингээд л сүрхий яриад эхэлсэн. Одоо байхгүй. Хэн нь ч буруутай юм. Одоо эргээд ард түмэнд оногдох ногдол ашгаар энэ станцуудыг дахиж барих тухай яриад бид нар сууж байгаа. Үгүй ээ, одоо барихаас өөр аргагүй л дээ. Яг үнэндээ бол энэ Баянхонгор аймгийн төв, Өвөрхангай аймгийн төвд хагас дутуу баригдсан, тэр хэзээ орох бол гэж утаандаа дарагдсан 2 аймгийн төв, бүр эхлээ ч үгүй Архангай аймаг гэх мэтчилний хохирсон хүмүүс энд байгаа. Тэгэнгүүт одоо энийг тойрч ярьж байгаа асуудал нь зөвхөн тэрийг яаж дуусгах вэ, ямар эх үүсвэр болсноос биш нөгөө зогсоосон, авлига авсан гээд зарлаад байсан хүмүүс юу болсон бэ гэдэг нь мартагдчихаж байгаа юм. Тэгэхээр та бүхний боловсруулаад байгаа энэ хууль энэ дулааны салбарын авлига, авлигажсан нөхцөл байдалд яаж нөлөөлөх юм.

МАН-ын Засгийн газарт сайд хийж байсан Бат-Эрдэнэ гишүүн түрүүхэн энэ салбар бол тэр чигтээ авлига гээд ингээд түрүүн мэдэгдэж байна. Тэгэхээр би бол Бат-Эрдэнэ гишүүнийг худлаа ярьсан гэж бодохгүй байна. Мэдээд байгаа учраас энэ бол тэр чигтээ авлига юм байна лээ гэж хэлсэн байх.

Дараагийнх нь энэ дулааны үнэ нэмэгдээд байгаа. Ард иргэдийн амьдралд бол үнэхээр хүнд нөлөөлж байгаа. Энэ дулааны үнэ. Тэгэнгүүт энэчээ нэг ийм өгүүлбэр байгаа юм. Иргэн, хуулийн этгээдээс шууд гарах зардал үүсэхгүй гэж тооцсон гэж. Энэ хуулийн төслийн судалгаан дээр. Тоолуур тавина гээд байгаа юм. Тоолуур тавина, хүн болгон тоолууртай болох ёстой, тоолууруаа тавиул гээд айл өрх болгонд дарамт ирэх үү. Тоолууртай болчихсон юм чинь гээд одоо энэ асуултад хариулж байгаа хүмүүс, энэ салбарынхнаас бол ер нь алдагдлын тухай яриад байгаа. Энийгээ ард иргэддээ үүрүүлэх гэж байгаа юм биш биз дээ. Арай ядан амьжиргаагаа залгуулж ингэж явж байхад, бүх юмны үнэ нэмэгдэж байхад тоолууртай болсон. Энийг чинь хэмждэг болсон гээд ингээд халуун дулааных нь нөхцөл байдал сайжрахгүй, харин төлдөг мөнгө нь нэмэгдэх юм биш биз дээ. Энэ дулаан чинь зөвхөн хот суурин газарт хамаатай зүйлүүд биш шүү дээ. Сумын төвд хүртэл тэнд 1 уурын зуух ажиллуулж байгаа хүн болоод тэр уурын зуухыг дулааныг авч байгаа тэр хүмүүсийн хооронд маш том харилцаа явагддаг. Ямар эерэг өөрчлөлт гарах юм. Ард иргэдэд ямар хэрэгтэй юм. Эсвэл зүгээр л тоолууртай болгоно, дулааны алдагдлыг бууруулна, гадаадынхантай адилхан болно гэдэг ийм зорилгоор явж байгаа юм уу. Тэгэхээр асуулт бол 2 үндсэн чиглэлд очиж байгаа юм.

1 дүгээрт энэ дулаан, цахилгааныг тойрсон олон жил угсарсан энэ авлигын систем, үр дүн нь эхнээсээ гараад гацаад эхэлчихсэн энэ төслүүдийг урагшлуулахад яаж нөлөөлөх юм. Эерэг нөлөө, сайн нөлөө байгаа юм уу, үгүй юм уу.

2 дахь нь ард иргэдийн амьжиргаа ахуйд дарамт болох юм биш биз дээ. Төлдөг мөнгө нь ихсээд, хэрэглэдэг дулаан нь багасаад, хүнд суртал нь нэмэгдчих юм биш биз дээ гэсэн ийм асуултууд хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр 1 дүгээр асуулт болохоороо боловсруулж байгаа энэ хууль маань тэр төрийн хүнд суртал, авлига, хээл хахуулийг бууруулахад ямар үр өгөөж өгөх юм бэ гэж байна. Тэгэхээр ер нь яах вэ, энэ хүнд суртал, авлига, хээл хахуулийн 1 том үндсэн шалтгаан юу вэ гэхээр мэдээж нэгдүгээрх нь бол төрийн оролцоо маш их байгаад байгаа юм. Төрийн оролцоо. 2 дугаарх асуудал нь болохоор бид нар харилцаагаа хуульчлаагүй. Бүх юм журмаар явж байгаа. Энэ салбар маш ерөнхий товчхон хуультай. Тэгээд дулаан хангамжийг хууль дээрээ бараг 5 хувийн зохицуулалт байдаг. Тэгээд дулаан, цахилгаан хангамж талд 800 гаруй журмаар харилцаагаа зохицуулж байгаа. Тэгэхээр ийм салбар л зохицуулалтын хувьд маш тогтворгүй буюу тэр хүндрэл бэрхшээл, хүнд суртал ингээд гардаг юм байна. Тийм ч учраас энэ хуулиар бүхий л харилцаануудыг, тэр сумын төв, тэр аймгийн төвийн дулааны эх үүсвэр, хангамжийн асуудал бүгдийг нь цагаан дээр хараар тодорхой зохицуулж өгч байгаа учраас энэ асуудлыг гаргахгүй байх тал руу явж байгаа гэж ингэж ойлгож болно.

2 дугаар асуудал болохоор дулааныг одоо тоолууржуулахад иргэнээс зардал гарахгүй гэсэн байна. Тэгэхээр дулааны тоолуурыг бол хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмч байна. Өөрөөр хэлбэл дулаанаар хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч маань буюу тэр байгууллага энэ дулааны хэрэглэгчийн дулааны тоолуурыг тавих асуудлыг шийдвэрлэх ёстой. Гэхдээ мэдээж хэрэглэгч хүсэх юм бол би өөрөө ийм тусгай зориулалтын тоолуур тавья, юу байдаг юм, ингэсэн тохиолдолд бол бас тэр тохиолдол нь нээлттэй байж байгаа. Бусдаар бол хэрэглэгчийг та дулааныхаа тоолуурыг тавь гэдэг ийм эрх зүйн орчин бол байхгүй. Тэгэхээр энэ дээр бол бас хэрэглэгч дээр бол дарамт очихгүй байх гэж ингэж бодож байгаа.

2 дугаар асуудал болохоор дулааныг тоолдог болсноороо хүмүүс шударга өөрийнхөө хэрэглэсэн мөнгөө л төлнө. Одоо бол метр квадратаар үржигдээд, метр кубээр үржигдээд төлж байна гэдэг чинь энэ харин жинхэнэ шударга бус илүү их хэмжээний мөнгийг авч байгаа гэсэн үг байхгүй юу. Тийм ч учраас тэр сумын төв, тэр аймгийн төвүүдэд байгаа дулааны эх үүсвэрүүд чинь яаж байна гэхээр хэдэн төрийн байгууллагаас л тэр метр кубээр нь үржүүлээд л мөнгө авчхаад, хувийн хэвшлийн орон сууц, хувийн хэвшлийн тэр айл өрхийг дулаанаар хангахгүй гээд сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудал маань цэгцлэгдэнэ. Тоолууртай болсноороо бид нар бодитоор үнэ нь төлдөг болно. Тэгээд эрчим хүчний тэр дулааны эх үүсвэр гарахаараа бусад дулаанаар хангаж чадахгүй байгаа олон хэрэглэгчийг дулаанаар хангах боломж бололцоо бүрдэнэ л гэж ингэж хараад байгаа юм.

Б.Пүрэвдорж: Алтангэрэл гишүүн нэмж тодруулъя.

О.Алтангэрэл: Төсөл санаачлагч аа, яг 1 асуултад тодорхой хариулаад өгөөч. Одоо энд хууль тогтоогчийн хувьд суугаад, энэ хуулийн төслийг дэмжсэнээрээ ард иргэдийн төлдөг мөнгө нэмэгдээд, амьдрал ахуйд нь дарамт үүсэх ийм нөхцөл үүсэх юм бол бид энд хууль тогтоогч гэж суугаад хэрэггүй байна л даа. Тэгэхээр яг энэ хууль батлагдсанаар яг нэгж өрхийн ард иргэдэд төлдөг төлбөр мөнгө нь нэмэгдэх үү, үгүй юу. Маш энгийн асуудал. Арифметикийн маш энгийн нэмэх, хасах үйлдэл. Төлдөг мөнгө нь нэмэгдэх үү, үгүй юу. Та энд бүр яг тодорхой хариулаад өгөөч.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Миний харж байгаагаар бол ард иргэдийн төлдөг мөнгө нэмэгдэхгүй гэж харж байгаа. Яагаад гэхээр одоо та метр квадратаар үржүүлээд, та байхгүй байсан ч тэр мөнгө чинь ингээд гүйгээд байна шүү дээ. Гэтэл хүн тоолууртай болчихвол яах вэ, тэр битгий хэл тоолуураа бүр ингээд хаагаад нар сайхан тусаж байгаа юм байна. Би мөнгөө хэмнэхийн тулд тоолуураар ингээд хаачихъя. Тэгээд та өөрөө бүр хэмнэх сэдэл чинь бий болох байхгүй юу даа. Тийм учраас би бол тэгж харж байгаа. Хүн бол хэмнэх сэдэлтэй болно. Одоо тэр бодит хэрэглэсэн дулааныхаа мөнгийг л төлнө. Тэгээд цонхоо онгойлгож тохируулах биш тоолууpaapaa тохируулаад, мөнгөө хэмнэнэ. Хаадаг болно. Гадаад явлаа гэхэд чинь та яах вэ, хамгийн доод түвшин дээр тавиад хаачхаад л мөнгөө хэмнээд явах нь байна шүү дээ. Тийм учраас би бол тэгж метр квадратаар тооцсоноос тоолууpaap тооцсон нь хамаагүй шударга. Тэгээд мөнгө өснө гэж бол үзэхгүй байна.

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Дулаан үйлдвэрлэлийн асуудал бол манай улсын хувьд бас ийм өвөрмөц цаг ууртай, байгаль цаг агаартай орны хувьд бол чухал асуудал. Тэгээд зөвхөн Улаанбаатар төдийгүй Монголын энэ 330 сум, 20 аймгийн төв дулаан үйлдвэрлэж энэ хүйтэн өвлийг давж байгаа. Тэгээд аймгийн төвүүд бол бүгд маш их утаатай болсон. Энэ бол дулаан үйлдвэрлэж, өвлийг өнтэй давахын тулд л ингээд маш их энерги зарцуулж, маш их утаа гаргаж, тэгээд энэ өвлийг давж байна л даа. Тэгээд мэдээж энэ анхдагч хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр бас хувийн хэвшлүүд, техник технологийн шинэчлэлт, хөрөнгө оруулалт хийх, байгаль дэлхийгээ хамгаалах мөн эрчим хүчний хэмнэлттэй байх гээд олон наштай үзүүлэлт гарна гэж ингэж харж байгаа. Тэгээд би ч бас энэ хуулийг дэмжиж, хууль санаачлагчийн байр сууринаас явж байгаа. Тэгээд энд бол хамгийн чухал асуудал нь хэрэглэгчийн эрх ашиг, хэрэглэгчид очих тэр дулааны чанарын асуудал байгаа. Өнөөдөр найдвартай дулаан эрчим хүчээр хангагдах нь хэрэглэгчийн эрх ашиг. Мөн чанартай дулаан нийлүүлэх нь энэ дулаан үйлдвэрлэгчдийн үүрэг байх ёстой. Тэгээд өнөөдөр одоо ингээд хавар, намар дулааны цагт болохтойгоо зэрэг градусаа нэмдэггүй ч гэдэг юм уу, дулааны тэр чанар, градус бага гээд ийм гомдол мэдээллүүд бас хөдөө, орон нутагт ирдэг. Мөн аймгийн төвүүд, сургууль, цэцэрлэг, төрийн байгууллагууд барилга байшингийн дулаан маш муу байна. Өвөл ингээд хичээл сургалт янз бүрийн үйл ажиллагаа явуулахад хүнд байна гэдэг ийм асуудлыг ярьдаг. Тэгээд энэ дээр чинь л ингээд хэрэглэгч, нийлүүлэгч, үйлдвэрлэгчийн хооронд бөөн маргаантай асуудлууд чи, би гэдэг асуудлууд байдаг. Тэгэхээр энийг бол ингээд технологи инновац ашиглаад, тоолууртай болгоод ингээд яг тэр чанар, энэ зүйлийг нь хэмжээд явах нь бол маш чухал байгаа юм.

Тэгээд одоо бол хөдөө сумд чинь жишээлбэл дулаан үйлдвэрлэж байгаа газар бол хэдэн төрийн байгууллагыг л дулаанаар хангаж байгаа. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв. Түүнээс сумын төвд орон сууц байхгүй. Тэгээд аймгийн төв дээр болохоор орон сууцыг талбайн метр квадратаар нь тооцож дулааны үнийг авч байгаа. Сургууль, цэцэрлэг, энэ төрийн байгууллагуудыг болохоор метр кубээр тооцож дулааны үнийг тооцож байгаа. Тэгэнгүүт төрийн байгууллагууд маань хувийн айл өрхүүдээс хамаагүй илүү дулааны мөнгө төлж байна л даа. Энэ маань өөрөө төсөвт бас ачаалал болдог. Тэгээд өнөөдөр бид нар чинь энэ улсын төсвийнхөө ихэнх хэсгээр л энэ өвлийг давах гэж, энэ сургууль, цэцэрлэг, соёлын төв, эмнэлэг гээд энэ төрийн байгууллагуудаа халаах зардалд маш их зардал гарч байгаа. Тэгээд энэ бол одоо яах вэ, бидний үндэсний онцлог. Тэгээд ер нь цаашдаа

эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн гэсэн үү, газрын хүн байх шиг байсан. Тэнд сууж байгаа.

Тэгэхээр миний асуух гээд байгаа зүйл бол ингээд метр квадрат, метр кубээр тооцдогийг тоолуурт шилжүүлснээр, энэ зөв зүйтэй хэрэглээнд шилжүүлснээр ямар эдийн засгийн бодит хэмнэлт гарах вэ. Энэ дээр та бүгдийн хийсэн тооцоо судалгаа байна уу. Энэ улс, орон нутгийн төсвөөс гарч байгаа, халаалтын зардал дээр гарч байгаа мөнгөн дээр ямар, хэдэн хувийн хэмнэлт хэдэн хувийн наайтай үзүүлэлт гарна гэсэн ийм урьдчилсан тооцоо, ТЭЗҮ, тооцоолол байгаа юу. Ийм зүйлийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, энэ газрууд бас хийж байгаа байх гэж ингэж харж байна. Ийм зүйлийг асууя.

Мөн хууль санаачлагч Энхцэцэг гишүүн маань яг улс орон нутгийн төсөвт 1 жилд өдий хэмжээний дулааны зардлын хэмнэлтийг бол гарна гэсэн урьдчилсан тооцоо байвал бас хэлж өгөөч гэж ингэж хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Хосбаяр гишүүний хэлж байгаа үнэхээр үнэн. Одоо эрчим хүчийг ялангуяа хэрэглэгчид бол чанартай, найдвартай хүргэж байх ёстой. Гэтэл бид нар дулааныг бол үнэхээр эцсийн хэрэглэгч чанартай хүргэж чадахгүй байгаа. Төвлөрсөн дулаан хангамжаас явж байгаа шугам бол тодорхой хэмжээний бүсэд байгаа хэрэглэгчийг л чанартай хангаж чаддаг. Тэр маань бүр стандарт нь алдагдаад, бүр хэдэн мянган км ингээд үргэлжилчихсэн ийм шугамаар хэрэглэгчид чанартай хүргэж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ хууль дээр, ялангуяа орон нутгийн, сумын, аймгийн, нийслэлийн дулаан хангамжийн хөгжлийн схемийг яг тухайн тухайн бүс, бүсээр нь орон нутаг маань өөрсдөө боловсруулаад, тэр хот төлөвлөлтөө боловсруулаад, ямар эх үүсвэрээр, ямар найдваржилттайгаар, чанартайгаар хүргэх юм бэ гэдгээ шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоо, судалгаа хийгээд, төлөвлөөд, 5 жилээр батлуулж авна гэж байгаа. Тэгэхээр энэ дээр бол энэ асуудлууд шийдэгдээд явах ийм зохицуулалт орж ирж байгаа гэж байна.

Тэр дулааныг метр квадрат, метр кубээр тооцдог байсныг тоолууруар тооцохоор ямар хэмжээний үр ашиг гарах вэ гэж. Тэгэхээр та сая бас хэлж байна. Үнэхээр хөдөө, орон нутагт бол яг л төсвийн байгууллагын хэдэн хэрэглэгчийг л метр кубээр нь тооцоод мөнгөө аваад сууж байх сонирхолтой байдаг. Тэгэхээр тэнд бол асар их хэмжээний үргүй, их хэмжээний төлбөр явагдаж байна гэсэн үг. Энийг яг бодитой болгоод тоолоод ирэхээр тэн дээр тодорхой хэмжээний маш их хэмжээний хэмнэлт гарна. Хамгийн гол чухал дараагийн хэмнэлт бол дулааны эх үүсвэр бий болно. Бусад хэрэглэгчийг дулаанаар хангах боломж бололцоо бүрдэнэ гэж ингэж харж байгаа. Тэгээд ажлын хэсгээс Эрдэнэчулуун зөвлөх нэмж хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Эрдэнэчулуун доктор.

Х.Эрдэнэчулуун: Орон нутгийн төсөвт яг ямар хэмжээний хэмнэлт гарах вэ гэдгийг бол яг ийм тодорхой жишээ, тооцоогоор яг тоогоор илэрхийлэх тоо бол одоогоор хэлэх боломжгүй байна. Тэгэхдээ ер нь бол ямар хэмжээний хэмнэлт гарах вэ гэдэг маань тэр тоолуурыг ашиглаж байгаа байгууллага маань өөрөө дулаалгаа болон хэрэглээгээ тохируулах байдлаар ямар хэмжээний эрчим хүч

хэмнэх боломж өөрөө бий болгох вэ гэдгээс л хамаарах учраас бас яг энэ байгууллага ийм эрчим хүч хэмжих юм байна гэдэг ийм тооцооллыг бас шууд хэлэхэд хүндрэлтэй байгаа.

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Энэ хууль батлагдсанаар улсын төсөв, орон нутгийн төсөвтэй холбоотой зардалтай холбоотой маш том бас асуудал хөндөгдөх гээд байгаа юм л даа. Одоо бид нар чинь энэ улсын төсвийнхөө нэлээд ихэнх хэсгийг нь энэ барилга байшингуудаа халаах, цахилгаантай байлгах, дулаан өвөлжүүлэх, өвлийг өнтэй давахад л зарцуулж байгаа шүү дээ. Тэгэхтэйгээ зэрэг ийм том хуулийн төсөл бид нар хийж байхад сая тэнд Эрчим хүчний эдийн засгийн судалгааны хүрээлэн гэж хүн байсан шүү дээ. Би тэр хүнээс л асуугаад байгаа юм л даа. Танайх ер нь заавал яг нэг бүрчлэн детальный биш, ер нь зүгээр 10 хувийн ч юм уу, 15 хувийн ч гэдэг юм уу хэдэн хувийн яг ийм эрчим хүчний эдийн засгийн хэмнэлт гарах юм бэ. Ийм зүйл байна уу. Ер нь бид нар чинь бас энэ хуулийн төсөл, шинэ зүйлийг хийхдээ эдийн засгийн үр ашиг, юмыг нь бас сайн тооцдог, боддог баймаар байна.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон хариулъя.

Р.Батмөнх: Баярлалаа. Зөвлөх инженер Батмөнх. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ер нь хувийн хэвшил ч бай, аж ахуйн байгууллагууд ч бай дулааны хэрэглээг бол хэмжүүлж авахаар буурах нь бол гарцаагүй. Энэ дээр бид хамтарсан судалгаа хийсэн байгаа. Энэ судалгаан дээр яадаг вэ гэхээр нэгж байрны энгийн дулаан зарцуулалт 280 нэгж байсан. Энэ 280 нэгжтэй байшин дээр хэмжүүрт тавиад, барилгын дулаалгыг сайжруулахад дулаан алдагдлын хэмжээ 18 дахин буурсан. Энэ бол онцгой тохиолдол л доо. Тэгэхээр ер нь бид бол практик дээр энэ 18 гэдгийг бууруулдаггүй юм гэхэд шинэ төрлийн материал ашиглахад бол 10 дахин буурах техникийн боломж байгаа юм. Энэ 10 дахин бууна гэдэг чинь цаанаа эх үүсвэр дээр ийм нөөц бий болно..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минутаар тодруулъя. Нэмж хариулъя.

Р.Батмөнх: Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр 18 дахин багасаж байна гэдэг бол төлөх мөнгөний хэмжээ энэ пропорцоор багасна. Мөн яах вэ гэхээр цаана нь эрчим хүчний эх үүсвэр дээр ийм хэмжээний эрчим хүчний нөөц бий болно. Тэгэхээр энэ судалгаа бол Германы байгууллагатай хамтарч хийсэн судалгаа учраас бол баттай хэлж болно гэж ингэж танд дамжуулах байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын урилгаар Барилгын хөөсөнцөр хавтан хөгжүүлэлтийн манлай холбооны гишүүд болон барилгын дулаалгын материал үйлдвэрлэгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд үйлдвэрлэл, технологийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Хуулийг бол үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Бас хамтарч энэ хуулийг бас өргөн барилцаж байгаа. Энхцэцэг гишүүн маань бас мэргэжлийн хүний хувьд олон хараагүй заалтуудыг бас оруулсан. Цогцоор нь бас авч үзсэн ийм хууль байна гэж хэлмээр байна.

1 дүгээрт бол өөрөөсөө авхуулаад бодоход бид нар чинь ер нь хавартаа, намартаа цонхоо онгойлгодог. Одоо манай энэ Байнгын хорооны хурал болж байгаа зарим өрөөнүүд чинь үндсэндээ цонхоо онгойлгож, нэвт онгойлгохгүй бол бараг тэнд хүн ухаан алдаж унамаар л хүртэл байдалтай л байна л даа. Уг нь бол энэ дулааныг хэрэгтэй газар нь илүү өгч байвал бол эдийн засаг хөгжинө. Маш ойлгомжтой энгийнээр хэлэхэд. Тэгэхээр манай үндсэндээ дулааны тохируулга бол халуун, хүйтний тохируулга бол үндсэндээ цонх онгойлгох. Би 10 жилийн ерөнхий боловсролын сургуулиудаар явж байхад цонхоо онгойлгомоор байна. Хүүхдүүдээс судалгаа авсан авсан чинь ялангуяа хавар намрын улиралд цонхоо онгойлгомоор байна. Дэндүү бүгчим халуун байдаг гэж юу өгч байсан. Тэгээд яагаад цонхоо онгойлгоод болдоггүй юм бэ гэхээр хамгийн захад сууж байгаа хүүхэд даардаг учраас тэр цонхыг онгойлгодоггүй. Тэгээд манай ангид үндсэндээ бол ерөнхий боловсролын сургуулиудын агаарын чанар бол 4-12 дахин илүү зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарсан. Тийм учраас энэ 300 тэрбум орчим төгрөг эхний ээлжид бүх байгууллагуудыг дулааны тоолуур тавихад зарцуулна гэж байна. Энэ маань ойролцоогоор 3 жил, магадгүй 3 жилийн дулааны татаастай бараг тэнцчих хэмжээний мөнгө. Бид нар чинь ирэх жил 100 орчим тэрбум төгрөгийг эрчим хүч, цахилгаан, дулааны үнэ нэмээгүйн төлөө татаасаар явж байгаа. Одоо энийг удаан барих боломжгүй. Эсвэл үнээ нэмье, эсвэл хэмнэе гэдэг юм руу орох ёстой. Тийм учраас бол энэ дулааны тоолуурыг та бүгд маань ер нь 1 айлд тавиулахад, тухайн айлууд цахилгааны тоолуурыг бол өөрсдөө авдаг шүү дээ. Айлуудаар тавихад өртөг жин нь дунджаар ямархуу үнэтэй байх бол. Айлууд өөрсдөө дулааныхаа тоолуурыг тавья гэвэл. Энэ талаар тодорхой судалгааг хэлж өгөөч гэж. Магадгүй сонирхолтой байгаа байх энэ хуультай холбоотойгоор.

2 дугаарт хүний нөөцийн асуудлыг бас тусгаж өгсөн байна. Энэ бол маш сайн. Нэлээн олон асуудлууд дээр. Бид нар аливаа хууль хийхээрээ хүнийг нь хаячихдаг. Баахан техник технологи, баахан бүтэц яриад л явчихдаг. Гэтэл яг ний нуугүй хэлэхэд манай эрчим хүчний салбар бол хүний нөөцийн дутагдалд бол орж байгаа. Тэртээ тэргүй хүнд нөхцөлд ажилладаг, цалин хөлснийх нь өрсөлдөх чадвар унасан. Тийм учраас тэртээ тэргүй хүнд нөхцөлд ажиллаж байгаа бол бид нар гадаадад явж ажиллая, эсвэл уул уурхай руу оръё гэдэг ийм хүний нөөцийн урсгал гадагшлах урсгал их өндөр байгаа юм. Тийм учраас би энэ дулааны өртөг тооцох дээр хүнтэй холбоотой, хүний нөөцтэй холбоотой зардал гэдэг дээр хүссэн, хүсээгүй орж ирж байгаа. Одоо нийт цалингийн чинь дийлэнх нь зардлын өндөр хэмжээтэй байгаа.

Гэхдээ магадгүй зардлаа хэмнээд, үр ашгаа сайжруулаад ингээд эхлэх юм бол ялангуяа мэргэшсэн мерит зарчмаар явж байгаа мэргэжилтнүүдийг элдэв янзын улс төрийн томилгоо гэдэг юм уу, эсвэл янз бүрийн шалтгаанаар энэ том, том дулааны байгууллагуудыг толгойлуулаад тавиад баймааргүй байна. Ялангуяа ажилчидтай уулзахад энийг хэлдэг юм. 20, 30 жил ингээд ёстой тоос шорооноос нь авхуулаад жирийн техник механикчаас нь авхуулаад дээшээ гараад ирэхээр хэзээ ч нар үзүүлэхгүй. Тэгээд л улс төрийн томилгоо. Нөгөө хүн нь хүрч ирээд яадаг вэ гэхээр багаа бүрдүүлнэ гэдэг. Тэр хүнд бол магадгүй тэр техникийн аюулгүй байдал гэхээсээ илүүтэйгээр өөрөө яаж түрүүний хэлдэг тэр боломжийг нь өөртөө ашиглах

вэ ч гэдэг юм уу, эсвэл тэр томилсон хүндээ яаж үйлчлэх вэ гэдэг л байх л даа. Тийм учраас үүнтэй холбоотой бас 200 мянган төгрөгөөр дулаан авахад хураамж төлдөг юм байна. Манай орон сууцны олон байгууллагууд бол хардаг байх. Магадгүй зарим нь 2 өрөө байр өгч байж авна гэдэг ийм юм хүртэл ярьдаг. Ийм зүйлууд байхгүй болох ёстой шүү гэдгийг бас .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмээд 1 минут тодруулъя.

С.Эрдэнэбат: Бас 1 санаа зовж байгаа асуудал. Хүссэн, хүсээгүй Монгол Улс тархай бутархай. Сумын уурын зуухны өр төлбөрийн асуудал гээд бараг бүх суманд байх шиг байна. Нэгдсэн дулаанд холбосон нь сайн. Гэхдээ нэг нөхөр аваачаад ерөөсөө ингээд хэмнэлтийн тоолуур хийнэ гэсэн чинь үгүй ээ, би хөрөнгө оруулалтаа хийнэ, би үнээ буулгахгүй, би кубээрээ тооцно гээд байвал энийг яаж зохицуулах вэ. Цаашдаа магадгүй шинээр нэгдсэн системд холбохоор байж байгаа, нэгдсэн системд болон бие даасан дулааны юун дээр төр хамаагүй оролцохгүй гээд байна шүү дээ. Тэгэхээр үнийг нь 2 дахин тавьчхаад би ийм л үнээр нийлүүлнэ. Манай зардал ингэж өссөн гээд суугаад байхыг яаж зохицуулах вэ. Тэгэхгүй бол магадгүй зүгээр муугаар бодоход тэр сум магадгүй тэр дулааны өрөндөө шүүхдээд л янз янзын объектуудыг нь авчихдаг л юм байна лээ л дээ. Тэр сургууль, цэцэрлэгээс авхуулаад. Манай ихэнх сургууль, цэцэрлэгүүдийн газрууд дулааны өрөндөө болоод тэндээ газраа алдсан тийм гашуун туршлагатай байдаг юм байна лээ. Энийг яаж хааж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн асуултад хариулъя.

М.Энхцэцэг: Хүний нөөцтэй холбоотой энэ хууль дээр нэлээн нарийвчилсан зохицуулалтууд орж ирж байгаа. Тухайлбал, дулаан хангамжийн байгууллагууд нь дулаан хангамжийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх. Үнэ тарифын хэсэг дээр бас яг маш тодорхой хүний нөөц, түүнтэй холбогдох зардлыг салбарын хэмжээнд мөрдөгдөх норм дүрэм эсвэл техник, технологийн стандартад нийцүүлэн хянаж хэрэгжүүлнэ. Салбарын хүний нөөцийн бодлого, ажил олгогч, үйлдвэрчний эвлэл хооронд байгуулсан хамтын хэлэлцээрт нийцүүлэн ажилтны нийгмийн зардлыг тооцож, үнэ тарифтаа тусгана. Салбарын норм дүрэм, стандартад үндэслэн хүний нөөцийн тоо хэмжээ, цалингийн зардал, НДШ-ийн зардлын тооцоог мөн үнэ өртөгтөө тооцож тусгана гээд нэлээн нарийвчлалтайгаар оруулж ирсэн байгаа.

Сая тэр үнэ өсөх дээр яаж хянах вэ, хамгаалах вэ. Хэрэглэгч дээр би тэдээр зарна гээд ингээд гэдийгээд суучих юм биш үү гээд тэгж байна. Тэгэхээр төвлөрсөн дулаан хангамжийн хувьд бол угаасаа үнийг зохицуулах хороо бол зохицуулаад явна. Харин тэр хэсэгчилсэн дээр болохоор зохицуулах хороо зохицуулахгүй явна. Харин 50 дээр нэмэх нь 1 хэрэглэгч гомдол гаргаад, зохицуулах хороонд энэ нөхөр намайг маш өндөр үнээр дулаанаар хангаад байна. Энийг шалгаач ээ, хянаач ээ төр л юм бол иргэнээ хамгаалаач ээ гэдэг хүсэлт гаргасан тохиолдолд зохицуулах хорооны зүгээс хөндлөнгийн аудит хийнэ. Тэгээд энэ төрлийн хөндлөнгийн аудит хийгээд мэдээж үнэ тариф дээр нь зөвлөмж өгч ажиллана. Тэгээд энэ төрлийн гомдол 3 удаа ирсэн тохиолдолд үнэ тарифыг зохицуулдаг болно гэсэн байдлаар хуульд тусгаж өгсөн байгаа. Тэгээд ажлын хэсгээс бас нэмэлт хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон хариулъя.

Х.Эрдэнэчулуун: Зөвлөх инженер Эрдэнэчулуун. 1 айлд тоолуур тавих өртгийг яаж тооцсон бэ гээд 320 гаруй мянган хэрэглэгчийг тоолууpаар хангахад 350 орчим тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоог бол Эрчим хүчний зохицуулах байгууллага гаргасан байгаа. Тэгэхдээ энд бол 1 айлд шилжүүлэхээр 1 1 тоолуурын өртөг бол 1 сая орчим төгрөг байж байгаа. 1 өрхийг тоолууpаар хангах зардал бол. Тэгэхдээ энэ дээр анхаарах ёстой юм нь юу вэ гэхээр зэрэг манай Монгол Улсын хэмжээнд бол дулааны тоолуур нийлүүлэх зах зээл бол нэлээд өрсөлдөөнгүй, илүү ийм монопол байдаг юм байна лээ. Тэгэхээр зэрэг бүх хэрэглэгчийг тоолууржуулах энэ зохицуулалт хэрэгжээд ирэхээр энэ зах зээл нээлттэй, өрсөлдөөнтэй болохоор энэ үнэ бас буурах боломжтой байх гэсэн ийм хүлээлт бол байж байгаа.

Дулааны эрчим хүчний тэр задгай хэрэглээг бол энэ хуулийн гол үзэл баримтлал маань дулааны эрчим хүчийг тоолууpаар тооцно л гэж байгаа. Тэгэхээр зэрэг задгай тариф гэсэн ойлголт бол цаашдаа хэрэгжихгүй .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Дулааны шинэчлэлийг бол хугацаа алдалгүй хийх ёстой ийм зүйл байгаа юм. Энэ удах тусам шугам сүлжээ маань улам хуучирч, зардал улам нэмэгдэнэ, авлига улам нэмэгдэнэ, татаас улам нэмэгдэнэ. Тэгэхээр энэ дулааны шинэчлэлийг бол зайлшгүй, хурдан цаг алдалгүй хийх ийм зайлшгүй шаардлага байгаа.

Тэгээд энэ өргөн мэдүүлсэн хуультай холбогдуулж хуулийн төсөлд маань завсрын шилжилттэй холбоотой ерөөсөө заалт байхгүй байгаа. Тэгэхээр энэ хууль маань нэлээн салбарын шинэ ийм зохицуулалтууд байгаа. Тэгээд хуулийн төсөл маань 66 дугаар зүйл буюу хариуцлагын заалтаар дуусаж байгаа юм. Тэгэхээр хүчин төгөлдөр болох хугацаа бол энгийн горимоор буюу хэлэлцэгдэж дуусаад шууд хүчин төгөлдөр болж, мөрдөж эхлэхээр, өөрөөр хэлбэл яг энэ халаалтын энэ улиралд өвөл жишээлбэл энэ хууль хэрэгжиж эхлэхээр иймэрхүү байдалтай харагдаж байна.

Тэгээд энэ хуулийг бас дагалдуулж өргөн барьсан Эрчим хүчний тухай хуульд болохоор энэ тусгай зөвшөөрлүүдийг дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрлүүд бас хүчингүй болохоор байгаад байгаа юм. Тэгэхээр энэ шилжилтийн зохицуулалтуудыг оруулах ийм зайлшгүй шаардлага харагдаж байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бас хууль санаачлагчийн зүгээс ер нь энэ заалтыг нэмэх, хэлэлцүүлгийн явцад нэмж сайжруулах, мөн дагаж мөрдөх хуультай холбоотой ийм төсөл бас оруулж ирэх шаардлагатай харагдаж байгаа. Дээр нь 20 гаруй журам аргачлалтай холбоотой заалтууд хуулийн төсөлд байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой хугацаанууд нь ерөөсөө байхгүй. Тэгэхээр хугацаануудаа бас тодорхой болгож оруулж ирмээр ингэж санагдсан. Тэгэхээр энэ завсрын зохицуулалттай холбоотой хууль санаачлагчийн зүгээс бас энэ дээр юу гэж бодож байгаа талаар асууя.

2 дугаарт нь болохоор 13.5.4-өөр төлбөрөө хугацаандаа төлөөгүй хэрэглэгчдийн дулааныг түдгэлзүүлэх, хязгаарлах ийм эрхтэй байгаа. Тэгээд энэ эрхийг хязгаарлахгүй байх юу нь болохоор 60.4-д заасан онцгой байдлын

жагсаалтаар л хязгаарлагдаж байгаа юм. Тэгээд өөрөөр хэлбэл ахмад настан ч юм уу, бага насны хүүхэдтэй өрхүүдийг өвөл жишээлбэл дулааныг нь таслах ийм эрх зүйн орчин нь нээгдчихсэн байгаа. Тэгээд үүнтэй холбоотой ямаршуу өөр зохицуулалтууд бусад хуулиуд дээр ч байна уу. Энэ талаар хууль санаачлагчийн зүгээс яаж харж байгаа вэ гэсэн ийм 2 дугаар асуулт байна.

Дээр нь энэ Засгийн газрын санал дээр техникийн нөхцөлийг барилга барихаас өмнө олгох зохицуулалт Засгийн газрын санал дээр байгаа. Тэгээд энэ саналыг тусгаж аваагүй байсан. Энийг яагаад аваагүй гэдэг талаар 1 асуулт байна.

Тэгээд ер нь цаашдаа энэ ажлын хэсэг дээр оролцогч талууд бас нэлээн чухал учраас хэлэлцүүлгийн явцад бол аж ахуйн нэгжүүдтэй, газруудтай нэлээн олон хэлэлцүүлгийг хийсэн байна лээ. Мянга гаруй оролцогчид орсон гээд нэлээн өргөн хэмжээний хэлэлцүүлгүүд хийсэн байгаа. Яг энэ хуульд хэлэлцүүлгийн явцад салбарын яамд болон ажлын хэсэгтээ энэ бодлого боловсруулж байгаа бүтцүүдийг, төрийн бүтцүүдийг бас нэлээн оролцоод, Эрчим хүчний зохицуулах хороо, дулааны станцууд, түгээх компаниуд, хэрэглэгч болон бизнес эрхлэгчдийн төлөөллүүдийг бас өргөнөөр оролцуулж энэ ажлын хэсгээ байгуулбал илүү бас энэ хууль бодит амьдрал дээр шууд гараад хэрэгжихэд илүү дөхөмтэй юм болов уу гэж бодож байна. Ийм асуултууд байна.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Завсрын зохицуулалтын хугацаатай холбоотой. Тэгэхээр одоо байгаа Эрчим хүчний тухай хууль дээр бол дулааны зохицуулалт 5 хувьтай байгаа. Дээрээс нь дулаан хангамжийн хувьд зохицуулагдаагүй маш олон харилцаануудыг цоо шинээр энэ хууль дээр зохицуулж өгч байгаа. Тэгээд дээрээс нь нэн тэргүүнд хэрэгжүүлээд явах ёстой байгаа нэлээн олон заалтууд байгаа учраас энэ хууль бол аль болох эрт хэрэгжээд явах нь зүйтэй гэж зүгээр харж байгаа юм. Тэгээд ажлын хэсэг Улсын Их Хурал дээр байгуулагдаад явахад зарим заалтууд бэлтгэл ажлаасаа хамааралд шилжилтийн заалт байдлаар бол хугацаа нь тавигдаад ороод ирэх ийм бүрэн боломжтой байгаа.

2 дугаарт болохоор тэр бид нар нөгөө дулаан хангамжийн байгууллагуудын эрх нь юу юм, үүрэг нь юу юм гэдгийг нэлээн тодорхой болгож нарийвчилж өгсөн. Тэгээд эрх гэдэг дээр бас яг тэгж байгаа. Хэрвээ ингээд дулааны төлбөрөө төлөөгүй эсвэл дулааныг хууль бусаар хэрэглэж байгаа энэ тохиолдолд бол дулааныг таслах тийм эрхтэй байна гэдэг ийм байдал дээр тусгасан байгаа. Гэхдээ сая хэлж байна. Нөгөө настай хүн, өндөр настай хүн, хөгжлийн бэрхшээлтэй ч юм уу ийм хүмүүс дулааны төлбөргүйгээс болоод дулаанаа таслуулах асуудал үүсэхгүй биз дээ. Энийг хамгаалах ямар заалтууд орж ирсэн бэ гэж байна. Тэгэхээр хамгаалах бас тодорхой заалтууд энэ дээр байж байгаа. Одоо тусгай хамгаалах хэрэглэгчдээ бол тодорхойлоод, тэр хэсэг дээр бол төр онцгойлон анхаарал хандуулаад явна гэдэг ийм заалт байж байгаа.

Тэр барилга барихаас өмнө техникийн нөхцөл олгох гээд техникийн нөхцөл ерөөсөө одоо ч гэсэн бас яг барилга барихаас өмнө техникийн нөхцөлөө олгоод ингээд явж байгаа. Техникийн нөхцөл гэдэг бол угаасаа сүлжээнд холбогдохоосоо өмнө та ийм техникийн шаардлагыг хангасан тохиолдолд таныг сүлжээнд холбоно шүү гэдэг ийм бичиг баримт. Тэгэхээр энэ асуудал бол хуульд тусагдсан байгаа гэж

зүгээр ойлгож байгаа. Тэгээд Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдахаар дэд ажлын хэсэг байгуулагдана. Тэгэхээр тэр дэд ажлын хэсэг дээр ЭХЯ, зохицуулах хороо болон дулааны шугам сүлжээ, станцуудаас бол ажлын хэсгүүд дэд ажлын хэсэгт бол ороод, энэ хуулийг сайжруулах ажил дээр ажиллаад явах бүрэн боломжтой байгаа. Ажлын хэсгээс нэмж хариулт өгөх үү.

Б.Пүрэвдорж: Одоо Монгол Улсын зөвлөх инженер Эрдэнэчулуун. 4 дүгээр микрофонд хариулна.

Х.Эрдэнэчулуун: Тэр нөгөө настай, халамж шаардлагатай хүмүүсийг хэрхэн хамгаалах вэ гэсэн асуултад хариулъя. Хуулийн 9 дүгээр зүйлийн нэгж дэх төрийн удирдлагын чиг үүрэг гэдэг зүйлд 9.1.6-аар зорилтот бүлгийн иргэдэд дулааныг хэмнэх болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой зардлыг нөхөх, нийгмийн тусламж үзүүлэх журмыг боловсруулж мөрдөх гэсэн заалт орсон байгаа.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын Оргил сургуулийн Янжинлхам багштай 12.1 дүгээр ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэж, ЭЕШ-аа сайн өгч, хүссэн сургуульд орохын ерөөлийг өргөн дэвшүүлье.

Одоо Чинбатын Ундрам гишүүн асуулт асууна.

Ч.Ундрам: Манайх шиг эрс тэс уур амьсгалтай оронд дулааны эрчим хүч бол маш чухал. Тэгээд анх би 2020 онд Их Хурлын гишүүнээр сонгогдоод, Сэлэнгэ аймгаас сонгогдоод байж байхад Сэлэнгэ аймгийн төв Алтанбулаг гэх мэт зарим сумд бол ер нь хөлдөхөд тун ойрхон байсан. Хүүхдүүд цэцэрлэгтээ куртикээ өмсөөд сууж байдаг байсан. Жирэмсэн ээж маш хүйтэн эмнэлэг дотор амаржиж байсан ийм нөхцөл байдалтай. Тэгээд манай Сэлэнгэ энерго гээд дулааны станц маань 8 тэрбум төгрөгийн өрөнд орчихсон, зуух нь эвдэрчихсэн ийм нөхцөл байдалтай. Тэгээд тухайн үед ЭХЯ-аас ажлын хэсэг гаргаад шалгалт хийгдэж байсан. Тэгээд хуримтлагдсан олон жилийн өр, бас хууль бус зарцуулалт, нүүрсний мөнгөө нүүрсээ авлаа гэсэн мөртөө аваагүй, мөнгийг нь шилжүүлчихсэн ч байдаг юм уу маш олон ийм зөрчлүүд байсан. Сумын уурын зуух бол бас бүр ярих юм байхгүй. Янз бүрийн улс төрийн нөлөө бүхий хүмүүстэй ойрхон хүмүүс хувьчлаад авчихсан. Тэгээд тэрэндээ засвар үйлчилгээ хийдэггүй, сүүлдээ бүр ерөөсөө ямар ч ажиллагаагүй болчихсон. Шинээр байшин бариад сум дээрээ бизнес хийх гээд зорьж байгаа хүний байр нь хөлдчихсөн. Тэгээд тэрний хохирлыг төлөх хүн байхгүй, ямар ч шүүх, цагдаад хандаад ямар ч боломжгүй амьдралаараа хохирсон ийм ард иргэд хүртэл надтай уулзаж байсан. Тэгээд яах вэ, энийг Их Хурлын гишүүний хувиар хөөцөлдөөд, төсвийн татаасыг нь нэмж байгаад, 1 зуухыг нь солиод, ингээд явсаар байгаад яваандаа бас төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бид нар 70мвт-ын ДЦС-тай болоод, одоо ингээд нээлтээ хийх гээд байж байна л даа. Тэгээд яг үүн шиг ийм одоо орон нутгийн засаг захиргааны нэгжүүд бол зөндөө байгаа байх гэж бодож байна.

Тэгэхээр энэ хууль батлагдсанаар орон нутгийн дулаан хангамжийн асуудал илүү цэгцтэй зөв болох уу. 1 дүгээр асуудал.

2 дугаарт энэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар манай Сэлэнгэ аймгийн төвд баригдаж байгаа энэ дулааны станц уг нь маш богино хугацаанд барихаар төлөвлөгөөтэй ажиллаж байсан боловч шат шатны Эрчим хүч хүчний яамнаасаа авхуулаад хүнд суртал, авлигын асуудал бас байгаа байх гэж би хардаж байгаа. Энэ хүнд суртлаас болоод маш удаан, маш олон юман дээр гацсан. Тэгээд яалт ч үгүй бид нар Сэлэнгэ аймагт дулааны асуудлаа шийдэх маш өндөр хэрэгцээ байгаа учраас аймгийн Засаг даргатайгаа ч тэр, би ч тэр Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүдтэй ингээд хөөцөлдсөөр байгаад арайхийж энийг 2 жилд ашиглалтад оруулах гээд ингээд явж байгаа юм. Гэхдээ маш их хүнд суртал. Түрүүн гишүүд ч хэлж байна. Шат шатандаа маш их хулгай байна гээд. Тэгэхээр энэ бүх юм чинь цэгцрэх үү.

Дараа нь энэ Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг, саналыг нь би харж байна л даа. Энэ Засгийн газар чинь энэ хуулийг дэмжихгүй байгаа юм биш үү. Бүр ингээд өчнөөн хуудас юм биччихсэн. Тэгээд зарим нь Эрчим хүчний тухай хуулийн заалтуудтай зөрчилдсөн байна, давхацсан байна, уялдуулах шаардлагатай байна гээд олон юм байна л даа. Жишээлбэл энэ Засгийн газрын тэмдэглэлийн 1.5-д эрчим хүчний диспетчерийн зохицуулалт нь зөрчилдсөн байна гээд байж байна. Мөн энэ өргөн барьсан хуулийн төсөлд чинь төрөөс өгөх татаас санхүүжилт гээд бүхэл бүтэн 9 дүгээр бүлэг байна. Энэ чинь хэт төрөөс бас хараат болгох гээд байгаа юм биш үү. Засгийн газрын саналын 8 дугаарт хэрвээ дулаан түгээх байгууллага нь дулааны зүй бус хэрэглээг олж илрүүлэх юм бол 3 дахин нэмэгдүүлнэ гэсэн эрх байна. Энэ чинь бас болохгүй гэх мэтчилэн энэ яам чинь өөрөө энэ хуулийг дэмжихгүй байгаа юм биш үү.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа орон нутгийн, ялангуяа сум, аймгийн дулаан хангамжийн асуудал бол илүү эмх цэгцтэй болох юм биш үү гэж асууж байна. Тэгэхээр ялангуяа дулаан хангамжийн асуудлууд гэдэг бол үнэхээр орон нутгийн оролцоо бол маш өндөр байх ёстой юм байна лээ. Маш өндөр. Тийм ч учраас орон нутгууд маань тэр аймаг, сумынхаа дулаан хангамжийн асуудлыг, тэр бүсээр нь төлөвлөөд, шугам сүлжээг нь төлөвлөөд, дулааны эх үүсвэрийг ямар эх үүсвэр барих юм, тэр эх үүсвэр нь ямар хэрэглэгчийг хангах юм гэдгийг нь маш тодорхой төлөвлөөд, дулаан хангамжийнхаа хөгжлийн схемийг иргэдийн төлөөлөгчийнхөө хурлаар 5 жилийн хугацаанд боловсруулаад, 5 жил тутамдаа шинэчлээд явж байх ёстой гэдэг ийм зохицуулалт орж ирж байгаа.

Одоо бид нарын том асуудал юу байгаад байна гэхээр үнэхээр төвлөрүүлчихсэн. Хамаг эрх мэдлийг ЭХЯ дээр төвлөрүүлснээс болоод өнөөдөр аймаг, сумын төвүүд маань энэ дулаан, цахилгааны асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа. Одоо харьцангуй яг энэ хуулиараа бид нар тэр хэсэгчилсэн, бие даасан, дээрээс нь орон нутгийн оролцоог нэлээн сайн нэмэгдүүлж өгснөөрөө тэр жишээ нь Сэлэнгийн 70мвт-ын станц гэхэд чинь ерөөсөө л эрчим хүчний царайг хараад, ЭХЯ-аас зөвшөөрлөө авч чадахгүй маш удсан. Ажил нь удааширсан. Тэр хэмжээгээр тэр зээл авсан өртөг, мөнгө нь гүйсэн гээд их хүндрэл бэрхшээл байдаг. Энэ тохиолдолд яг энэ хэсэгчилсэн, бие даасан, дээрээс нь орон нутгийн оролцоог нэмэгдүүлснээрээ энэ асуудал шийдэгдэнэ гэж ингэж харж байгаа.

Тэгээд Засгийн газар чинь дэмжихгүй байгаа юм биш үү гээд. ЭХЯ-ны хувьд, Засгийн газрын хувьд дулаан хангамжийн бие даасан хуультай болохыг бол бүрэн дэмжиж байгаа. Тэгээд энэ дулааны хуулиа эрчим хүчний хуультайгаа уялдуулах асуудал дээр нэлээн олон бас саналууд ирсэн. Энэ саналын дагуу бид хууль дээрээ өөрчлөлтүүдийг оруулаад өргөн барьсан байгаа. Тэгээд энэ хуулийг боловсруулах Улсын Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэг бол бараг бүтэн жилийн хугацаанд ажилласан. Нийтдээ манай ажлын хэсэг бол 24 удаа хуралдсан байна. 24 удаагийн хуралд манай ажлын хэсэг дээр жишээ нь Эрчим хүчний Найдалаа бол маш идэвхтэй оролцож байсан. Бид нар 24 удаагийн хурал хийхэд 55 хувь дээр нь Эрчим хүчний сайд Найдалаа, Золжаргал гишүүн, Цэнгүүн гишүүн бол маш идэвхтэй ингэж оролцсон байна. Тэгээд Энхтуяа гишүүн, Жаргалан, Анар гээд энэ гишүүдтэй ажлын хэсэг бол анх байгуулагдаж, энэ хуулийн ажлын хэсэг дээр ажилласан. Дээрээс нь үүний дараа маш олон гишүүд бас нэмж орж ажиллаж байсан. Хуулийн ажлын хэсэг дээр Алтаншагай, Жангабыл, Идэрбат, Наранбаатар, Сандаг-Очир, бүр Чинбүрэн гишүүн хүртэл энэ дулаан хангамжийн хууль дээр бид нар Улсын Их Хурал дээр тасралтгүй ажиллаж явсан. Тэгээд ажлын хэсгээс нэмж хариулах уу.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Эрдэнэчулуун инженер.

Х.Эрдэнэчулуун: Дулаан хангамжийн өнөөгийн нөхцөл, төлөв байдал Улаанбаатар хот төдийгүй аймаг, орон нутагт ямар байдалтай байгаа вэ гэдгийг нэгдсэн байдлаар үнэлдэг ийм тогтолцоо Монгол Улсын хэмжээнд байхгүй. Тэгэхээр зэрэг бид нар аль аймаг маань яг дулаан хангамжийн хүртээмжийн хувьд техникийн аюулгүй, найдвартай байдлын хувьд ямар түвшинд байгааг хэлж чадахгүй байгаа албан ёсоор. Тийм учраас энэ хууль дээр ямар механизм бичиж өгч байгаа вэ гэхээр дулаан хангамжийн төрийн захиргааны төв байгууллагын эрх, чиг үүрэг дээр дулаан хангамжийн системийн техник, технологи ашиглалтын найдвартай байдал болон эдийн засгийн хүртээмжтэй байдлыг хянах, үнэлэх журмыг баталж мөрдөнө гэсэн ийм заалт орж ирж байгаа. Тэгэхээр ийм журам батлаад хэрэгжүүлээд ирэхээр бид нар тогтолцооны хувьд дулаан хангамж маань Монгол Улсын хувьд ямар хэмжээнд байгаа юм, ямар үнэлгээтэй байгаа юм, ямар хүртээмжтэй байгаа юм гэдгийг системтэйгээр үнэлээд дүгнээд явах ийм механизм бүрдэнэ гэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя. Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Би түрүүн бас асуулт дээр асуусан. 9 дүгээр бүлэг гээд хамаг юм дулаан хангамжийн салбарт үзүүлэх дэмжлэг гэж байгаа юм. Хэт төрөөс хараат болчих вий гээд. Энэ 44.1.2 дээр та түрүүн хууль санаачлагчийн илтгэл дээрээ дулааны шинэ эх үүсгүүрүүд бол төр хувийн хэвшлийн түншлэлээр явж болно. Дамжуулах, түгээх сүлжээ нь бол төрийн эзэмшилд байх нь зөв гээд түрүүн хэлж байсан боловч энэ 44.1.2 дээр дулааны шинэ эх үүсгүүр дамжуулах, түгээх сүлжээ барьж байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхийг дэмжинэ гээд биччихсэн байна л даа. Тэгээд миний бодлоор эрчим хүчний бас улс үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд бид нар дамжуулах, түгээх бүх сүлжээнүүд нь улс хариуцаад явах ёстой юм биш үү. Өмнө нь бид нар бас 1 алдаа гаргачихсан байгаа шүү дээ. Хамаг дамжуулах, түгээхүүдээ хувийн хэвшилд хувьчилчихсан. Тэгээд мэдээлэлд ойр хүмүүс нь авчихсан ийм юм байдаг..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хариулах юм уу. Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Маш чухал асуулт асууж байна. Тэгэхээр төвлөрсөн дулаан хангамжийн системийн хувьд дамжуулах сүлжээ бол төрийн мэдэлд байна гэдгээрээ байж байгаа. Түгээх сүлжээ бол хувийн хэвшлийн юугаар байна. Харин нөгөө хэсэгчилсэн сүлжээн дээр болохоор эх үүсвэр барих, дамжуулах, түгээх сүлжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барихад төрийн зүгээс бол дэмжлэг үзүүлж ажиллана гэдгээр энэ хуулийн заалт орсон. Энэ ажлын хэсгээс бас тодруулж хариулах уу.

Б.Пүрэвдорж: Индрийн 4. Өөрөө гүйцэд хариулна шүү.

Х.Эрдэнэчулуун: Энэ төсвийн дэмжлэг гээд нэлээн олон салбарт үзүүлэх дэмжлэгүүдийг ерөнхий байдлаар томьёолсон ч гэсэн 48 дугаар бүлгийн төсвийн дэмжлэг гэдэг хэсэг дээр орон нутгийн болон улсын төсвийн дэмжлэг гэж юу юм, хөрөнгө оруулалт гэж юу юм, татаас гэж юу юм бэ гэсэн асуудлуудыг нарийвчилсан байгаа. Тэгээд энэ дээр бол улсын төсвөөр оруулах, улс болон орон нутгийн төсөвт дараах асуудлуудыг тусган хэрэгжүүлнэ гэдэг дотор бол дулаан хангамжийн хөгжлийн схемийг боловсруулах, дулаан хангамжийн системийн ТЭЗҮ боловсруулах, дулаан дамжуулах сүлжээг барьж өргөтгөх гэсэн ийм заалт орсон байгаа. Тэгэхээр дамжуулах сүлжээн дээр бол төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх боломжтой байхаар заасан байгаа. Тэр дээр харин дамжуулах гэдэг үг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Отгоны Саранчулуун гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна.

П.Ганзориг: Энэ дулаан хангамжийн асуудлыг эрчим хүчнийхээ энэ хуулиудаас тусад нь гаргаад, нэлээн нарийн зохицуулалттай болгож байгаа нь бол зөв. Гэхдээ энэ цаг хугацааны хувьд, дараллын хувьд эхлээд нь Эрчим хүчний тухай хуулийг бүхэлд нь шинэчилж байгаа. Эрчим хүчний хууль буюу энэ суурь хуулиа эхлээд явуулж байж, эсвэл зэрэгцүүлээд энэ Дулаан хангамжийн тухай хуулиа явуулахгүй бол бас үндсэн суурь хуультайгаа үзэл баримтлалын хувьд, концепцын хувьд зөрчилдөх зүйлүүд бас их харагдаж байна. Тухайлбал, түрүүн бас гишүүд хэлж байна. Энэ Засгийн газраас энэ хууль дээр өгсөн санал дээр хуулийн төслийн нэлээд олон бүлэг, зүйл заалт, хэсэг нь Эрчим хүчний тухай хуулийн холбогдох зүйл заалттай зөрчилдсөн агуулгатай, давхардсан агуулгатай энэ зохицуулалтыг дахиж нягтлах шаардлагатай гээд 3, 4 хуудас бараг ийм санал өгчихсөн. 4 нүүр. Тэгээд энэ дээр зөрчилдсөн зүйлүүд бол их байна. Бас давхардсан зүйлүүд их байгаад байгаа юм байна.

Тэгэхээр 1-д энэ Эрчим хүчнийхээ суурь хуультай, Засгийн газраас бас энэ суурь багц хуулийг боловсруулаад зэрэгцээд явж байгаа гэж ойлгосон. Үүнтэйгээ хэрхэн уялдуулж авч явах вэ. Эхлээд энэ суурь хуулиа явуулаад, араас нь Дулаан хангамжийн хуулиа явуулах нь зөв юм биш үү гэдэг асуулт байна.

2-т тоолуурын зохицуулалт орж ирж байгаа. Тоолуурын зохицуулалттай холбоотой энэ түрүүн ажлын хэсгээс хариулж байх шиг байна. Нэг өрхөд тоолуур шинэчлэхэд ойролцоогоор 1 сая төгрөгийн зардал гаргана гэж байна. Тэгээд бүгд тоолуур луу шилжих ёстой. 320 орчим тэрбум төгрөг хэрэгтэй гэж байна. Тэгэхээр энийгээ 1 сая төгрөгийнхөө тоолуурыг төлж чадахгүй айл өрх зөндөө бий шүү дээ. Ахмадууд, эмзэг бүлгийнхэн гээд энэ дээр яаж шийдэх юм бэ. Тэгээд цаашдаа огт

задгай тарифаар төлбөр тооцоо авахгүй, үүгээрээ зогсож байгаа гэж байна. Тэгэхээр энэ эмзэг бүлгээ эргээд төлбөрийн дарамтад, дулааны төлбөрийн дарамтад ийм хүнд байдалд оруулах ийм зүйл үүсэж байгаа юм биш үү гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

2-т тоолуур шинэчиллээ гэхэд энэ хуучин орон сууцууд дээр бол дулааны тоолуурыг шинэчлэх техникийн бололцоо нь өөрөө хязгаарлагдмал гээд байгаа шүү дээ. Бүрэн шинэчлэх боломжгүй гээд байгаа юм. Энэ ингээд тэгш бус байдал үүсээд маргаан гарах 1 үндэслэл болох уу. Шугам сүлжээнүүдийг нь хүртэл шинэчлэх шаардлагатай. Ганцхан тоолуур биш. Одоо гаднаас орж ирж байгаа үндсэн дулааны шугам сүлжээ, барилга дотор дамжуулж байгаа дулааны шугам сүлжээ, паарны радиатор гээд эд нарыг шинэчлэх ийм нөхцөлүүд үүсэх юм биш үү. Энэ дээр ямар зардал мөнгө гарахаар тооцож байгаа вэ. Ямар хугацаанд хэрхэн хийх вэ.

3-д энэ тариф төлбөртэй холбоотой асуудал дээр ер нь бодит өртөгт нь тулгуурлаад тарифаа хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр бага орлоготой иргэд, өрх, өндөр настан гээд эд нарт яг энэ зорилтот бүлгийн тарифын огцом өсөлтөөс хэрхэн хамгаалахаар тооцож байгаа юм. Дэмжлэгийг нь ямар эх үүсвэрээс олгохоор тооцож байгаа вэ гэдэг 3 дахь асуулт байна.

4-д ер нь энэ Засгийн газраас өгсөн санал дээр ч гэсэн тавьчихсан байна лээ. 2 дугаар бүлэг дээр нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт татаасаас бол төрөөс үзүүлэх дэмжлэг бол нэлээд их орж ирж байна. Төрийн оролцоо нэмэгдэх нь гээд. Тэгээд энэ дээр татаас, тарифын зөрүү, төр, хувийн хэвшлийн түншлэлийн урт хугацааны төлбөрөөс төсөвт үүсэх ачааллыг юу гэж харж байгаа вэ. Ямар хэмжээний ачаалал үүсэх вэ. Тэгээд энэ татаасыг ямар шалгуураар, ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх вэ. Үүний үр дүнг хэрхэн олон нийт ил тод тайлагнах вэ гээд ийм 4 дэх асуулт байна.

Тэгээд хариултаа аваад, тэгээд тодруулъя.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Эрчим хүчний тухай ерөнхий хууль нь түрүүлж яваад, дараа нь Дулааны хууль явах юм биш үү гэсэн асуултад хариулъя. Тэгэхээр энэ хуулийг боловсруулах дээр энийг маш их ярилцсан. Өөрөөр хэлбэл одоо дулаан, цахилгаан хангамж гэдгийг 1 ерөнхий товчхон хуулиар зохицуулдаг. Дээрээс нь энэ хууль дээр дулаантай холбоотой зохицуулалт 5 хувь байдаг. 5 хувь. Харж байгаа биз. Тэгээд дулааны салбарт зохицуулаагүй харилцаа асар өндөр байдаг. Маш их байдаг. Тийм ч учраас ингээд цоо шинээр хууль боловсруулж орж ирж байгаа. Тэгээд ЭХЯ-аас бол дулаан хангамжийн бие даасан хуультай болохыг бол бүрэн дэмжиж байгаа гээд саяын тэр давхардсан, ингээд зөрчилдөж байгаа юм биш үү гэсэн асуулт, саналууд бүгд дээр нь бид нар тэрний дагуу энэ хуульдаа өөрчлөлтийг оруулаад, өргөн барьсан байгаа. Та бүхэн тэрийг хараарай. Жишээлбэл, одоо ингэж байгаа. Эрчим хүчний тухай хууль дээр чинь тоолуур гэсэн заалт байна шүү дээ. Дулааны хууль дээр чинь тоолуур байна. Энэ чинь давхцаад байгаа юм биш үү гэсэн. Тэгэхээр Эрчим хүчний тухай хууль дээр байгаа тоолуурын асуудал бол цахилгаан хангамжийн тухай тоолуурын асуудал юм. Тэгэхээр нөгөө бас зарим мэргэжлийн юун дээр нөгөө хууль дээр суугаагүй хүмүүс учраас ойлгоогүй ингээд давхардаад

байна, давхцаад байна гэдэг юунууд ирсэн байсан. Тэрийг бид нар бүгдээрээ бас саналын дагуу сайжруулаад, хуулиа өргөн барьсан байгаа.

2 дугаарт Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдахаар дэд ажлын хэсэг бас байгуулагдаад, салбарынхан оролцоод энэ хуулийг цаашлаад сайжруулаад явах бүрэн бололцоо байгаа.

Тоолуурын зохицуулалтын асуудал. 1 айлын тоолуур 1 сая орчим төгрөг байх шиг байна. Одоогийн байдлаар бол дулааны тоолуур нийлүүлдэг компани бараг 4, 5 л байгаа. Яагаад гэвэл угаасаа дулааны тоолуур тавьдаг зах зээл байхгүй. Тэгэхээр ингээд дулааны тоолуурыг тавихаас аргагүй зах зээл нь өргөжөөд эхлэхээр олон тоолуур нийлүүлдэг компаниуд бий болно. Үүний үр дүнд өрсөлдөөн бий болно. Энэ 1 сая төгрөг буурна гэж харж байгаа.

2 дугаарт энэ 1 сая төгрөгийг айлууд өөрсдөө тавихгүй. Дулаан хангах үйлчилгээ үзүүлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компаниуд маань хүнд зарж байгаа дулааныхаа хэмжүүрийг өөрсдөө тавина гэдэг ийм зохицуулалт орж ирсэн байгаа. Гэхдээ хэрэглэгч үнэхээр өөрөө хүсэх юм бол би ийм ид шидтэй, ийм сайхан тоолуур тавимаар байна гээд хүсэх юм бол хэрэглэгч өөрөө тавих нь бол нээлттэй байж байгаа.

Тэр тарифын төлбөртэй, бодит өртөгтэй ингээд ойртоод ирэхээр хэрэглэгчийн үнэ нэмэгдэх юм уу гэж асууж байна. Тэгэхээр энэ хэрэглэгчийн үнэ бодит рүү дөхөхөөр бас хэрэглэгчээ хамгаалах зохицуулалт бол энэ хууль дээр бас тодорхой зохицуулалт болоод орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл тэр төлбөрийн чадвар байхгүй хүмүүсийг хамгаалах гээд зохицуулалт орж ирж байгаа.

Засгийн газрын санал дээр татвар нэлээн өссөн байна гээд. Тэгэхээр бид нар энэ дээр ингээд цоо шинээр хэсэгчилсэн, бие даасан дулаан хангамжийн системийг оруулж ирж байгаа юм. Энэ дээр бол төрийн оролцоо ерөөсөө байхгүй болчхож байгаа юм. Тэр төрийн татаас, тэр үнэ тарифыг зохицуулах асуудал. Энэ хэсэгчилсэн, бие даасан 2 маань нөгөө төвлөрснийг бас сааруулах, тархмал болгох ийм..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минутаар нэмж хариулъя.

М.Энхцэцэг: Зөвхөн төвлөрсөн дулаан хангамжийн хувьд л төрийн оролцоо дамжуулах сүлжээн дээр нь, тэгээд үнэ тарифын хэсэг дээр нь төрийн оролцоо байгаа. Тэгээд тэр үнэ тарифын хэсгийг мэдээж бодит өртөг рүү оруулна. Бодит өртөг рүү оруулахад хугацааг нь хойшлох ч юм уу, хэрэглэгчээ хамгаалах зорилгоор бол хэрвээ төрийн зүгээс бодлого хэрэгжүүлж байгаа бол тэрнийхээ дэмжлэгийг үзүүлээд явна гэдэг ийм л зохицуулалт орж ирсэн байгаа. Тэгээд ажлын хэсгээс нэмж хариулах уу.

Б.Пүрэвдорж: Инженер Эрдэнэчулуун. Индрийн 4 дүгээр микрофон.

Х.Эрдэнэчулуун: Түрүүний нийгмийн эмзэг хэсгийг үнийн дарамтаас яаж хамгаалах вэ гэдэг дээр 9.1.6 дээр ийм журам батлаад, тэрнийхээ дагуу эмзэг хэсгийг хамгаална гэсэн зохицуулалт байгаа гэж хариулъя.

Орон нутагт татаасын асуудал болохоор зэрэг ерөнхийдөө 2 хэлбэрийн татаасын асуудал үүсэж болно гэж зохицуулсан байгаа.

Нэгдүгээрх нь болохоор зэрэг зохицуулах байгууллага бодит өртөгт суурилаад ингээд дулааны эрчим хүчний үнэ тарифыг эцсийн хэрэглэгчийн үнэ тарифыг тогтооход тэр нь нийт ард иргэдэд нэлээд их санхүүгийн ачааллын дарамт үүсгэхээр байх юм бол тэрийг тэр хэрэглэгчийн үнийн зөрүүг татаас хэлбэрээр төсөвт тусгана.

Нөгөөдөх нь болохоор нүүрсний татаасын хэлбэр орон нутагт байж болно гэсэн заалт байгаа. Энэ нь ямар учиртай вэ гэхээр жишээлбэл Архангай, Өвөрхангай аймгууд бол дулааны станцын нүүрсээ бараг 400 гаруй .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганзориг гишүүн тодруулъя.

П.Ганзориг: Би асуусан асуултынхаа 2 дээр тодруулга хүсэж байна.

Нэгд, Эрчим хүчний яг энэ суурь хуультайгаа уялдуулаад зэрэгцээд Засгийн газрын хуультай ингээд явах бололцоо бий юу гэдгийг бас нэгд хууль санаачлагчаас асууя.

2-т тарифын энэ зөрүү үүснэ. Бодит өртөгт хүргэхээр гээд. Хэр хэмжээний ачааллууд ирэх вэ. Одоо тооцож байгаа үнэ тарифаас тоолуур суулгаснаасаа хэдэн хувиар айл өрхийн дулааны төлбөр өсөх вэ. Яг хэдэн хувиар гэдэг тооцоог бас хэлээч.

3-д, сая төгрөгийн дунджаар үнэтэй гэж байна 1 өрхөд тоолуур суулгахад. Төлбөрийг нь бол өрхүүд төлнө, айл өрх төлнө. Энийгээ төлж чадахгүй иргэдийг яах юм. Дулааныг нь хаана, хязгаарлана гэж ойлгож болох уу. Задгай тарифаар тооцохгүй гэхээр тэгж ойлгогдож байгаа. Гэтэл нөгөө иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах Үндсэн хуулиар олгогдсон баталгаа яах юм бэ гэдэг асуудал.

3-д эмзэг бүлэг дээр тарифын татаасны зөрүүг тооцож дэмжлэг үзүүлнэ гэж байна. Энэ дээр төсөв дээр ямар хэмжээний нөлөө үзүүлэх тооцоо байгаа юм. Хэдэн жилийн хугацаанд. Ямар шалгууруар энэ .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Маш нарийн тооцоолол асууж байна шүү. Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Эрчим хүчний суурь хуультайгаа гэж байна. Тэгэхээр ЭХЯ-ны зүгээс бол оруулж ирэх нэн тэргүүний хууль бол юу вэ гэхээр Цахилгаан хангамжийн тухай хууль байгаа. Цахилгаан хангамжийн тухай хууль. Цахилгаан хангамжийн тухай хуулийг боловсруулж, одоо байгаа 1 худалдан авагчийн загварыг өрсөлдөөнт бөөний зах зээл рүү шилжүүлэх ийм хуулийг Эрчим хүчний яам оруулж ирэх ийм хүлээлттэй байгаа. Эрчим хүчний ерөнхий хууль. Одоо Эрчим хүчний тухай хууль маань өөрөө Эрчим хүчний ерөнхий хууль болоод ингээд үлдэх ийм зохицуулалттай байгаа. Тэгэхээр энэ дээр бол суурь хуулиа хүлээгээд бид нар бүхэл бүтэн дулаан хангамжийн асуудлыг зохицуулах нарийвчлалын хуулиа явуулахгүй хэзээ ч оруулж ирэх хуулийг мэдэхгүй ингээд сууж болохгүй гэж харж байгаа.

Бодит өртөгт хүргэхээр хэдэн хувиар өсөх юм бэ. Тэгэхээр одоо бол бодит өртөгт угаасаа хүрэхгүй явж байгаа шүү дээ. ЭХЯ-аас бол энийг бол тасралтгүй л ярьж байгаа. Дулааны үнийг нэмэх ёстой байсан. Тэрийгээ нэмж чадаагүй. Энэ дээр хүлээлттэй байж байгаа гэж байгаа. Энэ тоолуурын асуудал суурилуулахаа .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Бичгээр яг тэр тооцооллуудыг бүгдийг нь өгөөрэй. Тэгэхээр яг энэ орон нутгийн дулаан хангамжийн асуудал бол маш их чухал байдаг. Сумдын ялангуяа. Тэгэхээр энэ жилээс эхлээд дулааны хангамжийн асуудлаар сумуудад 17 тэрбум төгрөгөөр дулаан хангамжийн дэд бүтцийг шийдвэрлэхээр орж ирээд эхэлж байна. Яг ингээд энэ тооцооллоор явах юм бол 330 сумд 17 тэрбумаар энэ хөрөнгө оруулалтыг хийх юм бол 6 орчим их наяд төгрөгийн зардал гарах нь л дээ. Тэгээд энийг чинь өнөөдөр орон нутагт бас шийдвэрлээд яваад байгаа туршлагууд байж байгаа. Яг энэ дулаан хангамжийн талаарх хууль орж ирж байгаатай холбоотой Увс аймгийн Засаг даргын орлогч Сайнбилэгийн Анхбаяр гэдэг залуу над руу залгаж, тэгээд манай Увс аймагт бүх сумдууд бүгдээрээ дулааныхаа асуудлыг концессоор хувийн хэвшилд бүгдийг нь өгсөн. Гэвч улсын төсөвт байгууллагуудын зардал нь урсгал зардал нь өндөр байж байгаад хувийн хэвшилд өгнө өгөнгүүт багасгадаг, улсын дунджаас хэтэрхий бага үнэтэй байлгадаг. Үүнээсээ болоод нөгөө компани, аж ахуйн нэгжүүд нь өртэй болох ийм нөхцөл байдал руу орж байна гэж яриад байна л даа. Тэгэхээр ийм их төсвийн ачаалал авч, сум болгонд дулаан хангамжийн дэд бүтцийг шийдвэрлэж байхын оронд концессоор хийгээд, нөгөө аж ахуйн нэгжүүддээ бас тодорхой хэмжээний татаас тэр урсгал зардлыг нь тогтвортой байлгах, жоохон ахиухан байлгах ийм бодлого энэ хууль дээр чинь яаж орж байгаа юм. Энэ талаар бас яг Эрчим хүчний сайд, ТНБД зэрэг хүмүүсээс заавал асуулт асуух ёстой юм л даа. Гэвч энд зөвхөн Улаанбаатар хотын дулааны байгууллагын хүмүүс ирчхээд суугаад байдаг. Тийм учраас энэ дээр хэлэлцүүлгийн явцад, 2 дугаар хэлэлцүүлэг дээр ийм ийм асуудлууд гарах учраас та нар холбогдох албан тушаалтнуудыг заавал байлгаж хэлэлцүүлгийг хийгээрэй гэж бас хүсэж байна. Одоо Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Хэд хэдэн асуулт байна. Дулаан хангамжийн системд гарч байгаа сүлжээний усны алдагдлыг нөхөх нэмэлт усны хэрэглээг ямар аргачлалаар тооцож, зөвшөөрөгдөх технологийн алдагдал болон хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн алдагдлыг хэрхэн ялгаж салгах вэ. Түүнчлэн нэмэлт усны зардлыг үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч болон хэрэглэгчийн аль тал хариуцахыг хуулийн түвшинд яаж тодорхойлсон бэ гээд 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт болохоор бол дулаан түгээх байгууллага болон хэрэглэгчийн хоорондох шугам сүлжээний өмчлөл, эзэмшлийн зааг, ашиглалтын хариуцлагын зааг ялгаатай, зөрүүтэй тогтоогдсон тохиолдолд тухайн хэсэгт гарсан дулааны алдагдал, аваар гэмтэл, засвар үйлчилгээний зардлыг аль тал нь хариуцах юм бэ. Эдгээр заалт заагийг гэрээ, техникийн баримт бичгээр баталгаажуулах нэгдсэн шалгуурыг хуулийн түвшиндээ тусгасан байгаа юу гэсэн ийм 2 асуулт байна.

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Би 2 дахь асуултад хариулъя. 1 дэх асуултад манай ажлын хэсгийн хариулах байх гэж бодож байна. Тэгэхээр дулаан түгээх, хэрэглэгч 2-ын ашиглалт үйлчилгээний зааг гээд маш тодорхой байгаа. Дулааны тоолуурын цэгээр

хязгаарлагдаж байгаа. Тэгээд яг түгээх сүлжээ бол түгээх сүлжээнийхээ шугам тоноглолд үйлчилгээгээ хариуцаад, ашиглалтын бэлэн байдлыг хангаад явах ийм үүрэгтэй байж байгаа. Хэрэглэгчийн дулааны тоноглол гээд байж байгаа. Одоо жишээлбэл орон сууц дотор байгаа дулаан хангамжийн шугам сүлжээнд бол бас үйлчилгээ үзүүлээд явах, гэрээгээр үйлчилгээ үзүүлээд явах эрх нь бол ингээд нээлттэй байж байгаа энэ хууль дээр бас тийм зохицуулалтууд орж ирсэн. Зүгээр өмчлөлийн асуудал бол яг л одоо дулаан түгээх бол өөрийнхөө шугам сүлжээг өмчилнө. Хэрэглэгч бол хэрэглэгчдийнхээ шугам сүлжээг өмчилнө. Гэхдээ бас ийм нийтийн эзэмшлийн шугам сүлжээ гэж бас байгаа. СӨХ нь бас ерөнхий шугам сүлжээг өмчлөөд явахаар ийм бас зохицуулалтууд байж байгаа. Ажлын хэсгээс нэмж хариулах уу.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Инженер Эрдэнэчулуун.

Х.Эрдэнэчулуун: Дулаан хангамжийн гэрээ гэсэн бүлэг зүйл байгаа. Энэ хүрээнд болохоор дулаан хангамжийн гэрээнд оролцогч талууд ямар оролцоотой оролцох юм, юу туссан байх ёстой вэ гэдэг дотор өмчлөл ба эзэмшлийн заагийг дулаан хангамжийн гэрээнд тодорхой заана гэчихсэн байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ өмчлөл эзэмшил хаагуур зааглагдаж байна, тэр хүрээнд ашиглалт, засварын зардал өртгөө хариуцаад явна гэсэн ийм зарчим үйлчилнэ.

Сүлжээний усны алдагдлыг бол сүлжээний усны алдагдал хаана гарч байгаа хэсэг төлнө. Дамжуулах, түгээх сүлжээн дээр гарч байгаа сүлжээний усны алдагдлыг бол тоолууураар дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид хариуцна. Хэрэглэгч дээр бас сүлжээний усыг бас ашиглах, түүнд хадгалагдсан дулааныг ашиглах тохиолдлууд байдаг. Тэрийг болохоор зэрэг хэрэглэгч дээрх тоолууураар тооцож хянаж байна.

Б.Пүрэвдорж: Соронзонболд тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр гол нь яах вэ, тэр нөгөө зааг нь ингээд зөрүүтэй байгаад тэрнээс болоод хариуцлагын асуудал гарах юм бол яах юм бэ л гэж асуусан байхгүй юу. Тэр заагуудыг нь л тогтоохоор л орчихсон байна. Гэтэл яг амьдрал дээр нөгөө өмчлөл, эзэмшил, ашиглалтын зааг чинь аль аль нь зөрүүтэй байх тохиолдол гараад, тэр тохиолдолд үүсэж байгаа хариуцлагыг нь хэн хүлээх юм бэ гэдэг асуулт асуусан байхгүй юу.

Тэгээд яах вэ ерөнхийдөө энэ хуулийг уншаад үзэхээр хууль дээр ерөнхийдөө энэ хуулийн нэр томьёо, зүйл заалтын дугаарлалт, дулаан хангамжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, өмчлөл, ашиглалт тариф, төрийн хяналт шалгалтын зохицуулалтыг нэлээн нарийвчлан боловсруулах, сайжруулах зүйлс байна шүү гэдгийг бол бас хэлмээр байна.

Дээрээс нь Эрчим хүчний зохицуулах хорооны чиг үүрэг дээр болохоор яг Эрчим хүчний зохицуулах хороо чинь өөрөө энэ дулааныхаа эрчим хүчний үнэ тарифын тооцоо, судалгаа хийх, тарифын санал боловсруулах, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хянах, батлах энэ тэр гэсэн чиг үүргийг нь сайн тусгаж өгөхгүй бол эрчим ..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууна.

Ц.Баатархүү: Сайн байцгаана уу. Хууль нөгөө талдаа хөгжлийг ингээд чөдөрлөдөг болж байна л даа. Би энэ хуулийг яг шүүмжлэх гээгүй. Тэгээд 1 асуудлыг ингээд цогцоор нь оруулж ирэх, энэ хэлэлцэх асуудлын дараалалд бас Их Хурлын удирдлага, Засгийн газар анхаармаар байна.

Монголд одоо 900 гаруй хууль байна. Иргэдийн ажил амьдралыг яг зохицуулж байгаа нь хэд юм, дөнгө тушаа болж байгаа нь хэд юм бэ гэдэг анализ хийх хэрэг байгаад байгаа юм. Тэгээд нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, эрчим хүчний суурь хууль, энэ дулааны хууль, энэ ус цахилгаантай холбоотой бүх асуудлаа ингээд нэг дор уялдаатай шийдчихвэл дараагийн хөгжил дэвшилд хэрэг болох юм болов уу гэсэн ийм саналыг бас хэлмээр байна.

Ер нь Монгол Улсын хууль яаж хэрэгжиж байгаа юм бэ гэдгийн хамгийн энгийн жишээ бол иргэддээ үнэгүй газар олгох асуудал байдаг. Нийт хүн амын ерөөсөө 20 хувь буюу 10 хүний 2 нь л газраа өмчилж авсан байна. 8 нь бол аваагүй. Тэгээд иргэд нь ингээд газраа авъя гэхээр өгдөггүй. Гэтэл уулын аманд ам болгоныг нь хашаад, ингээд газар өгөөд, үүнд нь дулааны зөвшөөрлийг, эрчим хүчний зөвшөөрлийг, усны зөвшөөрөл өгчихсөн байдаг. Отог нэрээр ингээд тусгай хамгаалалтын бүсэд майхан барина гэж зөвшөөрөл авчхаад орон сууцын хороолол бариад зарж байгаа шүү дээ. Тэгээд 10 иргэн тутмын 8-ынх газрыг өгдөггүй. Тэгэхээр юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ хуулийн чинь хамгийн том цоорхой нь барилга буюу барилгын зөвшөөрөл байхгүй, газрын зөвшөөрлөө аваагүй тэр үл хөдлөх хөрөнгөд дулааны зөвшөөрлийг өгч болох заалт орчихсон байна. Энэ бол Улаанбаатар хотыг тойрсон ногоон бүсэд хууль зөрчин баригдаж байгаа тэр үл хөдлөх хөрөнгүүдэд, иргэдийн хууль ёсоороо 1 удаа үнэгүй авах тэр 0,07 га газрыг булааж авсан, мэдээлэлд ойр хүмүүс, Байгаль орчны яаманд ойр хүмүүсийн тэр газар дээр дулаан өгнө гэсэн утга агуулга бас байгаад байна. Энэ асуудлаа анхаарч үзсэн юм уу гэдэг 1 ийм асуулт байгаад байгаа юм.

2 дугаарт нь нийслэл Улаанбаатар хотын 171 мянган өрх айл Үндсэн хуулиар олгогдсон инженерийн дэд бүтэцгүй газар амьдарч байна. Гэр хорооллын бүсэд хэсэгчилсэн болон төвлөрсөн дулаан хангамжийг шийдэх тухай заалт тодорхой биш байна. Энэ асуудалд 1 тодорхой хариулт өгөөч.

3 дугаарт нь одоо болтол энэ аж ахуйн нэгжүүдийг зовоож байгаа, авлига нэхэж байгаа газар чинь хаана юм бэ гэхээр энэ дулааныхан, эрчим хүчнийхэн, усныхан, барилга барих зөвшөөрөл өгдөг тэр барилгын ерөнхий төлөвлөлтийн газрынхан байгаа шүү дээ. 4 газраас ижилхэн зөвшөөрлийг авч байгаа шүү дээ. Дулаан дээр очно, ус суваг дээр очно, хотын ерөнхий төлөвлөгөө дээр очно, эрчим хүчин дээр очно шүү дээ. Энийг иргэддээ, хувийн хэвшилдээ 1 цонхоор олгох энэ боломжийг нэгмөсөн шийдэх ёстой байтал одоо энэ хуулиар бол ингээд 14 хоногт дулааны зөвшөөрлөө өгөөд нөгөө эрчим хүч, нөгөө ус, нөгөө барилга барих зөвшөөрөл чинь дахиад ингээд үлдэж байгаа байхгүй юу. Тэгэхээр Засгийн газар чинь бид нар Зөвшөөрлийн хууль дээр ажиллаад, би ажлын хэсгийн дэд даргаар нь ажиллаад энэ зөвшөөрлийг нэгтгэе гэдэг концепц гаргасан шүү дээ. АН-ын бүлэг Эдийн засгийн эрх чөлөөний хууль батлаад энэ зөвшөөрлүүдийг нэгтгээд 1 цонхоор шийддэг болъё гэж байгаа шүү дээ. Төрд байгаа мэдээллийг ингээд иргэн, аж ахуйн нэгж дамжуулж гүйдэг энэ цагийг зогсооё гээд, энэ хуулийг АН-ын бүлэг санаачлаад л батлуулчихсан. Тэгэхээр энийгээ нийцүүлэх боломж байгаа юм уу гэдэг асуудал байгаа.

4 дүгээрт нь энэ 10 аймагт дулааны станц барьсан барих тухай асуудал яригдаад, авлига, албан тушаалын асуудал яригдаж байгаа. Энэ хариуцлагыг нь тооцмоор байна. Энэ асуудал яагаад чимээгүй болов. Энэ дулаан хангамжийн маш чухал төслүүдийг хэлэлцэж байхад салбарын яам, ТНБД нь яагаад ирэхгүй байгаа юм. Яагаад ажлын хэсэг гээд ийм цөөхөн хүн сууж байгаа юм бэ. Энэ мега төсөл гэдэг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр нийслэлд одоо дулаанаар хангагдаж чадахгүй байгаа 171 мянган хэрэглэгчид байна гэж байна. Тэгэхээр энэ хэрэглэгчдийг дулаанаар хангахад төрийн оролцоог бага байлгая. Тийм учраас цаашдаа бол бид нар аль болох тархмал, бие даасан байдлаар дулаан хангамжийн асуудлыг шийдээд явъя. Угаасаа хууль дээр л тусгаагүй л болохоос биш бодит амьдрал дээр тархмал эх үүсвэр тэр сэргээгдэхээр, тэр газрын гүний дулаанаар, тэр дулааны насосоор дулаан хангамжийнхаа асуудлыг шийдээд явж байгаа бодит амьдрал дээр маш их байгаа. Тэгэхээр энийг л бид нар ингээд хууль дээр товч тодорхой болгоод тусгаж өгч байгаа юм.

Авлига нэхэж байна гэж. Ер нь бол энэ хүнд суртал, авлигын гол үүр уурхай чинь юунаас болоод байгаа юм гэхээр ерөөсөө л төрийн оролцоо их байгаагаас болоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулиар бид нар төрийн оролцоог л багасгая. Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлье. Энэ хүнд суртлыг багасгая л гэж байгаа юм.

2 дугаар асуудал нь энэ авлига, хүнд суртал юунаас болоод байна гэхээр оролцогч талууд маань харилцаагаа цагаан дээр маш товч бөгөөд тодорхой бичээгүй, бүрхэг, хачин тодорхойгүй бичсэн журмаар харилцаагаа зохицуулаад байгаа болохоор л энэ хүнд суртлууд нь гараад байна. Яах гээд байгаа нь мэдэгдэхгүй, хүссэн зөвшөөрөлд хариугаа өгчихгүй ингээд суугаад байна. Тийм учраас энэ чинь юм нь тодорхой байж байж зохицуулалтын хувьд тогтвортой болдог юм гэдгээр л энэ хуулийн байдлаар юу яагаад байгаа юм.

Тэр тархмал байдлаар шийдэх дээрээс нь зөвшөөрлийг энэ чинь багасгаад байгаа байхгүй юу. Зөвхөн төвлөрсөн дээр л төр оролцъё. Бусдаар бол тэр хэсэгчилсэн, бие даасан дээр төр ерөөсөө оролцохоо больё гэдэг ийм асуудлыг оруулж өгч байгаа юм.

Тэр 10 аймгийн асуудлын хариуцлагын асуудлыг би мэдээж мэдэхгүй. Мэдээж бид нар бол ингээд л бас л ингээд улс төржөөд, тэр авлига гээд явчихсан. Яг үндсэндээ бол манайх гаднаас зээл авдаг. Зээл авахдаа заавал тэр зээл авсан улсын компаниар хийлгэнэ. Солонгосын компаниар хийлгэнэ. Тэд нарын санал болгосон компаниар хийлгэнэ. Нөгөө компани нь дампуурчихсан. Тэгэхээр бид нар ерөөсөө барьж авч гол зодох юм нь ерөөсөө л ЭХЯ-ны хэдэн хүнийг ингээд барьж авч зоддог. Яг үндсэндээ сая ингээд төрийн байгууллагын хүмүүсийг шалгаад явж байгаа 10 аймгаар гээд л бөөн л сошиал дээр яллаад байсан. Бодит юун дээр тэр нь ерөөсөө тийм хэрэг болохоор асуудал биш байсан шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар бас ойлголтоо маш зөв болгомоор байгаа юм. Дээрээс нь бид нар гаднаас зээл авч байгаа бол заавал тэр улсын тэр хулхи компаниар хийлгэнэ гэдэг энэ

зохицуулалтаа болимоор байгаа байхгүй юу. Бид нар үнэхээр зөв сонгон шалгаруулалтаа хийгээд, дотоодын компаниар хийсэн бол одоо тэр Хөвсгөл дээр гэхэд л 22мвт-ын дулааны станцыг 1 жилийн дотор оруулчихсан байна шүү дээ. Гэтэл одоо энэ 10 аймгийнхан чинь бас л адилхан 20-30мвт-ын дулааны станц байгаад байгаа байхгүй юу. Зөв. Өнөөдөр ингээд ажлын хэсэг байгуулагдахаар тэр салбарын яам, тэр Эрчим хүчний зохицуулах хороо улс төржихгүйгээр энэ салбарынхаа асуудлыг шийдэхийн төлөө бид хэдтэй хамтраад ажиллаад явж байх ёстой байхгүй юу. Тэгэхээр Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад, албан ёсоор дэд ажлын хэсэг байгуулахаар хамтраад ажиллах байх гэж бодож байна. Энэ хүртэл хамтраад ажиллаад яваад ирсэн юм уг нь.

Б.Пүрэвдорж: Тодруулъя. Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Их Хурлын түвшинд, Засгийн газрын түвшинд Монгол Улс 1 зарчимтай болъё гэж бодож байна. Томоохон энэ төслүүдийг дуусгаж байж дараагийнхаа төслийг эхэлдэг болмоор байгаа юм. 10 аймгийн дулааны станцын асуудлыг мухарлах ёстой. 5 дугаар цахилгаан станцаа дуусгаж байж, 6-аа эхэлдэг болмоор байна. 1 ажлаа дуусгаж байж, дараагийн юмаа эхлэхгүй бол нийслэл Улаанбаатар хот шиг болно шүү. Метро 2027 он, BRT төсөл, дүүжин тээвэр, хурдны галт тэрэг, тэнгэрийн тойрог, усан зам энэ байж болох, дэлхий дээр байж болох бүх тээврийн хэрэгслийг зэрэг эхлүүлнэ гэдэг ийм тооцоогүй, судалгаагүй, эдийн засгийн үр ашгийг нь хардаггүй, татвар төлөгчдийн мөнгийг орж ирсэн цаасанд зарцуулах сонирхолтой. Туулын хурдны зам ингээд эхэлчихдэг. Аль нь ч дуусдаггүй. Тэгэхээр Монгол Улс бол эхлүүлсэн төслөө .... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баатархүүгийн шаардаж байгаа ч зөв. Энхцэцэгийн бас хэлээд байгаа ч зөв. Өөрөөр хэлбэл 2016 оны сонгууль, 2020 оны сонгууль, 2024 оны сонгуулиар сонгуулийн зөвлөгөө өгч Пи Ар хийсэн компани энэ зээлийг оруулж ирээд, тэгээд тендерт нь шалгараад, угаасаа хийхгүйгээр дампуурах зорилготой байсан юм. Тэгээд одоо энийгээ буцаагаад Оюутолгойгоос орж ирж байгаа 2 их наяд төгрөгөөр барина гэвэл тэр авлигачин, хулгайч нарын хулгайлсан мөнгийг ард түмэнд очих ёстой тэр мөнгөөр төлөх болчхоод байна. Тийм учраас та Баатархүү гишүүн ээ, яг энэ дээр бас тодорхой яг ийм баримттай зүйл дээр араас нь жоохон яваад, асуудлыг гаргаж ирээрэй гэж би танд үүрэг өгч байна.

Улсын Их Хурлын гишүүд хуулийн төсөлтэй холбоотой асуулт асууж дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр суурьа илэрхийлж үг хэлнэ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн индрийн 1 дүгээр микрофоноос үг хэлнэ. Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг бол дэмжиж байна. Тэгээд тал талын оролцоотой, хуулийг уялдаатай, асуудлуудыг бас яг шийдсэн ийм байдлаар хэлэлцэн батлах ажлыг бас зохион байгуулж болох байх. Ямар ч байсан хэлэлцэх эсэхийг нь гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Би бас хууль санаачлагч. Мэргэжлийн энэ хүмүүсийн хийсэн энэ хуулиуд бол маш чухал олон зүйлүүдийг тусгаж бас орж ирж байгаа юм.

Тэгээд яг энэ хуулийг боловсруулах ажил бол жишээ нь Эстони, Казахстан, Дани зэрэг яг энэ байгаль цаг уурын хувьд бас бидэнтэй төстэй, хүйтний улиралтай ийм бас улс орнуудын туршлагыг судалснаараа бас энэ туршлагуудыг нутагшуулахад бас нэлээн дөхөм байх болов уу гэдэг зүйлийг би бас энэ ташрамд хэлмээр байна.

2 дугаарт энэ дулаан хангамжийн асуудлыг 400 орчим хуулиар уялдаагүй, иргэд энэ процедурыг дагах боломжгүй байдалтай, бараг л ойлгомжгүй байгааг засаж залруулж энэ хууль маань өөрөө материаллаг хэм хэмжээгээ агуулахаасаа гадна процессын хэмжээгээ агуулж энэ үйл ажиллагаануудыг яг хуулийн хүрээнд зохицуулъя. Иргэдэд энэ нь өөрөө эргээд ойлгомжтой бөгөөд цаана нь процессын тодорхойгүй байдлаас авлига, хүнд суртлын асуудлыг бол цэгцэлье гэдэг энэ мессежийг бас энэ хууль маань бас өгч байгаа. Тийм учраас та бүгдийг бас дэмжиж өгч байна.

Дээрээс нь энэ дулаан хангамжийг үнэ тогтоохоос эхлээд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах энэ чиглэл рүү нь бас сайн зохицуулалтууд бас орж өгсөн байж байгаа. Одоо бол үнэндээ хэлэхэд хэрэглэгч хаашаа хандахаа мэдэхгүй, гэрээн дээр тэгээд л зурж байгаа шүү дээ. Тэгээд нөгөө талдаа бас хэрэглээгээ тохируулах асуудал дээр хүртэл оролцох боломж нь бас ойлгомжгүй байгаа. Тэгэхээр энэ зэрэг асуудлууд ингээд цаашдаа шийдэгдээд явж байна. Хамгийн чухал асуудал юу вэ гэхээр орон нутгийн оролцоо, хувийн хэвшлийн оролцоо байгаа. Түрүүн Соронзонболд гишүүн маань ярьж байна. Энэ дулааны хангамжийн асуудал дээр яг энэ газар доорх шугам сүлжээний өмчлөлийн асуудал, хэн хариуцах нь тодорхойгүй. Шинээр бариад яг юу гэдэг юм ашиглалтад байгаа энэ хугацаандаа болохоороо тавиулсан компани нь энийгээ зарж бусдадаа ашиглана, ашиглуулахгүй, холбоно, холбуулахгүй гэдэг байдлаар явдаг. Ашиглалтын хугацаа дуусаад ирэхэд тэр орон нутаг болон төр лүү шилжүүлдэг. Засвар, үйлчилгээгээ хаядаг. Тэгэхээр ийм зүйлүүдийг цаашдаа бас энэ асуудал маань тодорхой өмчийн асуудлыг шийдэж өгөх гэж байна. Тийм учраас дэмжих нь зүйтэй байгаа юм.

Тэгээд мэдээж хэсэгчилсэн, тархмал, бие даасыг нь эх үүсвэрүүдийн олон төрөлт байдлыг оруулж ирж байна. Цаашдаа бид нар энэ газрын гүний дулааныг ашиглах нөхцөл байдлыг ч гэсэн энэ хууль маань дэмжиж орж ирж байгаа.

Тэгээд хамгийн суурь асуудал болсон утааны асуудал байгаа. Яг эцсийн дүнд утаа гэдэг зүйл бол дулаан, цахилгааны эх үүсвэрийн асуудал шүү дээ. Бид хэд энэ өвөлжихдөө дулаахан байх ёстой. Энэ хүрээндээ л бид хэд энэ дулаан хангамжийн асуудлыг хүртээмжтэй, яг тэр хэрэглэгчид нь хүргэж өгч чадахгүй байгаа учраас л энэ утаа, энийг дагасан маш олон нийгмийн асуудлууд үүсэж байгаа. Энэ утааны асуудлыг энэ хууль маань шийдэх бас нэг шийдэл, гол хөшүүрэг нь байх юм. Дээрээс нь иргэдийн хамгийн анхдагч хэрэгцээ болсон гэр хорооллын иргэд аятай тухтай буюу амины орон сууцдаа амьдрах, зарим төлөвлөлтөд орж байгаа орон сууцжуулах бодлогыг дэмжих. Одоо яг үнэндээ хэлэхэд Улаанбаатар хотод баригдсан орон сууцуудыг л бас бид хэд яриад байгаа болохоос цаашдаа орон сууц барих бололцоогүй болчхоод байна шүү дээ. Дулаан хангамжийн эх үүсвэр байхгүй. Тэгээд үүний цаана эх үүсвэрийн хүртээмжгүй бөгөөд ийм хомсдолтой байдал гэдэг бол авлига гэсэн үг. Энэ дээр эрх мэдэлтэй болоод, танил талтай хүмүүс л энэ асуудлыг шийдэж байгаа. Тийм учраас энэ хуулийг бас цаг алдалгүй тал талаас нь

хэлэлцээд, дэмжиж өгөхийг хүсэж байна. Тэгээд хэлэлцэхийг дэмжиж байна. Тэгээд маш олон .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Отгоны Саранчулуун гишүүн. Индрийн 1 дүгээр микрофоноос үг хэлнэ.

О.Саранчулуун: Хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байна. Яагаад гэхээр хэрэглэгчийн тухай заалтууд болон агуулгын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн эмзэг бүлэгт алсдаа хэрэгтэй, тэд нар өөрсдөө хэрэглээгээ хянах, зохицуулах агуулгууд тусгачихсан байгаа гэдэг утгаараа маш ээлтэй харагдаж байна. Гэхдээ дулааныг тоолууураар хэмжиж хянах, өөрсдөө шийдвэр гаргахтай холбоотой зохицуулалтаар бид нар хүртээмжийг ярих хэрэгтэй байгаа. Тэр очиж байгаа мэдээлэл нь иргэн хэрэглэгч өөрөө хэрхэн мэдээллээ хүртээмжтэй авах, хэрхэн ойлгомжтой авах гэдэг энэ хялбаршуулсан асуудлыг бид нар илүү журмаараа байдаг юм уу, дагалдаж хэрэгжүүлэх тэр бүх хэсэг дээрээ анхаарч, мартахгүй орхих хэрэгтэй байгаа.

Би яагаад энийг хэлж байгаа вэ гэхээр өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүн, Монголд байгаа нийт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний 10 хүн тутмын 2,5 нь бол орон сууцанд, үлдсэн нь бол хашаа байшин, гэр гэх зэрэг орон сууцад амьдарч байгаа. Тэгэхээр тэр хүмүүсийн хувьд бол дулаан амьдрах, амьжиргаагаа залгуулах, амь зогоох төдийд жижигхэн хэмжээний тэтгэлэг, мөнгийг улсаас горьдож, хүлээж амьдарч байгаа. Тэгэхдээ энэ нь тэд нар зүгээр суугаад байгаа гэсэн үг ерөөсөө биш. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж байгаа асуудал бол үнэндээ энэ орчны физик бэрхшээлүүд байна. Бодит хүртээмжүүд нь саадтай байгаад байна. Орон сууц амьдарч байгаа бүх нийтийн сууцууд хүртээмжгүй байгаатай холбоотой дулаан алдагдал бас ихтэй байдаг. Тэгээд энийгээ буцаагаад нөхөөд авъя гэхээр түүнтэй холбоотой бүх үйлчилгээнүүд эргээд хөгжлийн бэрхшээлтэй хүн авах боломжгүй өндөр босготой, хүртээмжгүй ийм асуудлууд байдаг учраас энэхүү хууль, энэхүү хуулийг дагалдан гаргах бусад хуулийн заалтууд, дүрэм журмууд дээрээ энэ дулаан, тог цахилгаантай холбоотой дэд бүтцийн асуудлууд дээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг битгий мартаач ээ. Хүртээмжийн асуудлыг битгий орхигдуулаач ээ гэдэг энэ санаагаа бас өнөөдөр давхар дуулгаж хэлж байгаа юм.

Өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст түлээ нүүрсний хөнгөлөлт гэдэг асуудал байдаг. Гэхдээ тэрний хэмжээ өнөөдөр маш бага, хүрэлцдэггүй. 140 мянган төгрөгөөр ер нь хэдэн шуудай нүүрс, түлээний асуудал авах вэ. Тэгэхээр энэ дээр жишээлбэл ямар өөрчлөлт шинэчлэлт хийсэн юм бэ гээд судлаад үзэхлээр тэр түлээ, нүүрсний мөнгөн хэмжээг ваучер болгоно гэдэг ийм өөрчлөлтийг халамжийн хуулиас харсан. Тэгэхээр Нийгмийн халамжийн хуульд тусгаж байгаа үзэл баримтлал болон дулаан, тог цахилгааны дэд бүтэцтэй холбоотой хуулиуд хоорондын уялдаа холбоо өнөөдөр хангалтгүй, ойлгомжгүй байгаад байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой асуудлыг хууль санаачлагч нар анхааралдаа авч сайжруулах хэрэгтэй байна. Маш олон иргэд энэ дээр санал гомдлоо өгөх эрхийг нь бас нээх хэрэгтэй байна. Мэдээллийг нь илүү ойлгомжтой болгож өгөх хэрэгтэй байна. Тэгээд хуулийн төслийг дэмжиж, илүү сайжруулж, илүү хүртээмжтэй болгохыг хүсэж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Саранчулуунд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг 1 хуулийн дараа явуулна. Одоо үүний дараа товчоор хэлбэл Хэлмэгдэгчдийн хуулийн 4 дүгээр хэлэлцүүлэг явна. Энэ бол маш хурдан явчихдаг учраас үг хэлэхгүй, асуулт асуухгүй. Тийм учраас Их Хурлын гишүүдийг чуулганыхаа танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна.

15.24 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн байна.

Байнгын хороо 2026 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд хуулийн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлсэн гишүүн гараагүй болно.

Б.Пүрэвдорж: Ахмадуудыг хүлээж байгаарай. Ахмадууд хүлээж байгаарай. Сууж байгаарай. Би танилцуулъя.

С.Одонтуяа: Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1 зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулж, Байнгын хороогоор хэлэлцүүлсэн бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 83,3 хувиар дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Цагаатгах ажлын улсын комиссын даргаар 4 жил маш их идэвхтэй ажилласан Салдангийн Одонтуяа танд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийг танилцуулъя. Чүлтэмсүрэнгийн Цасчихэр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга, Луттөмөрийн Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн алга байна. Мөнхбат гишүүн алга байна. Лодойсамбуу гишүүн асуулт асууна.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай ажлыг зохион байгуулж байгаа, энэ олон жилийн турш явж байгаа Одонтуяа гишүүн, энэ хуулийг санаачилж байгаа Пүрэвдорж дарга нарт бас талархал илэрхийлье. Энэ хуулийг бол дэмжиж байгаа.

1937 оноос хойш 2 жилийн хугацаанд энийг бид нар хэлмэгдүүлэлт гэж хэлээд байгаа боловч их хядлага өрнөсөн. Нийт 10 мянга гаруй хүний 70, 80 хувь нь лам нар байсан. Номтой хүмүүс байсан гэсэн үг. Тухайн үеийнхээ эрдэмтэй хүмүүс байсан. 700 гаруй сүм хийдийг устгасан. Ямар шалтгаанаар вэ гэхээр хувьсгалын эсэргүү, гадаадын тагнуул, өөрөөр хэлэх юм бол ардын засгийн эсрэг шүүмж хэлж байсан, ардын засгийг шүүмжилж байсан хүмүүсийг хоморголон устгасан. Одоо араас нь бид нар цагаатгах, нэр төрийг нь сэргээх, нөхөх олговор олгох тухай энэ олон жил ярьж байгаа. Олгож байгаа. Одоо хүрээ хязгаараас гадна үлдсэн хүмүүсийг бас энд хамруулъя гэдэг хууль орж ирж байгаа. Яагаад ч нөхөгдөхгүй зүйл бол хүний амь нас. Хэзээ ч нөхөгдөхгүй. Ямар ч нөхөн олговор хүний амь насыг оруулахгүй. Хүний нэр төр, алдар хүнд.

Энэ ардын засгийг шүүмжилсэн хүмүүсийг хэлмэгдүүлдэг хэлмэгдүүлэлт 2026 оны байдлаар зогсоогүй байгаа. Яг одоо үргэлжилж байгаа. Хувьсгалын эсэргүү гэж хэлээгүй ч хувьсгалын эсэргүү гэдэг байдлаар бүгдэд хандаж байгаа. Засгийн газрыг шүүмжилсэн, Ерөнхий сайдыг шүүмжилсэн, Ерөнхий сайдыг огцруулна гэж хэлснийх нь төлөө хуулийн байгууллага хэрхэн ажилладаг вэ гэдгийг би өөрөө биеэрээ туулсан хүмүүсийн 1.

Өнгөрсөн хугацаанд хувьсгалын эсэргүү болсон хэвлэл мэдээллийн байгууллагынхан, бизнес эрхлэгчид хэдэн 10, 100-аараа байгаа. Одоо хэлж чаддаггүй ч гэсэн манай бизнес эрхлэгч мэдэж байгаа. Засгийн газар гадаа хүмүүс жагсаал цуглаан хийгээд, Засгийн газрыг эсэргүүцэхэд бизнесийн байгууллагыг хардаж, бизнесийн байгууллагыг сэрдэж, компанийнх нь нэр усыг дурдаж, татварын байгууллага шалгалт оруулдаг ийм улс төрийн дохио зангаагаар ажилладаг ийм баримт жишээнүүдийг бид нар олон үзсэн. Өнөөдөр 1 сэтгүүлч шоронд байгаа. 1 философич бас шоронд байгаа. Заавал шоронд хийж шалгадаг, заавал шоронд хийж хэргийг нь мөрддөг энэ бол бүр сүүлдээ улс төрийн хэрэгсэл болоод хоногшсон. Энэ хилс хэрэг байвал яах вэ гэдэг асуудал ардаас нь үүснэ.

Тэгэхээр цаашид улс төрийн хилс хэрэгт ингээд 30, 30 хоногоор гэсээр байгаад хэдэн сар хоригдчихсон зөндөө олон хүмүүс байгаа. Тэр хүмүүс 30, 30 хоногоор хоригдож хоригдчихоод гарч ирэхэд нь хэрэг нь хэрэгсэхгүй болдог, хэрэг нь хаагддаг, эс үгүй бол гэм буруугүй нь тогтоогддог. Тэр олон хүмүүс шоронд олон сар хоригдчихоод хилсээр хоригдсон болж хувирдаг, хилсдүүлдэг энэ байдал зогсоогүй байгаа.

Цаашид зөвхөн 1990 оноос өмнөх гэлтгүй өнөөдрийг хүртэл энэ хилс хэргээр хохирсон байж болзошгүй, улс төрийн хилс хэрэгт орсон байж болзошгүй хүмүүсийн талаар хууль санаачлагчид ямар бодолтой байдаг вэ гэдгийг асуугаад, тодруулъя.

Б.Пүрэвдорж: Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай энэ хууль 1998 онд батлагдсан. Нийтдээ 31.695 хүнийг цагаатгаж, 20220 хүнд нөхөн олговор олгосон байгаа. 2023 онд Одонтуяа гишүүн хууль санаачилж, эдгээр иргэд гомдол гаргах энэ эрхийг нь нээж өгсөн. Харин нэхэмжлэл гаргах эрх нь бол 2020 оны 12 сарын 31-ээр дуусчихсан байсан юм. Одоогийн байдлаар 43 хүн энэ хуулийн хугацаа нээлттэй болох юм бол 43 хүн нэхэмжлэл гаргаж, энэ нухан олговор авах тухай асуудлаа шийдвэрлэнэ. Тэгээд энэ асуудлыг шийдвэрлэсний дараагаар мэдээж дахиад өөр хүмүүс нэхэмжлэл гаргах юм нь бас шинэ нөхцөл байдал илэрвэл нэхэмжлэл гаргах эрх нь нээгдэж байгаа.

Тэгээд үүний дараагаар бидний хийх ёстой бас 1 чухал ажил бол нийтдээ 770 гаруй сураггүй алга болсон, өөрөөр хэлбэл гэрийнх нь гаднаас баривчлаад аваад явсан, тэгээд яасан нь мэдэгдэхгүй, сураггүй алга болсон 770 хүнийг цагаатгах энэ асуудлыг шийдвэрлэнэ. Үүний дараагаар бүлгээр нь хэлмэгдүүлсэн 17 бүлэг хэлмэгдүүлэлт байдаг. Жишээ нь, Лхүмбийн хэрэг гэхэд Лхүмбэ гэдэг хүнийг нь цагаатгачхаад, үлдсэн дагаж явсан тэр хүмүүсийг нь цагаатгаагүй орхичихсон ийм тохиолдлууд байгаа. Тийм учраас нийтдээ 16 мянга гаруй энэ бүлгээр нь хэлмэгдсэн хүмүүс үлдчихсэн байгаа. Энэ хүмүүсийг цагаатгах ажлыг бас хийнэ.

Ингэсний үр дүнд ер нь бол энэ 1990 он хүртэл хэлмэгдсэн тэр бүх хүмүүсийн асуудлыг шийдвэрлэж дуусна. Үүний дараагаар ер нь бол цаашдаа энэ хэлмэгдэл гарах ёсгүй гэж, үүнийг олон нийтэд, ялангуяа ирээдүй болсон бидний үр хүүхдүүд ирээдүйд сануулах зорилгоор цагаатгах ажлын улсын комиссыг Үндэсний ой санамжийн газар болгох ийм зорилготой ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээндээ маш их олон ажлууд хийгдэх ёстой. Энэ ТЕГ-ын архивыг цахимжуулах, мөн түүнчлэн ЦЕГ-ын харьяа байгаа 16.700 орчим хүний хувийн архив байгаа. Тэндээс 660 орчим хүн нь яг хэлмэгдсэн гэж тооцогдож байгаа. Энэ хүмүүсийн архивыг цахимжуулах олон олон ажлуудыг хийх ёстой. Энэ дээр бас төр тодорхой хөрөнгө гаргаж ажиллах

ёстой. Ингэж явж байж бид бүхэн цаашдаа энэ хэлмэгдлийн хар шуурга Монголд дахин бүү тусаж, Монголын ард иргэд энх тунх, эв нэгдэлтэй байх ийм сайхан боломж нээгдэнэ гэж харж байгаа. Нэмж тодруулъя.

Ч.Лодойсамбуу: Тэгэхээр үүнээс хойш цаашдаа улс төрийн хилс хэрэгт холбогдсон хилс хэргийн хохирогч болсон, хэлмэгдсэн гэж үзэж байгаа бол нэхэмжлэл гаргах эрхтэй болж байгаа энэ хуулиар. Тэгэхээр Монголын төр цаашдаа хэлмэгдсэн хүмүүсийн нэхэмжлэлд дарагддаг байх вий, болох вий гэдэг үүднээс л би хэлээд байгаа юм. Өнөөдөр төрийн өндөр дээд албан тушаал хашиж байгаа, хууль, шүүхийн байгууллагын толгой дээр сууж байгаа бүх хүмүүст нэг зүйлийг уриалмаар байгаа юм. Бас сануулмаар байгаа юм. Хугацаагүй албан тушаал, хугацаагүй алба гэж хаана ч байхгүй. Илэрдэггүй гэмт хэрэг гэж хаана ч байхгүй. Мөнхөд дарагддаг үнэн гэж хаана ч байхгүй. Тэгэхээр улс төрийн зорилгоор залхаан цээрлүүлдэг, эрүүдэн шүүдэг, хилс хэрэг тохоодог энэ бүхнийгээ зогсоогооч ээ гэж уриалмаар байгаа юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зочин танилцуулаадахъя.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүдийн санал өгөөгүй байна. Одоогийн байдлаар 37 хүн энэ танхимд сууж байна. Яаралтай ирцээ бүрдүүлье. Намын бүлгийн дарга нар, дэд дарга нар яаралтай гишүүдээ дуудъя. Энэ урд талын эгнээнд ганцхан Чойжилсүрэн гишүүн ганцаараа сууж байна. Бусад энэ яг урд талын эгнээнд суудаг хүмүүс ер нь бол хуралдаан дээр байхгүй байгаад байна шүү. Ингэж залуу гишүүддээ муу үлгэр дуурайлал үзүүлэхгүй шүү. Сүхбаатар танхимд хэлэлцүүлэг болж байгаа юм байна. Тэр гишүүдийг наашаа орж ирж саналаа өгчхөөд буцаж ор гэж хэлмээр байна. Үндсэн хууль танхимд бас хэлэлцүүлэг болж байгаа. 2 танхимаас гишүүдээ дуудъя. Ирц бүртгэлийн санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгээрэй.

Одоо Статистикийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Горимын санал гаргаарай. Замира гишүүн горимын санал гаргая.

С.Замира: Сая Дэлгэрсайхан сайдын танилцуулж байгаа асуудлаар гарын үсэг зурах гэж байгаад санал өгч амжсангүй. Тийм учраас саяын саналыг хүчингүй болгоод, дахиж санал хураалт хийж өгнө үү. Үнэнийг хэлж байна шүү дээ.

Б.Пүрэвдорж: Замира гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. 51 гишүүн дэмжиж, 51 хувиар санал дэмжигдлээ.

Дахин уншъя. Статистикийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 54 гишүүн дэмжиж, 54 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 14 хууль байгаа.

2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 58 гишүүн дэмжиж, 58 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 57 гишүүн дэмжиж, 57 хувийн саналаар энэ асуудал дэмжигдлээ.

4.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 58 гишүүн дэмжиж, 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. 61 гишүүн дэмжиж, 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 60 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 61 гишүүн дэмжиж, 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 57 гишүүн дэмжиж, 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 60 гишүүн дэмжиж, 59,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 59 гишүүн дэмжиж, 58,4 хувиар санал дэмжигдлээ.

11.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 60 гишүүн дэмжиж, 59,4 хувиар санал дэмжигдлээ.

12.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 57 гишүүн дэмжиж, 56,4 хувиар санал дэмжигдлээ.

13.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 59 гишүүн дэмжиж, 58,4 хувиар санал дэмжигдлээ.

14.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 59 гишүүн дэмжиж, 58,4 хувиар санал дэмжигдлээ.

15.Статистикийн тухай хууль хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 59 гишүүн дэмжиж, 58,4 хувиар санал дэмжигдлээ.

Статистикийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

15.51 цаг.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтаншагай нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хорооны ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Одоо Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1.Дулаан хангамжийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Чойжилсүрэн гишүүн горимын санал гаргана.

Б.Чойжилсүрэн: Би энэ Дулааны тухай хуулийг дэмжих ёстой байсан. Энэ төхөөрөмж гацаад, санал хураалтад оролцож чадсангүй. Энэ болохгүй байна. Тамгын газрынхныг дуудаач.

Б.Пүрэвдорж: Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Сая Чойжилсүрэн гишүүн бас дахиад болсонгүй. Дахиад горимын санал гарга даа.

Б.Чойжилсүрэн: Төхөөрөмж гацсан учраас саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна.

Б.Пүрэвдорж: Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Горимын санал дэмжигдсэнгүй. Гишүүд ер нь бол энэ хуулийг дэмжихгүй байгаа юм байна.

Тийм учраас Дулаан хангамжийн тухай хууль болон түүнийг дагалдаж орж ирж байгаа хуулиудыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.14-д заасны дагуу санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно. Тогтоолыг баталлаа.

15.56 цаг.

Одоо Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хууль ёсны” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, “буюу” гэснийг “эсхүл” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад бэлдье. Болсон уу. Санал хураалт. Байж байгаарай. Цуцалъя. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

Түрүүний уншиж, танилцуулсан саналын дагуу санал хураалт явуулъя. 61 гишүүн дэмжиж, 60,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. 15.58 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ *Э.СУВД-ЭРДЭНЭ*